

## Өмнөтгөл

Дэлхийн олон улс оронд хэрэгжсэн “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” боловсролын хөтөлбөр манай улсад 2004 оноос эхлэн, Монголын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг, Олон Улсын Улаан Загалмай Хорооны хамтарсан гэрээний дагуу хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөр амжилттай хэрэгжихийн үндэс нь тус улсын ерөнхий боловсролын сургуулийн түүх, нийгмийн ухааны боловсролын стандартад хүмүүнлэгийн эрх зүйн суурь мэдлэг, чадварыг тусган баталгаажуулсан явдал юм. Мөн “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” хичээлийн үндсэн бүлгүүд буюу модулиудыг манай улсын ерөнхий боловсролын тодорхой сургуулиудад туршин заасан. Эдгээрийн үндсэн дээр “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” **Арга зүйн гарын авлага** (багшийн гарын авлага), **Өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөр** (сурагчийн гарын авлага) номуудыг дээр дурдсан хөтөлбөрийн хүрээнд Монголын Улаан Загалмай Нийгэмлэгээс эрхэлж, англи эхээс нь эрх зүйч Ц.Отгонбаатарын орчуулгаар Монголын багш, сурагч та бүхний гэгээн оюунд өргөн толилуулж байна.

“Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” **Арга зүйн гарын авлага** гэсэн багшийн номд “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” хичээлийг заах багш нарын эрхэм зорилго, зорилт, эл хичээлийг сурагчдын хэрэгцээнд тохируулан заах агуулга, арга зүй, хэрэгсэл, үнэлгээ дүгнэлтийг онол, практикийн өндөр түвшинд, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн сургалтын баялаг туршлагад тулгуурлан оновчтой, ойлгомжтой нээн харуулсан нь Монголын багш нар, түүний дотор нийгмийн ухааны багш нарын сургах арга зүй, ур чадварыг гүнзгийрүүлэн баяжуулах нэгэн тулгуур хэрэглэхүүн болно гэдэгт эргэлзэхгүй байна.

“Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” **Өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөр (бүлгүүд)** ном нь 13-18 насны өсвөр үеийнхэнд “Хүмүүнлэгийн төлөв”, “Зэвсэгт мөргөлдөөний хязгаарлалт” “Хуулийн хэрэгжилт”, “Шударга ёсны баталгаа”, “Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь” гэсэн бүлгүүдийг (модулиудыг) судалгааны болон оролцооны аргаар, бусад хичээлтэй холбох аргаар хэрхэн сурахыг ихээхэн сонирхолтой агуулга, хэлбэрээр оновчтой тодорхойлон бичсэн нь монгол хүүхдүүдийн хэрэгцээ, сонирхолыг татна гэж бодож байна. “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” хичээлийг Монголын хот, хөдөөгийн сургуулиудад турших үед ч монгол хүүхдүүд хүний эрхэм чанар - нэр хүнд, амь насыг шаардлагатай нөхцөл байдалд хэрхэн хамгаалах, туслах, хүнлэг, энэрэнгүй зан үйлийг яаж эзэмших, хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг хэрхэн мөрдөхийг хэр сурсанаа өөрсдийн бодит үйлдлийн үр дүн болох санал, сэтгэгдэл, эсээ, шүлэг болон дүрд тоглох, багаар ажиллах арга замаар чин сэтгэлээсээ илэрхийлэн харуулсан нь Олон Улсын Улаан Загалмай Хорооны зөвлөх, сургагч багш нарын талархалыг хүлээж байлаа.

Олон Улсын Улаан Загалмай Хорооноос эрхлэн туурвисан “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” **Арга зүйн гарын авлага**, “Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” **Өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөр (бүлгүүд)** номуудын монгол хэвлэлийг манай багш нар өөрийн улс орны түүхэн уламжлал, орчин цагийн даяаршлийн болон үндэсний онцлог, ХХI зууны Монгол улсын хүүхэд, залуучуудын хүмүүнлэг соёлын хэрэгцээ, чадамжийг харгалzan авах, гээхийн ухаана ар хандаж, сургалтын үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэнэ гэдэгт итгэж байна.

Эрхэм уншигч, хэрэглэгч Та бүхэн эдгээр номуудын орчуулгын талаарх санал, сэтгэгдлээ Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн хаягаар ирүүлэхийг хүсэе.

Монгол эх оронд хүмүүнлэгийн боловсрол  
цэцэглэн хөгжих болтугай.

“Хүмүүнлэгийн эрх зүйг судлах нь” боловсролын  
хөтөлбөрийн менежментийн багийн ахлагч,  
шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор О.Пүрэв

2008.01.12

Оршил

Англи хэлнээс монгол хэлэнд орчуулан хэвлэх ажлыг Монголын Улаан Загалмай нийгэмлэг эрхлэв.

Хаяг:  
Төв Шуудан  
Ш/x 537  
Улаанбаатар 13  
Монгол Улс

## АГУУЛГА

### Оршил ..... 5

Залуусын дуу хоолой: “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг яагаад судлах хэрэгтэй вэ?

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь”

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн агуулга

### Танилцуулга..... 16

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг ямар учраас заах шаардлагатай вэ?

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” гэдэг нь?

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг заах багш буюу хэлэлцүүлгийг удирдан явуулагч таны үүрэг

Багш боловсрол хөтөлбөрийн үндэслэл

Багшийн эрхэм зорилго

Хөтөлбөрийг хэрэгцээндээ тохируулах нь

Дөт арга зам

Сургалтыг үнэлэх

Энэхүү арга зүйн удирдамжийн бүтэц, зохион байгуулалт

### Багш нарт..... 21

1. Хэлэлцүүлэг

2. Брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх

3. “Хялбар бус хариулт”

4. Дилемма ашиглах

5. Дүрд тоглох

6. Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах

7. Бичих ба эргэцүүлэн бодох

8. Ярилцлага

9. Бичил бүлгээр ажиллах

10. Түүх, мэдээ цуглуулах

### Сургалт семинар..... 43

Сургалтууд

Багш боловсролын сургалтын төлөвлөгөө

1. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг сурагчдад танилцуулах

2. Дүрд тоглох: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

3. Дилемматай ажиллах: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма

4 Хүний нэр хүндийг фото зураг ашиглан судлах нь

5. Сурагчдын үзэл бодол: Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндэс
6. Дүрс бичлэг: ”Цэрэг” хүүхдүүд
7. Хэргийн судалгаа: “Ми Лай тосгонд”
8. Бүлгийн ажил: Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь
9. Хувийн туршлагыг ашиглах: ”Төвийг сахих” ба “Шударга” зарчим
10. Сурснаа ашиглах: Залуучуудын төсөл

### **Тайлбар..... 66**

Удирдах хэлэлцүүлэг: Оршил судалгаа

Сурагчдын хариултыг нэгтгэн: Хүмүүнлэгийн үйлс

Хүний нэр хүндийг судлахад фото зураг ашиглах нь

Сурагчдын үзэл бодол: Зэвсэгт мөргөлдөөний үед ямар дүрэм журам хэрэгтэй вэ?

Дүрс бичлэг үзэх: Бэлтгэл ба хэлэлцүүлэг

Сурагчдын илтгэлүүд: “Хэрвээ та дэлхийтэй ярьж чаддагсан бол”

Зарим ухагдахууныг ойлгоход хувийн туршлагаа ашиглах: “Төвийг сахих” ба

“Шударга” зарчмууд

# **Залуусын дуу хоолой “Хүмүүнлэгийн эрхзүйг судлах нь” хичээлийг яагаад судлах хэрэгтэй вэ?**

## **Оршил:**

### **Залуусын дуу хоолой: “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг яагаад судлах хэрэгтэй вэ?**

#### **Чили**

“...Дайны тухай мэдрэмжтэй болох...”  
“...Дэлхийн улс орнуудад юу болж байгааг мэдэх...”  
“...Хүн бүр эдлэвэл зохих эрхээ мэдэж байх ёстой учраас...”  
“...Хүн бүрт хамаатай учраас...”

#### **Жибути**

“..Өсвөр нас гэдэг нь юм үзэж нүд тайлах үе бөгөөд өсвөр насныхан олон улсын  
хүмүүнлэгийн эрх зүйн учир шалтгааныг хүлээж авах чадвар сайн байдаг ... ”  
“...Ирээдүйн төлөө...”

#### **Египет**

“...Хойч үеийнхэн мэдэж авах болно...”  
“...Улс орны эрх ашигт нийцэх учраас... ”  
“...Энэхүү мэдлэгийн ачаар хүмүүс энэрэнгүй нигүүлсэнгүй болж төлөвших учраас... ”  
“...Хэрвээ дайн эхэлвэл энэ хуулийг хэрэглэж болно ...”  
“...Өөрсдийн эдлэх эрх, хариуцах үүргээ мэдэхийн тулд...”

#### **Израйл**

“ ...Хувь хүний хувьд мэдэж байвал чухалд тооцогдох олон юм байна ...”  
“...Дайны хоригдлуудыг тарчлаахыг хориглох хууль байдаг гэдгийг мэдэж авах болно... ”  
“...Өсвөр насныхан бидний өдөр тутмын амьдралд тохиолдох ялимгүй “дайн –  
зөрчилдөөнд” тус дөхөмтэй учраас ...”  
“...Дэлхий ертөнцөд бага ч гэсэн итгэл найдвар үлдэх учраас...”

#### **Малайз**

“...Бид том болоод энэхүү хуулийг дэмжих болно ...”  
“ ...Дайны цагт бид ирээдүйн удирдагчид учраас; Энэ хуулийг бага насандаа л сурахгүй  
бол дайны цагт мэдэх боломжгүй...”

# **Залуусын дуу хоолой “Хүмүүнлэгийн эрхзүйг судлах нь” хичээлийг яагаад судлах хэрэгтэй вэ?**

## **Норвеги**

“...Өмнөх үеийнхэнд тулгарч байсан асуудлууд манай үеийнхэнд ч тулгараах учраас...”

## **Палестины Өөртөө Засах Засаг Захиргаа**

“...Өсвөр үеийнхний хувьд бие хүн, үзэл бодол, ур чадвар болон хандлага нь төлөвшиж байгаа учраас...”

“...Хүн төрөлхтний энх тайвны төлөө хүсэл эрмэлзлийг идэвхжүүлж, дайны төлөө эрмэлзлийг бууруулдаг учраас – Хэрэв багш нар энэ хуулиа хэрэгжүүлэхгүй бол заах ёсгүй...”

“...Энэ насан дээрээ бид олон асуулт асууж, зөв бурууг мэдэхийг хүсдэг учраас...”

“...Өсвөр насыхан том болоод, улс орноо удирдах болно; Залуудаа юм сурч авах нь чулуун дээр сийлэхтэй адил; Тэр нь үүрд үлдэх болно...”

## **Сенегал**

“...Цэргүүд юу хүссэнээ хийх эрхтэй биш шүү гэдгийг мэдэж авах нь маш чухал учраас...”

3 ...Бид маргаашийн насанд хүрэгчид...”

“ ...Хожим бид үр хүүхдүүдээ зааж сургах учраас... ”

## **Тайланд**

” ...Өөрсдийгөө хамгаалахын тулд... ”

“ ...Дайны үед энгийн иргэд ямар эрхтэй байдгийг мэдэхийн тулд... ”

## **“Америкийн Нэгдсэн Улс”**

”... Бид хэзээ нэгэн цагт ийм нөхцөл байдалд орлоо гэхэд юу хийх ёстойгоо мэдэж байх хэрэгтэй учраас...”

“...Юу болоод байна вэ гэдгийг мэдэж буруу зүйлийн эсрэг дуугарч чаддаг байхын тулд...”

Тайлбар: Залуучууд яагаад олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг судлах ёстой вэ гэсэн асуултанд тэдний дурдсан шалтгаануудын заримаас дээр нийтлэв. Эдгээр хариултыг “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” төслийн сорилын хүрээнд “холбогдох газрууд”-аас зохион байгуулсан бүлгийн хэлэлцүүлгийн үеэр цуглуванс болно.

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### ОРШИЛ:

Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт

### БҮЛЭГ 1: ХҮМҮҮНЛЭГИЙН ТӨЛӨВ

Судалгаа 1A: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ? [хүмүүнлэгийн үйлсийн жишээ]

Судалгаа 1B: Хүмүүнлэгийн үйлс [дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой]

Судалгаа 1C: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма [жишээ дилемма]

### БҮЛЭГ 2: ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТ

Судалгаа 2A: Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах

[фото зураг, зургийн эвлүүлэг, үндсэн дүрэм]

Судалгаа 2B: Түүхэн хууль дүрмүүд [дайны тухай хуулиуд]

Судалгаа 2C: “Цэрэг” хүүхдүүд [зургийн эвлүүлэг, дүрс бичлэг, газрын зураг]

Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина [дүрс бичлэг, газрын зураг]

### БҮЛЭГ 3: ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Судалгаа 3A: Зөрчлийг тодорхойлох нь [дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой]

Судалгаа 3B: Байлдагчийн байр сууринаас хараад [жишээ дилемма]

Судалгаа 3C: Хэн хариуцлага хүлээх вэ?

Судалгаа 3D: Хэргийн судалгаа – Ми Лай [дүрс бичлэг ба дүрд тоглох]

### БҮЛЭГ 4: ШУДАРГА ЁСНЫ БАТАЛГАА

Судалгаа 4A: Шударга ёсны суурь шалтгаан [үншлага]

Судалгаа 4B: Олон улсын шүүхийн хувьсал [үншлага]

### БҮЛЭГ 5: ДАЙНЫ ҮР ДАГАВРУУДАД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ НЬ

Судалгаа 5A: Дайны хор хөнөөлөөс үүдэн гарах хэрэгцээ [зургийн эвлүүлэг]

Судалгаа 5B: Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж

Лагерь буюу хоргodoх байр төлөвлөх

Судалгаа 5C: Хоригдлуудыг хамгаалах [дүрс бичлэг]

Судалгаа 5D: Гэр бүлийн холбоог сэргээх [зургийн эвлүүлэг]

Судалгаа 5E: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүй [жишээ дилемма]

### ТӨГСГӨЛ:

Дүгнэлт судалгаа: Цаашид юу хийх хэрэгтэй вэ? [дүрс бичлэг]

ОЙЛГОЛТ, НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

ОЙНГОЛОУУЛЫГ		ҮРЧАДВАРУУЛЫГ	
<p>Хүний нэр хүнд Хүмүүнлэгийн зан үйлд учрах саад тогторууд Дилемма Үр дагавар Олон талт төлөв байдал</p> <p>Хүндэтгэлэгийгээр санал үл нийлэх Үндэслэлтэйээр бусдын санал бодлыг дэмжих Брейнсторминг буюу очоуны дотволгоон хийх Эрх зүйн үндэслэл</p>		<p>Хэлэлцүүлэг Сонсок Хүндэтгэлэгийгээр санал үл нийлэх Үндэслэлтэйээр бусдын санал бодлыг дэмжих Түүхэн үйл явдлыг ярих Дилеммад анализ хийх Асуудлыг тодорхойлох</p> <p>Төлөвшил Дүрд тоглох Түүхэн үйл явдлын анализ хийх Түүхэн үйл явдлыг ярих Шийдвэр гаргах Тэмдэглэл хөглих</p>	

НИЙТ БҮЛГҮҮДЭД			
БҮЛГҮҮД			
БҮЛГЭГ	АСУУЛТ	ОЙЛГОЛТ	СУДАЛГАА
ОРИШИЛ СУДАЛГАА	<p>Зэвсэгт мөргөлдөөний талаар таны төсөөлөл юу вэ?</p> <p>Зэвсэгт мөргөлдөөнөөс Үүдх ганигдл зовлон, хүндрэл бэрхшээлийг хязгаарлах оролцогуудын талаарх таны болол?</p> <p>Хүний нэр хүнд гэж юу вэ?</p>	<p>Зэвсэгт Мөргөлдөөний хязгаарлалт Хүний нэр хүнд Дилемма</p> <p>Төсөөлөл ба ойлголт</p>	<p>◆ Хүмүүнлэгийн эрх зүйн суурь, Үндсэн ойлголтуудын талаар мэдэж байх.</p> <p>◆ Хүмүүнлэгийн эрх зүйг судлах явцад тулгарах зарим асуултуудад хариулахад амаргүй гэдгийг мэдэж байх.</p> <p>◆ Хүний нэр хүндийг урьдчилан тодорхойлох.</p> <p>◆ Хүний нэр хүнд гэж байхгүй. Энэхүү тарын авалын нг зорилго нь ийм асуултуудыг тодорхойж судлахад оршино.</p>

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУУЛТ	ОЙЛГОЛТ	СУДАЛГАА	ЗОРИЛТ	ГОЛ САНАА
					<ul style="list-style-type: none"> <li>◆ “Хөндлөнгөөс ажиллагчид” гэдэг нь хүчирхийлийн үед үл таних хүмүүсийн амь нас, нэр хүндийг хамгаалахын тулд аливаа үйлдэл хийж чаддаг энгийн хүмүүсийг хэлнэ.</li> <li>◆ Хөндлөнгөөс ажиллагчид нь ихэвчлэн өөрт учирч болох хохирол, эрсдэлийг оролцдог.</li> <li>◆ Энгийн хүмүүс хаана ч байсан эмзэт хүмүүсийг хамгаалан хүnlэг бус үйлдлийн эсрэг зогслог.</li> </ul>
БҮЛЭГ 1 Хүмүүнлэгийн төлөв	Хөндлөнгөөс ажиллагч гэдэг нь? Хөндлөнгөөс ажиллагчад ямар дилимма тулгардаг вэ? Хөндлөнгөөс ажиллагчид ямар нөлөө үзүүлж чадах вэ? Хүмүүнлэгийн үйлсийн мөн чанар юу вэ?	1A Хөндлөнгөөс ажиллагчид юу хийж чадах вэ?	Хөндлөнгөөс ажиллагчийн зүтгэлтэн үзүүлж чадах вэ?	<ul style="list-style-type: none"> <li>◆ Хөндлөнгөөс ажиллагчийн зүтгэлтэн үзүүлж чадах вэ?</li> <li>◆ Хүмүүнлэгийн үйлсийн тухай ойлголт.</li> <li>◆ Аливаа хүний амь нас, нэр хүнд эрсдэлтэй үед юу хийх вэ гэдэг талаар нийтгүйн зүтгэс учуруулах дарамт нөлөөллийг ойлгох.</li> <li>◆ Мэдээ, мэдээлэл болон өдөр тутмын амьдрал дахь хүмүүнлэгийн үйлсийг ялган таних чадвартай болох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ “Хүмүүнлэгийн үйлс” гэдэг нь ихэвчлэн ердийн нөхцөлд хамгаалаад байлагч, амь нас, нэр хүндэд нь аюул тулгарсан хүмүүсийг хамгаалахаар хийгдэж буй үйлдлийг хэнэ. Ихэнх тохиолдолд эрсдэлтэй байдаг.</li> <li>◆ Хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилго бүхий хүмүүнлэгийн үйлс нь зарим нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан бэрхшээлтэй учирдаг.</li> <li>◆ Ихэнх хүмүүнлэгийн үйлсийн үед хүн өөрөө эрсдэлц орох, эсвэл өөрт нь буюу хамгаалах гэсэн хүнд нь язз бурийн гарз учирч болзошгүй учир хамгаалах уу, болих уу гэсэн сонголт хийх хэцүү байдалд ордог.</li> <li>◆ Аль ч сонголт нь хамаарах хүмүүст төвөгтэй, удаан хугацаанд үргэлжлэх үр дагаврыг авчирч болно.</li> </ul>
1C	Хөндлөнгөөс ажиллагчийн диллемма				<ul style="list-style-type: none"> <li>◆ Хүний нэр хүндэд аюул учрах Уед байлцсан хөндлөнгөөс ажиллагчад тулгарч болох хүндрэлүүдийг таньж мэдэх.</li> <li>◆ Дилеммад анализ хийж сурх.</li> </ul>

## Хичээлийн агуулга

### ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУУЛТ	ОЙЛОГОТ	СУДАЛГАА	ЗОРИЛТ	ГОЛ САННАА
БҮЛЭГ 2 Зэвсэгт мергөлдөөний хязгаарлалт	Дайны хязгаарлалт Энтийн ирээ,	2A Дайны сурэл, хор хөнөөтийг хязгаарлах	Дайны хязгаарлалт Энтийн ирээ, байлдагч бус хумуус (байлдаанд оролцоогооргүй болсон хумуус) Хүний эрх Хамгалалт Хүүхдүүдийн эрэлт хэрэцээ Үл ялгаварлах зэвсэг Долгионт Үр нөлөө	◆ Зэвсэгт мөргөлдөөнд залшигүй мөрдөлдөх дурмийн зарим шалтгааныг ойлгож авах. ◆ Хүний эрхийн хувь болон хумуунлэгийн эрх зүйн харилсан некхө чанарыг ойлгож авах. ◆ Олон улсын хумуунлэгийн эрх зүйн зарим үндсэн дурмуудийг мэдэж байх.	◆ Хумуунлэгийн эрх зүй нь зэвсэгт мергөлдөөний үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилготой. Энэ нь хэрэгцээгүй зовлон шаналтыг багасгах, түүнчлэн байлдагч булсын хумуусийг хамгаалахын тулд дайны арга, хэрэгслийг хязгаарлах замаар хэрэгжижинэ. ◆ Хумуунлэгийн эрх зүй болон хүний эрхийн хувь аль аль нь хүний амь нас, нэр хүндийг хамгаалах үндсэн зорилготой. Хумуунлэгийн эрх зүй нь зөвхөн зэвсэгт мөргөлдөөн зэрэг тодорхой нөхцөл байдалд Үйлчлэхээр зохиогдсон байdag бол хүний эрхийн хувь нь ямар ч үед хэрэглэдэл.
БҮЛЭГ 2 Зэвсэгт мергөлдөөний хязгаарлалт	Ямар хязгаарлалтууд хэрэгтэй байдаг вэ? Яагад? Эдгээр хязгаарлалтууд хаанаас хийгддэг вэ? Дайныг хязгаарлах хуулиуд хэрхэн бий boldog вэ?	2B Түүхэн хувь дурмууд	Хамгаалалт Хүүхдүүдийн эрэлт хэрэцээ Үл ялгаварлах зэвсэг	◆ Янз бурийн газар нутаг; цаг үед хумуус зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах зорилгоор хувь дурэм боловсруулсаар ирсэн гэдгийг мэдэж авах. ◆ Өмнөх үеийн хуулиудад заасан хорилголт, шаардлагатнын зарим жишээг мэдэж байх. ◆ Хумуунлэгийн хэм хэмжээний хувьсал болон Үйл явдлуудын хорондох харицааг танилцуулах.	◆ Дайны гай зовлонг хязгаарлах гэж өрөөнцийн өнцөг булан бүрт хумуус хичээн зүтгэж байна. ◆ Хэрэгцээгүй зовлон шаналтыг багасгаж, эвдрээл сүйрлийг хязгаарлахын тулд хүч хэрэглэхийг хорилгосон хувь дурэм байсныг туүх гэрчилдэг.
“Цэрэг” хүүхэд	“Цэрэг” хүүхэд	2C	Хамгаарыг тогтоох шаардлагыг оийлох.	◆ Хүүхдүүдийг байлдагч болгон ашиглаж байгаа практик артын хэм хэмжээ, түүний Үр дагаврын талар мэдэж байх. ◆ Цэрэгт элсүүлэх насыны доод хязгаарыг тогтоох шаардлагыг оийлох.	◆ Зэвсэгт мөргөлдөөний үед хүүхдүүдийг хамгаалах ёстой. Цэрэгт элсүүлэх насын доод хязгаарыг тогтоох нь хамгаалалын нэг хэлбэр юм. ◆ Олон улсын жишгээр насыны доод хязгаар 15 байдаг. “Сайн дүрүн” ч бай, хүчээр ч бай 15-ас дооши насын хүүхдүүдийг цэрэгт элсүүлэх нь дайны гэмт хэрэг юм. ◆ Олон улс даяар одоогийн байдаар насыны доод хязгаарыг өсгөн 18 болгоохор хүчин чармайж байна.

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУҮЛТ	ОЙЛГОЛТ	СУДАЛГАА	ЗОРИЛТ	ГОЛ САНАА
БҮЛЭГ 2 Зэвсэгт мөргөнцөөний хягаарлалт (урзэлжээл)	2D Хүний эсрэг газрын мина	◆ Ул ялгаварлах бөгөөд хэрэгцээгүй зовлон шаналал учруулдаг тодорхой төрлийн зэвсүүдийг ямар ураас хориглодийг ойллох.  ◆ Газрын минийг хэрэглэсэнээр гарах үр дагаврыг (“долгионт үр нэлбө”) илрүүлэх чадвартай байх.  ◆ Олон нийтийн үзэл болдol, тэднийг дайчлах нь хэрхэн хүмүүнлэгийн эрх зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулж болж талаар ойлолтой байх.	◆ Газрын мина, биологийн ба химийн зэвсэг нь байлдатчид болон энгийн иргээдийг Ул ялгаварлах бөгөөд хэрэгцээгүй зовлон шаналал авчирдаг учраас эдгээрийт хориглодог.  ◆ Газрын минаад өргөгсөд эрүүл мэнд, сэлгээ санаагаар хохироод зогсохуй хувь хүмүүс, тэдний гэр бүл, ойр орчныхон, улмаар улс орон болон олон ульын нийгмэлг нийэмж, эдийн засгийн хор уршигийт амсдаг.  ◆ Газрын минийг үйлдвэрлэх, хэрэглэхийг хорилгоо тухай 1997 оны Огтавагийн гэрээ нь олон нийтийг дайчилсны үр дунд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хувьсан хөгжиж болдийн нэг жишээ юм.	◆ Олон ульын хүмүүнлэгийн эрх зүйн дурмууд нь зэвсэгт мөргөлдөөний нохцiol байдалд хэрэглэгдэхээр тусгайлан зохиогдсон байдаг.	
БҮЛЭГ 3 Хуулийн хэрэгжилт	Ихэвчлэн ямар дүрэм зөрчигддэ? Яагаад? Байлдагчид ямар дилгэммагтай тулгардаг вэ? Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн бисэтуулж байгааг хэндэх харгуулжатыг хэн хүлээх вэ?	ЗА Зөрчлийг толорхойлох нь	Хуулийн зөрчил Энгийн иргэн/ байлдагийн ялаа Гинжин нөлөө	◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн зарим зөрчлүүдийг таньж мэдэх чадвартай байх.  ◆ “Гинжин нөлөө” бүхий ҮР дагаврын тухай ойлголыг хэрэгтэн зөрчил зөрчлөө терүүлдгүйг жишигээр танин мэдэх.	◆ Хүмүүнлэгийн эрх зүйн зөрчлүүд нь ихэвчлэн дараа дараагийн зөрчлүүдийн гинжин нөлөөг үүсгэж байдаг.  ◆ Хүмүүс зарим зөрчлүүдэд янз бурийн шалтгаан байдаг гэж үздэг, тухайцбал өшөө авах, хумус одноор суурьшсан газар байдах, энгийн иргэд дайснуудад тушаалтуудын хувуль бус захирамж тушаал зэрэг орно.

## Хичээлийн агуулга

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУУЛТ	ОЙЛГОЛТ	СУДАЛГАА	ЗОРИЛТ	ГОЛ САНАА
3B Байлдагчийн байр сууринеас хараахад			3C Хэн хариуцлага хүлээх вэ?	<ul style="list-style-type: none"> <li>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг дагаж мөрдөх чиг зорилго нь тулалдааны нөхцөл гарч болох дилемма, үр дагваруудыг таньж мэдэх.</li> <li>◆ Энгийн иргэн ба байлдагч этгээдийн ялгаа тодорхой бус үед хүмүүнлэгийн эрх зүйг сахихад гарах бэрхшээлүүдийг таньж мэдэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ Звасгэлт мөргөлдөөний үед олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дурмуудийг дагаж мөрдөхөд янз бүрийн дилемма учирдаг.</li> <li>◆ Энгийн иргэд болон байлдагчыг ялгахад хэдүү учраас олон дилемма үсдэг.</li> <li>◆ Заримдаа хүмүүс энэ ялгааг санаатайгаар бүрхэг болгог бол бусад тохиолдолд хүмүүс суурьшсан газар байдах үед энэ ялгаа нь өөрөө тодорхой бус болдог.</li> </ul>
БҮЛЭГ 3 Хуулийн хэрэгжилт (ургэлжлэл)				<ul style="list-style-type: none"> <li>◆ Эдгээр дурмуудийг сахиж мөрдөж байгаа эсэхийг хянах үргийг шөргийн ямар хүмүүс хүлээндэг талаар ойлголтой байх.</li> <li>◆ Энэ үүрэг хариуцлагыг хэрхэн биелүүлдгүй тодорхойлох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн сахихад олон хүний гүйцэтгэх ёстoy үүрэг хариуцлага гэж бий. Хэдийгээр ганц хүн дэнгаараа хүмүүнлэгийн эрх зүйг зөрчиж чадах боловч, уг эрх зүйг хүндэтгэн сахиж буйг багалгаажулахад засгийн газрын тушмэлүүд, цэргийн удирдагчид, байлдагч зарэг хүмүүсийн хамтын хүчин чармайлт шаардлагатай.</li> <li>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хөхиулэн дэмжих нь алывава ундэстний эрхэм дээд эрх ашигт нийцэ.</li> </ul>
3D Хэргийн судалгаа — Ми Лай:				<ul style="list-style-type: none"> <li>◆ Хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчил тохиолдоход энгийн хүмүүс ямар хариу үйлдэл хийдэг талаар ойлголтой байх.</li> <li>◆ Хүмүүнлэгийн эрх зүйн хэрэгжилт, албадан хэрэглэхэй холбогдсон зарим дилемма, асуудлуудыг ойлжок авах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ Байлдагч хүмүүс эрх зүйн бус тушаалыг биелүүлэх албагүй.</li> <li>◆ Орчин үеийн байланы бодит нохцөл байдал нь хүмүүнлэгийн эрх зүйг хэрэгжүүлэхэд төвөг чуруулж болдог.</li> <li>◆ Хүмүүнлэгийн эрх зүйг зөрийн оөрийн цэргийн хүчиний гишүүдийг шударгаар шуухэд улс орнуудад бэрхшээл тулгарч болдог.</li> </ul>

## Хичээлийн агуулга

### ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУУЛТ	ОЙЛОЛТ	СУДАЛГАА	ЗОРИЛТ	ГОЛ САНАА
БҮЛЭГ 4 Шударга ёсны багалгaa	Хэрэгжилт Албидан хэрэглэх Энгийн иргэн/ байдагчийн ялгаа Эрх зүйн бус захирамж тушаал Ниймийн дарамт Хувь хүний харилцлага Удирдагчийн харилцлага Дайны гэмт хэрэг Шүүхэд оролцох эрх, тавигдах шардлага Яагаад шударга ёс хэрэгтэй байдаг вэ? Шударга ёсонд язж хүрэх вэ?	Хэрэгжилт Албидан хэрэглэх Энгийн иргэн/ байдагчийн ялгаа Эрх зүйн бус захирамж тушаал Ниймийн дарамт Хувь хүний харилцлага Удирдагчийн харилцлага Дайны гэмт хэрэг Шүүхэд оролцох эрх, тавигдах шардлага Яллагдажийн хэн шүүх ёстай вэ?	4A Шударга ёсны суурь шалтган	◆ Хүмүүнлэгийн эрх зүйг зөрчигдийн эсрэг арга хэмжээ авах нь эзвэсэйт мөргөлдөөний дараах нийгмийн сайн сайханд хэрхэн нелөөлж болохыг ойлгож авах.	◆ Хүмүүнлэгийн эрх зүй нь уг хуудийг ноцトイгоор зөрчигч буюу зерничийг тушаасан этгээдийг шударгаар шүүхийг шаарддаг. ◆ Женевийн Конвенцид нээлсэн улс бүр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг түгээн дэлгэрүүлэх, хүндэтгэн сахих, хэрэгжүүлэх үүрэг харилцагаа хүлээдэг.
БҮЛЭГ 5 Дайны Үр дагаврууд хариу Үзүүлэх Нь	Дайны Үр дагаврууд гэж юу вэ? Тэдгээрт хариу Үзүүлэхэд ямар хүчин чармайлж шаардлагдаг вэ? Хүмүүнлэгийн Үйл ажиллагааны явцад ямар дилемма гардаг вэ?	Дайны хор хөнөөл, сүйрэлээс Үүдэн тарах хэрэгцээ Дүрвэлсэд, шилжин нуусэн хүмүүс Төвийг сахих Үзээл Шударга байдал	5A Дайны хор хөнөөл, сүйрэлээс Үүдэн тарах хэрэгцээ Дүрвэлсэд, шилжин нуусэн хүмүүс Төвийг сахих Үзээл Шударга байдал	◆ Дайны гэмт хэрэгжилтэй эрх хэрэгнүүдийг шударгаар цуух гэсэн олон улсын хүчин чармайлтын хувьсал хөгжлийг ойлгох. ◆ Дайны гэмт хэрэгтэй холбоотой зарим асуудалуудыг мэдэж байх.	◆ Дайны гэмт хэрэгжилтэй эрх хэрэгнүүдийг шударгаар цуух гэсэн олон улсын хүчин чармайлтын хувьсал хөгжлийг ойлгох. ◆ Шүүгчид гэм бууруутай тогтоохдоо шүүтдэгч этгээд яллагдаж буй эрх зүйн зөрчийг санаагайгаар Үйлдсэн эсэхийг харгалzan Үздэг. Бусдын тушаалаар Үйлдсэн бууижил төстийг зөрилийн урьдаах жишээ нь хууль зөрчичийг гэм бууруугаас чөлөөлөх шалтгаан болж чадахгүй.
	Дайны Үр дагаврууд гэж юу вэ? Тэдгээрт хариу Үзүүлэхэд ямар хүчин чармайлж шаардлагдаг вэ? Хүмүүнлэгийн Үйл ажиллагааны явцад ямар дилемма гардаг вэ?			◆ Дайн дажин амьдралын сөрдийн хангамжийг хэрхэн алдагдуулдаг талаар оийлж авах. ◆ Зэвсэгт мөргөлдөөн их хэмжээний эд баялагийн хохирол авчирч, амьдралын ердийн хангамжийг алдагдуулдаг. ◆ Зэвсэгт мөргөлдөөний Уед хүний амь нас, нэр хүндэд аюулт учирч, улмаар тустай хамгаалалт хэрэгтэй болдог. ◆ Хүмүүнлэгийн байгууллагууд хамтран ажилласнаар амьдралын сөрдийн хангамжийг нөхөн сэргээж чаддаг.	◆ Зэвсэгт мөргөлдөөн их хэмжээний эд баялагийн хохирол авчирч, амьдралын ердийн хангамжийг алдагдуулдаг. ◆ Зэвсэгт мөргөлдөөний Уед хүний амь нас, нэр хүндэд аюулт учирч, улмаар тустай хамгаалалт хэрэгтэй болдог. ◆ Хүмүүнлэгийн байгууллагууд хамтран ажилласнаар амьдралын сөрдийн хангамжийг нөхөн сэргээж чаддаг.

## Хичээлийн агуулга

### ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУУЛТ	ОЙЛГОЛТ	СУДАЛГАА	ЗОРИЛТ	ГОЛ САННАА
5B			Дайны улмаас шилжин нүүсэн хүмүүст зориулж лагерь буюу хорголож байр төлөвлөх	<ul style="list-style-type: none"> <li>◆ Алоулуй байдал зэрэг шилжин нүүлгээс үүсэх хэрэцээ шаардлагыг хангахад асар их төлөвлөлт, хүчин чармайлт шаардагдаа.</li> <li>◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас шилжин нүүсэн хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангажин чармайлт шаардагдаа.</li> <li>◆ Ус, хүнс, орон байр, эмнэлэгийн тусламж зэрэг зайлигүй биологийн хэрэгцээнээс гадна нийтм, сэтгэл зүйн хэрэгцээг хангах шаардлага гардаг. Эдгээр нь хүний аль болох бие даасан байдлаа даруй сэргээхэд нь туслах зорилготой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас шилжин нүүсэн хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангажин чармайлт шаардагдаа.</li> <li>◆ Ус, хүнс, орон байр, эмнэлэгийн тусламж зэрэг зайлигүй биологийн хэрэгцээнээс гадна нийтм, сэтгэл зүйн хэрэгцээг хангах шаардлага гардаг. Эдгээр нь хүний аль болох бие даасан байдлаа даруй сэргээхэд нь туслах зорилготой.</li> </ul>
5C			Хоригдуудыг хамгаалах нь (ургээлжлэл ийн)	<ul style="list-style-type: none"> <li>◆ Хоригдуудын амь нас, нэр хүндийг хамгаалах хүмүүнлэгийн эрх зүйн зарим аргуудыг мэдэж авах.</li> <li>◆ Хоригдуудыг хамгаалахад хүмүүнлэгийн ажилтнуудад учирдаг зарим диллеммаг ойлгох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ Зэвсэгт мөргөлдөөний уеэр олзогдон, хоридсон хүмүүсийн амь нас, нэр хүнд эсрэлтэй байдаг.</li> <li>◆ Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй хоригдуудыг хамгаалахыг, мөн дээрх хамгаалалтыг баталгаажуулах зорилгоор хүмүүнлэгийн төлөөлжигчid тэднийг широнд эргэж очихыг шаарддаг.</li> <li>◆ Хоригдуудыг эргэж буй хүмүүнлэгийн ажилтнуудад шийдвээд хэнүү диллемма олон тулгардаг.</li> </ul>
5D			БҮЛЭГ 5 Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь (ургээлжлэл ийн)	<ul style="list-style-type: none"> <li>◆ Дайнаас болж тарж бутарсан гэр бүлийнхийн хүнд нөхцөл байдлын талаар мэдэж байх.</li> <li>◆ Дайнаас болж тарж бутарсан гэр бүлийнхийн дахин нэгтгэхэд шаардлагатай хүчин чармайлтын хэм хэмжээний талаар ойлгож авах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>◆ Зэвсэгт мөргөлдөөний улмаас олон тооны хүмүүс гэр бүлийнхийн холбоо барих ямар ч аргачийгээр хагацдаг.</li> <li>◆ Хүмүүнлэгийн эрх зүй нь гарж бутарсан гэр бүлийнхийн дахин нэгтгэх зэрээдэд холбоог сэргээх, хэвээр үздэх үйл ажиллагааг шаарддаг.</li> <li>◆ Гэр бүлийн гишүүдийг олж тогтоон дахин нэгтгэх нь олон үе шатгтай.</li> </ul>

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

## ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

БҮЛЭГ	АСУУЛТ	ОЙЛГОЛТ	СУДАЛГАА	ЗОРИЛГТ	ГОЛ САНАА	
БҮЛЭГ 5 Дайны үр дагавруудад харуу үзүүлэх нь (Үргэлжлэл бий)			5Е Хүмүүнлэгийн Үйл ажиллагааны ёс зүй	◆ Хүмүүнлэгийн Үйл ажиллагааны удирдамж болох “төвийг сахиж, болон “шударга” зэрэг зарим зарчмуудыг мэдэж байх. ◆ Хүмүүнлэгийн ажилтан Үүрэгт ажлаа явуулж байх Үед тулгарах зарим диллеммаг ойлгох.	◆ Хүмүүнлэгийн байгууллагуудад зан Үйлийн зарим төрөлжсөн хууль дүрэм шаардлагатай байдаг. ◆ Хүмүүнлэгийн ажилтан мөргөлдөгч талуудын итгэлийг олж авахын тулд говийг сахиж, шударга ёсиг эрхэмлэх ёстай. ◆ Хүмүүнлэгийн ажилтнууд ажиллаж байх Үедээ ёс зүйн диллемматай тулгардааг. Хэдийгээр хамгийн оновцуй хариуцт, шийдвэр олдохгүй байж болох авч, юу ч хийхгүй байна гээг нь бас л ямар нэгэн Үр дагавартай шийдвэр гэдгийг ойлох нь чухал юм.	
				Хүний нэр хүндийг хөхиулэн дэмжих төслийн төлөвлөлтийн талаар сурсан мэдлэгээсээ амьдралд хэрэгжүүлэх. Дугнэлт Судалгаа	◆ Хүний нэр хүндийг хөхиулэн дэмжих төслийн төлөвлөлтийн Запуучуудыг дайчлах нь Зорилтот хун ам Төслийн зорилго Нийгмийн хүчин чадал ба баялаг Хүний нэр хүнд та юу хийж чадах вэ? Бусдын мэдлэгийг та хэрхэн дээшшуулж чадах вэ?	◆ Хүний нэр хүндийг илэвхгэй дэмжихийн төлөө хийгдэх ажил олон байгаа бөгөөд ур чадвар, сонирхолдоо тохирсон төсөлд оролцох боломжтой юм. ◆ Бусдын нэрийн өмнөөс ажил Уурэг түйцэтгэх үед тэдний байр суурийг харгалзаж үзэх нь чухал байдаг. ◆ Төсөл хэрэгжих явцад тогтолц хугацаанд Үр дунд үнэлгээ өгөх, ирээдүйн төлөвлөгөө тоймлон гаргах нь тустай байдаг.

## Танилцуулга

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг ямар учраас заах шаардлагатай вэ?

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь мөргөлдөөний нөхцөл байдалтай холбоотой хүмүүнлэгийн асуудлуудын ойлголтыг дээшлүүлэхэд чиглэгдсэн цуврал судалгаануудаас бүрдэнэ. Тиймд дэлхийн иргэншлийн болон хүний эрхийн боловсрол, амьдрах ур чадварын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдаг. Мөн ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хууль, түүх, нийгэм судлал, гүн ухаан зэрэг хичээлүүдийг сурах явцад ч ач холбогдолтой байж болох юм. Женевийн Конвенцид нэгдэгч талууд иргэний нийгэм, залуусынхаа өмнө олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг аль болох өргөн хүрээтэйгээр түгээн дэлгэрүүлэх хариуцлага хүлээсэн байдаг. Энэ утгаараа ч “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь суурь боловролын “олон улсын” нийтлэг цөмийг бүрдүүлэхүйц судлагдахуун юм. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн боловсрол нь орон нутаг, үндэстэн, олон улсын түвшинд иргэншлийн боловсролд хувь нэмэр оруулдгаараа өвөрмөц билээ.

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” гэдэг нь?

“Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь” хичээл нь цаашдын сургалтын үндэс болгон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйд анхаарлаа төвлөрүүлдэг. Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хүндэтгэн сахих нь зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэх гачигдал зовлон, хүндрэл бэрхшээл болон хүчирхийллийг хурцдахаас сэргийлэхэд тустай байж болох талтай. Мөн хэрэгцээгүй зовлон шаналалаас зайлсхийн, хүний нэр хүндийг хөхиүлэн дэмжих, мөргөлдөөнийг энх тайвны аргаар шийдэх замыг түргэсгэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь зөвхөн дайны үед төдийгүй, хүн төрөлхтний бүхий л туршлагын хүрээнд хүний амь нас, нэр хүндийг хамгаалах талаар авч үздэг. Уг хичээлийн туршилтын хөтөлбөрт оролцсон Мароккогийн нэгэн сурагч охин “би хүн бүхнийг, дайсныгаа хүртэл хүн гэдэг талаас нь харж, мэдэрч сурлаа” гэсэн байна.

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь хүмүүнлэгийн төлөв байдлыг хөхиүлэн дэмждэг. Харин тодорхой мөргөлдөөнүүдийн учир шалтгааны хувьд улс төр болон үзэл суртлын үүднээс тайлбарлах нь энэхүү хичээлийн зорилго биш юм.

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг заах багш буюу хэлэлцүүлгийг удирдан явуулагч таны үүрэг

Багш нар ихэвчлэн цаг хугацаа зарцуулан сурч мэдсэн, танил болсон хичээлээ заадаг. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн багш нарын хувьд, та бүхэн хараахан мэргэшээгүй хичээлийг заах гэж байна. Хичээлийн сэдэв нь шинэлэг бөгөөд идэвхтэй заах арга нь ч багш нар болон хэлэлцүүлгийг удирдан явуулагчдад шинэ соргог болов уу. Мароккогийн нэгэн багш “Ийм хичээлийг үламжлалт заах аргаар заадаггүй юм байна. Харин бид хамтдаа суралцаж байгаа шүү гэсэн хандлагатай байх хэрэгтэй” гэжээ.

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг заах багш буюу хэлэлцүүлгийг удирдан явуулагч нь суралцагчийн үүрэг гүйцэтгэх учир та өөрөөсөө дараах хэдэн асуултыг асуугаад үзээрэй:

- Би юунд найдах вэ? Өөрөөсөө болон сурагчдаасаа хүсэн хүлээж буй зарим үр дүнг тодорхойлж эхлэх
- Би юунаас эмээж байна вэ? Хичээлийг заахтай холбоотой, ямар нэг байдаар санаа зовниулсан зарим асуудлуудыг нэрлэ. Зохих шийдлүүдийг тодорхойл.

## **“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг ямар учраас заах шаардлагатай вэ?**

► Сурагчид миний хариулж чадахааргүй асуулт тавидал яах вэ? Хичээлийн мөн чанараас улбаалан аливаа асуултанд хялбар, түргэн хариулт байхгүй гэдэг нь тодорхой. Хариулт өгөх зарим аргуудыг “Багш нарт 3: ‘Хялбар бус хариулт’”-аас үзнэ үү. Энэхүү материалын нэг зорилго нь багш, сурагчдыг хамтран суралцахад туслахад оршино. Хариулт бэлэн бус тохиолдолд, багш та хариулахад шаардлагдах мэдээллээ олж авахад нь сурагчдад туслах үүрэгтэй. Ийм асуултууд танд болон таны сурагчдад хуримтлуулсан туршлагаа “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлд ашиглах бололцоо олгоно. Хүнд хэцүү санагдаж буй асуултууд дэлхийн олон улс төрч, эрх зүйн мэргэжилтнүүдийн маргааны сэдэв гэдгийг санах хэрэгтэй.

### **Багш - боловсрол хөтөлбөрийн үндэслэл**

- ▲ Үр дүнтэй багш - боловсрол хөтөлбөр “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн үндсэн ойлголт, судалгаануудыг онцлон заах арга, техниктэй нь хослуулсан байдаг.
- ▲ Сурагчдын адил багш нар өөрсдөө үзэж, туршиж байж суралцдаг учир сургалтын явцад судалж мэдсэн үйл ажиллагаа нь хожим заах хичээлд биелэлээ олсон байх хандлагатай.
- ▲ Чадварлаг хөгжмийн зохиолчдын адил багш нар үндсэн сэдвээ эзэмшихвэл дараа нь өөрсдийнхөө хувилбарыг бий болгодог.
- ▲ “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн агуулга, ихэнх тохиолдолд аргууд нь багш нарт шинэлэг байх учир суралцах, дадлагажих, хөтөлбөрийн тухай эргэцүүлэн бодох цаг хугацаа шаардлагатай болдог.
- ▲ Багш нар анги танхимд бодитойгоор хичээл зааж буй бусад багш нарын жишээнээс суралцдаг.

### **Багшийн өмнөө тавих зорилт**

- ▲ Хичээлийн хөтөлбөрт багтсан үндсэн ойлголт, үйл ажиллагаануудыг сайтар ойлгож авах
- ▲ Хэлэлцүүлэг, дүрд тоглох, бүлгээр ажиллах, дурс бичлэг болон дилемма ашиглах зэргээр олон төрлийн стратеги агуулсан заах арга барилын урын сангaa арвижуулах
- ▲ Хичээлийн хөтөлбөрийн дагуу мэргэшил, чадвараа нэмэгдүүлж, заах ур чадвараа сайжруулах

### **Хөтөлбөрийг хэрэгцээндээ тохируулах нь**

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг 13-18 насны хүүхдүүдэд заахад зориулсан бөгөөд зэвсэгт мөргөлдөөний туршлагын хэр хэмжээнээс үл хамааран, ямар ч хэл дээр, аль ч улсын нутаг дэвсгэр дээр, мөн түүнчлэн дурын түвшний техник, тоног төхөөрөмжтэйгөөр албан ба албан бус сургалтаар зааж болно. Дэлхий даяар судлахаар зохиогдсон учраас, энэхүү хичээлийн ойлголт, заах арга барилтай танил болсон багш нар болон хэлэлцүүлгийг үдиранд явуулагчдаас тухайн орон нутгийн онцлог, нөхцөл байдалд нь тохируулан заахыг үүрэг болгодог билээ.

Хичээлийг зааж эхлэхээс өмнө хөтөлбөртэйгээ сайтар танилцахын тулд материалын нутагтай унших хэрэгтэй. Суралцагчид хэн билээ, “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг хэрхэн нэвтрүүлэх вэ гэдгийг ч бодолцох хэрэгтэй. Нэг талаас ашиглахыг хүссэн материал болон үйл ажиллагаагаа сонгох, нөгөө талаас хэрэглэж болох орон нутгийн нөөц, эх сурвалжуудыг тодорхойлох нь таны зорилго юм. Судалгаанууд гинжин бүтэцтэй бөгөөд судалгаа бүрийн үйл ажиллагаанууд мөн ижил бүтэцтэй байна. Үйл ажиллагаануудаа сонгосноор багш нар өөрийн гэсэн хөтөлбөө зохиох боломжтой болно.

# “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг ямар учраас заах шаардлагатай вэ?

Харин анх удаагаа заах гэж буй багш нар өөрчлөлт хийлгүйгээр стандарт хөтөлбөрөө баримтлах нь зүйтэй.

Зааж эхлэхээс өмнө:

- ▲ Өөрийн улс, бүс нутагтаа байгаа олон улсын хүмүүнлэгийн байгууллагатай холбоо тогтоож, тухайн сэдвээр ашиглах материал, илтгэгч байгаа эсэхийг лавлах
- ▲ “Цэрэг” хүүхэд, хүний эсрэг газрын мина зэрэг хичээлийн агуулгад багтсан зарим асуудлуудтай холбоотой орон нутгийн мэдээлэл, эх сурвалжийг тодорхойлох
- ▲ Танай улс уг хөтөлбөрт тусгагдсан асуудал, сэдвүүдийн хувьд ямар нөхцөл байдалд байгааг тогтоох

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, хүмүүнлэгийн төлөвийн орон нутаг, бүс нутаг, үндэсний жишиг судалж эхэлснээр сурагчид өөрсдийн мэддэг сэдвээсээ халин, дэлхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг ойлголт руу шат ахихад дөхөмтэй болно. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлд олон янзын түүх, фото зураг төдийгүй дилемма жишээнүүд ч багтсан байдаг. Эдгээрээс сурагчдад хамгийн тохиromжтойг нь сонгож авах хэрэгтэй. Мөн суралцагч хүүхэд залуучууд тухайн орон нутгийн нөхцөл байдлыг харуулсан түүх, зүйр уг зэргээр хичээлийн агуулгыг баяжуулж болох юм.

Үйл ажиллагааны түвшинг сурагчдын нас, боловсролын түвшинд тохируулж болно:

- ▲ Бага насны сурагчдад түүх, фото зураг, дүрс бичлэг зэргийг танилцуулахдаа эхлээд тодруулах, ойлгуулах асуултууд тавих, дасгалд дүн шинжилгээ хийхээс өмнө зураг дээр юу болж байна, өгүүллэг, түүхэнд юу гарч байна, уг өгүүлбэрүүд нь ямар утгатайг харилцан ярилцана.
- ▲ Унших чадвар нь хязгаарлагдмал бүлэгтэй ажиллахдаа, түүх, өгүүллэгийг чангваар унших хэрэгтэй. Унших явцдаа чухал хэсэг дээр түр зогсон ойлгоцыг тодруулах асуулт тавьж тоймлоно.
- ▲ Чадварлаг суралцагчдын хувьд өдөөх асуулт тавих, олон өнцгөөс харж тунгаах шаардлагатай дилемма, асуудал дэвшүүлэх зэргээр хэлэлцүүлэг, мэтгэлцээнийг хөхиүүлэн дэмжих хэрэгтэй.

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь түүх, математик, хэл бичиг болон уран зохиолын хичээлүүд рүү хөрвөх боломжтой бөгөөд үйл ажиллагаанууд нь өөр хоорондоо холбоотой. Зарим судалгааны өөр хичээлд ашиглагдах боломжуудыг “нэмэлт дасгал” хэсэгт оруулсан байгаа.

Зарим судалгааг хувилан ашиглах дүрс бичлэг, материалууд дагалдах бөгөөд хэрэв эдгээрийг ашиглахад шаардагдах тоног хэрэгсэл байхгүй бол фото зураг, зургийн эвлүүлэг болон зурагт хуудас зэргийг ашиглах, түүх, өгүүлэл, эх бичмэлийг унших зэргээр зорилгодоо хүрэх боломжтой.

## Дөт арга зам

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь дангаар нь ашиглаж болох, эсвэл одоогоор хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрүүдэд хавсарган ашиглаж болох сургалтын материалуудын цогц юм. Эдгээр материалуудыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар тэнхимийн сургалтанд хэрэглэхээс гадна хөтөлбөрөөс гадуур хичээлүүд болон танхимиин бус янз бүрийн сургалтанд ашиглах бүрэн боломжтой. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалын иж бүрдэл нь нийт 20 цагийн зааварчилгатай бөгөөд нэмэлт материал, үйл ажиллагаа болон урт хэлэлцүүлэг бүхий семинар зэргийг ашиглан өргөтгөж болно. Гэвч, уг хичээлийн ерөнхий бүтэц уян хатан учир тухайн зорилт, цагийн бололцоондоо тааруулан үйл ажиллагаагаа сонгох боломжтой.

## “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг ямар учраас заах шаардлагатай вэ?

Хүчирхийлэл, мөргөлдөөний үед хүний амь нас, нэр хүндийг хамгаалахтай холбоотой үндсэн асуудлуудыг бүхэлд нь зөв ойлгуулахуйц судалгааны дөт замыг дор үзүүлэв.

- Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт
- Судалгаа 1А: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?
- Судалгаа 2А: Дайны сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах
- Судалгаа 3А: Зөрчлийг тодорхойлох
- Судалгаа 4А: Шударга ёсны суурь шалтгаан
- Судалгаа 5А: Дайны хор хөнөөлөөс үүдэн гарах хэрэгцээ

Энэхүү дөт арга замыг багш, сурагчдын цагийн бололцоо, “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг агуулсан боловсролын үндсэн хөтөлбөрийн сургалтын зорилтоос хамааруулан янз бүрийн байдлаар өргөтгөж болно.

### Сургалтыг үнэлэх

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь үнэлгээний бичгэн аргачлалаас гадна сурагчид юу сурч, юуг буруу ойлгож авав гэдгийг олж мэдэх өдөр тутмын боломжийг багш нарт олгодог. Үүнд ангийн хэлэлцүүлэг, бүлгийн ажил, брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх болон дүрд тоглох зэрэг идэвхитэй суралцах аргууд орно.

Тусгай үнэлгээний арга, асуултууд доорх хэсгүүдийн төгсгөлд өгөгдсөн байна.

- ▲ “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн нийт бүлэг
- ▲ Багш нарт зориулсан сургалтууд
- ▲ “Багш нарт” хэсэг

Багшлах явцад өөртөө доорх асуултуудыг тавиарай:

- Явц дунд дэвшил гарч байна уу?
- Сурагчид мэдээллийн хэрэгслээр гарч байгаа болон амьдралд нь тохиолдож байгаа үйл явдалд сурсан ойлголтуудаа (гинжин нөлөө гэх мэт) ашиглаж чадаж байна уу?
- Сурагчид сурсан зүйлтэйгээ уялдуулан сонин сэтгүүлийн нийтлэл, радио өгүүлэл болон гэр бүл, найз нөхдөөсөө дуулсан түүх зэргийг сайн дураараа авчирч байна уу?
- Тэд фото зургийг хоёр, гуравдахь удаагаа харахдаа шинэ зүйл олж харж байна уу?
- Тэд холбогдох талуудын, ялангуяа зэвсэгт мөргөлдөөнд хохирогчдын олон талт үзэл бодлын талаар илүү сайн мэддэг болж байна уу?
- Тэд бусдын оронд өөрийгээ тавьж, нөхцөл байдлыг өөрөөр харах чадвар байна уу?
- Эмзэг бүлгийнхэнд туслах хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай байдгийг тэд ойлгож байна уу?

## “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг ямар учраас заах шаардлагатай вэ?

### Энэхүү арга зүйн удирдамжийн бүтэц, зохион байгуулалт

Арга зүйн удирдамж нь багшлах арга, багш нарт зориулсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад зориулагдсан материал юм. Бичмэл удирдамж нь:

- ▲ “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг заах танилцуулга
- ▲ Багшлах 10 стратегийг танилцуулах “Багш нарт” хэсгүүд  
“Багш нарт” хэсэг нь тодорхой багшлах арга техникийн тухай, мөн түүнчлэн **зорилго, сургалтын эхлэл, бүлгийг удирдах, бэрхшээлийг шийдвэрлэх** болон **үнэлгээний талаар зөвлөмж өгнө.**
- ▲ Багш нарыг бэлтгэх 10 сургалтын төлөвлөгөө зэргийг агуулсан байна.

## Багш нарт

### 1. Хэлэлцүүлэг

Хэлэлцүүлэг, ярилцлага нь “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн хөтөлбөрийн үндсэн суралцах стратеги юм. Хэлэлцүүлгийн нэг зорилго нь сурагчдын тэнцвэртэй оролцоонд урам зориг өгөхөд оршино. Үр өгөөжтэй хэлэлцүүлэг нь багш буюу хэлэлцүүлгийн удирдан явуулагчийг сайн сонсогч, бас сайн “нэхмэлчин” байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, янз бүрийн сурагчдын олон санаа бодлыг нэгтгэн холбож, хээнд оруулан нэхэг гэдэг утгаараа нэхмэлчин юм. Хэлэлцүүлгийн эцсийн зорилго нь сурагчид өөрсдөө “нэхмэлчин” болоход хүргэх явдал билээ.

#### Зорилго

- ▲ Сэдвийн талаар сурагчид юу мэдэж байгааг тогтоох
- ▲ Сонсох, ярих зэрэг хэлэлцүүлэгт шаардагдах чадваруудыг хөгжүүлэх
- ▲ Сурагчдад байр сууриа тодорхойлж түүнийгээ баримтаар нотлох дадлага олгох

#### Эхлэх

Хэлэлцүүлэг эхлэх үед дараах хоёр дүрмийг баримтлах хэрэгтэй. Сонирхолтой хэлэлцүүлэг ид халж ирэх тохиолдолд хэрэгтэй бол сурагчдад дүрмээ дахин сануулж болно.

1. Бусдыг анхааралтай сонсож, яриаг дуустал нь хүлээх
2. Бусдын үзэл бодолтой санал нийлэхгүй байж болох боловч тэднийг болон тэдний үзэл бодлыг хүндэтгэн харьцах

Самбарт дараах зүйлсийн нэг, эсвэл бүгдийг бичиж хэлэлцэх асуудлыг тодорхой болгоно:

- ▲ Хэлэлцэх асуудал, асуултууд
- ▲ Хэлэлцүүлгийн зорилго
- ▲ Хэлэлцүүлгийн боломжит үр дүн

Хэлэлцүүлэгт асуулт, фото зураг, түүх өгүүлэл, мэдээлэл, дүрс бичлэг, бичих дасгал болон бусад тохиромжтой материалуудыг ашиглан сурагчдын үзэл бодлыг өдөөн идэвхжүүлэх хэрэгтэй.

#### Бүлгийг удирдах

- ▲ Сурагчдад хэлэх зүйлээ эргэцүүлэн бодох хугацаа өгөх хэрэгтэй. Тэд бодлоо цаасан дээр буулгасан бол ярихад улам хялбар байdag.
- ▲ Сурагчдын хувь нэмрийг хүлээн зөвшөөр. Үндсэн санаануудыг самбар дээр бичих нь тоймлон дүгнэж, анализ хийхэд дөхөмтэй байдаг.
- ▲ Сурагчдыг нэмэлт санаагаа хэлэхийг уриалах, бусадтай санал нийлж буй эсэхийг асуух зэргээр хувь нэмрээ оруулахад нь урам зориг оруулах
- ▲ Сурагчид санал бодол, дүгнэлтээ шууд багшид хэлэлгүйгээр бусадтайгаа харилцан ярилцах талаас нь чиглүүлж өгөх

## Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Хэн нэгэн нь буруу мэдээлэл дамжуулбал эхлээд алдаа нь чухал эсэхийг тогтоо. Хэрвээ алдаа нь ач холбогдолтой тохиолдолд, анхны илтгэгчийн урмыг хугалалгүйгээр бусад сурагчдыг саналаа илэрхийлэхийг уриална. Эсвэл та өөрөө алдааг нь тодруулан хэлж өгнө.
- ▲ Сурагчид ярих сонирхолгүй байвал, тэдэнд хэлэлцүүлгийн зорилго нь “зөв” хариулт өгөхдөө бус янз бүрийн санал, үзэл бодлыг судлах юм шүү гэдгийг сануулна.
- ▲ Хэлэлцүүлэг дүрэм журмаа алдаад эхэлбэл өмнө нь тогтоосон хоёр дүрмийг дахин сануулна.
- ▲ Зөвхөн хэдхэн сурагчид хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоод байвал, бусдыг санаа бодлоо нэмэрлэхийг уриалах, эсвэл бичсэн зүйлээсээ унших зэргээр дуугүй байгаа сурагчдаас асуулт асууна.

Хэлэлцүүлэг улс төрийн эмзэг асуудал, шашин соёлын итгэл үнэмшил, дадал заншил руу хазайгаад ирвэл яах вэ? Энэ нь сурагчдын тодорхой ашиг сонирхол, үзэл бодол, туршлага зэрэгтээ тууштай байгааг харуулж байж болох юм. Хэлэлцүүлэг нь “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлтэй шууд хамааралтай тохиолдолд, та хичээлийн цагаа гүнзгийрүүлсэн судалгаа хийх, нэмэлт дасгал хийлгүүлэх, бие даасан судалгаа хийхийг дэмжих зэрэгт зарцуулж болно. Хэрэв энэ хэлэлцүүлэг уг хичээлийн тэнхимийн сургалттай холбоогүй бол, хувь хүний туршлага, сонирхол, хэрэгцээтэй хамаатай байж болох үүднээс сурагчдыг янз бүрийн үзэл бодол дээр тулгуурлан бодож эргэцүүлдэг болгох зорилгоор хичээлээс гадуур уг сэдвийг хөндөн хэлэлцэж болно. Өөр боломжит хувилбар гэвэл, та сурагчдаа тухайн сэдвээр бие даасан судалгаа хийхийг санал болгож болно.

## Үнэлгээ

- Сурагчид мэдэж буй зүйлээ тодорхойлж бусадтай хуваалцаж чадав уу?
- Сурагчид бусдын үзэл бодлыг сонсож, тэдгээрт хариу өгсөн үү?
- Ямар чухал санаанууд болон санал нийлэхгүй асуудлууд гарав?
- Та юу сурсан бэ?
- Та юуг арай өөрөөр хийх байсан бэ?
- Та туршлага дээрээ тулгуурлан дараагийн хичээлийн хэлэлцүүлгийг яаж хийх вэ?

## Багш нарт

### 2. Брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх

Брейнсторминг буюу оюуны довтолгоон гэдэг нь аливаа зүйлийг шүүн хэлэлцэхийг түр хойшлуулах уур амьсгал бүрдүүлснээр сурагч бүрийн өвөрмөц бодол эргэцүүллийг дэмжих арга бөгөөд тодорхой хугацаанд оюуны довтолгооноор аль болох олон санал, санаа гаргаж ирэх бололцоо олгодог. Хэрвээ аливаа асуудлыг шийдэх зорилготой бол, хувь хүмүүс олон янзын шийдэл дэвшүүлнэ. Сурагчид олон санал дэвшүүлсний дараа мэдээллийг тоймлон, бүлгээрээ нэгдсэн хариу өгөх боломжтой.

#### Зорилго

- ▲ Хэлэлцүүлэг эхлүүлэх буюу асуултанд хариулахын тулд янз бүрийн санал цуглуулах
- ▲ Сурагчдын идэвхийг нэмэгдүүлж, урам зориг хайрлах

#### Эхлэх

Сурагчдыг бүлэг дотроо аль болох олон санал дэвшүүлэхийг уриалан дараах удирдамжийг санал болгоно уу:

- ▲ Идэвхтэй байх
- ▲ Бусадтай хуваалцахын өмнө өөрийн бодол санаандаа үнэлэлт, дүгнэлт өгөхгүй байхыг хичээх
- ▲ Бусдын санал бодолд хүлээцтэй хандан нээлттэй сэтгэлгээтэй байж, үнэлэлт, дүгнэлт хийхгүй байх
- ▲ Бусдын дэвшүүлсэн санаан дээр өөрийн санааг нэмэрлэх

#### Бүлгийг удирдах

- ▲ Брейнстормингийн (оюуны довтолгоон хийх) асуулт буюу гол сэдвийг тодорхой мэдээл.
- ▲ Сурагчдыг хариулж эхлэхээс өмнө асуултын талаар тодруулах ёстой бүгдийг тодруул.
- ▲ Сурагчдын оруулсан хувь нэмэр, оролцоог бүртгэж ав.
- ▲ Зохимжгүй санаануудыг тодруул. (Урмыг нь хугалалгүй дараа нь санал дэвшүүлэхэд саад болохгүйгээр тодруулж хэлж өгөх хэрэгтэй.)
- ▲ Үйл явц удааширч эхэлбэл нэмэлт хариулт авахын тулд асуултаа дахин тавь.
- ▲ Олон санал дэвшүүлэх үйл явцыг эцэслэн дүгнэхдээ хуваалцсан санаануудыг жагсаан тоймлох, дүгнэх, эсвэл эдгээрийг сурагчдаар өөрсдөөр нь хийлгэ.

#### Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Сурагчдын хариулт тухайн сэдэвтэй холбоогүй байвал, үргэлжлүүлэхээсээ өмнө түр зогсоод сэдвээ дахин тодорхойлох хэрэгтэй.
- ▲ Хэрэв сурагчид тухайн сэдвийн талаар мэдлэг хомс учраас хариулахад хүнд байгаа бол, санаа өгөхүйц зарим хариултыг жишигэлэн үзүүлж болно.

#### Үнэлгээ

- ▲ Сурагчдын санал дэвшүүлэх чадвар хэр зэрэг сайн байсан бэ?
- ▲ Бүлгүүд хуваалцсан санаануудаа нэгтгэн дүгнэхдээ ямар байсан бэ?
- ▲ Энэ стратегийг хэрэглэхийн давуу буюу сул талууд юу вэ?
- ▲ Та юуг арай өөрөөр хийх байсан бэ?

## Багш нарт

### 3. “Хялбар бус хариулт”

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн сурагчид багш нар ч хариулахад хэцүү асуулт тавьдаг. Энэ нь мэдээллийн хомдолоос бус харин хялбар хариулт угаасаа байхгүй учраас юм. Хаана ямар хэцүү асуулт гарав гэдгийг тэмдэглэж аваад тэдгээрийг “хялбар бус хариулт” гэж нэрлэхийг санал болгож байна. Ийм асуултад хариулах эх сурвалжуудын нэг нь “Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй: Таны асуултад хариулах нь” нэртэй Олон Улсын Улаан Загалмайн Хорооноос гаргасан товхимол болно. Зарим нэгэн асуултыг “Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь” хичээлийн дараагийн бүлгүүдэд авч үзнэ.

#### Зорилго

- ▲ Сурагчдын тавьсан хэцүү асуултуудын бүртгэл хөтлөх (дараа тайлбарлахын тулд)
- ▲ Зарим асуултууд хариулт өгөхөд үнэхээр төвөгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх
- ▲ Хэцүү асуултуудыг судлахад хэрэг болох боломжит эх сурвалжыг тогтоох

#### Эхлэх

Зэвсэгт мөргөлдөөний үед туйлширсан нөхцөл байдал, тайлбарлахад хэцүү зан үйл үүсдгийг онцлон дурдах хэрэгтэй. Ийм учраас дээрх нөхцөл байдалд олон асуултуудад хариулт өгөхөд хялбар бус байдаг. Гэсэн хэдий ч сонирхол болон бодолдоо автсан сурагчдын урмыг хугалахгүйн тулд цаг алдахгүйн үүднээс ямар ч гэсэн энэ асуултуудыг авч үзэх хэрэгтэй.

#### Бүлгийг удирдах

- ▲ Хэцүү бөгөөд даруйхан тодорхой хариулт өгөх боломжгүй асуултууд “хялбар бус хариулт”-д тооцогдох ёстой.
- ▲ Хэцүү асуултуудыг цаашид гарч ирэх асуултуудтай хамтаар судлахыг, мөн тэдгээр асуултуудаас үр дүн гаргахыг сурагчдад даалгана.
- ▲ Бусад сурагчдаас ганцаарчлан буюу жижиг бүлгээр хариу өгөхийг хүснэ.
- ▲ Ийм асуултуудад шууд хариулахад зарцуулах хүчин чармайлтанд тодорхой хязгаар тогтооно.
- ▲ Тус хөтөлбөрийн дагуу дараа авч үзэх асуултуудыг тодорхойлно.

#### Боломжит хариулт бүхий түгээмэл тавигддаг зарим хэцүү асуултууд

- ▲ Дайны үед яах вэ гэсэн хууль гаргана гэдэг чинь угтаа дайныг хуульчилж байгаа хэрэг бус уу? Дүрэм нь дайныг тоглоом шиг болгож байгаа юм биш үү? Ер нь дайныг шууд хууль бус гэж тогтоож болохгүй юу?

Ихэнх тохиолдолд дайныг хууль бус гэж заасан байдаг. Олон улсын эрх зүйд зааснаар хоёрхон тохиолдолд л дайныг эрх зүйн дагуу гэж үзэх ба тэр нь НҮБ-ээс зарласан дайн болон тухайн орон өөрийгээ хамгаалах зорилгоор эхлүүлсэн дайн болно. Гэвч XX зууны сүүлийн хагаст болсон олон үйл явдал дайныг хууль бус гэж тунхагласнаар сэргийлж чадахгүй гэдгийг харуулж байна. Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй нь дайны энэхүү гунигт бодит байдлыг хүлээн зөвшөөрөх төдий бөгөөд дайныг учлах ч үгүй, хуульчлах ч үгүй.

Энэ асуултанд бүрэн хариулахын тулд “Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт”-ыг харна уу.

- Цэргийн албанд татагдсан цэргүүдийг яагаад дайны гэмгүй хохирогчид гэж үздэггүй вэ? Шийтгэнэ гэж сүрдүүлсэн учир тэд дайнд явж гайд өртөн, өөрсдийн хүний нэр хүндэд нийцэхгүй олон зүйлийг тушаалын дагуу гүйцэтгэдэг.

Хүн төрөлхтний түүхнээ зэвсэгт хүчин нь цэргийн албадан татлагад тулгуурлаж ирсэн гэдгийг тэмдэглэж хэлэх нь зүйтэй. Асуудлын гол нь албадан татагдсан цэргүүд хохирогчид мөн эсэхэд бус харин тухайн улс аюулд учирсан үед иргэдээ албадлагаар цэрэг болгож болж байна уу гэдэгт байгаа юм. Гэтэл энэ нь улс төрийн ба шашин - ёс зүйн үзэл бодлынхоо улмаас цэргийн алба хаахаас татгалзсан хүн гэдэг Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн хүрээнээс гадуур сэдэвт хүргэж болох юм. Байлдахаас татгалзсан хувь хүмүүсийг шийтгэх ёстой юу? Яагаад? Зөвхөн сайн дурын арми буюу зэвсэгт хүчинтэй байвал дээр биш үү? Сайн дурын хүчинтэй байлаа гэхэд асуудал бас гарах уу?

Дараах асуудлуудыг ч авч үзэж болох юм:

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй нь зэвсгээ хаясан, өвчтэй, шархадсан буюу олзлогдсоны улмаас байлдаанд идэвхитэй оролцоооргүй болсон бүх байлдагчдыг хамгаалах арга замыг эрэлхийлдэг. Дээрх шалтгаанууд биелэлээ олсон тохиолдолд байлдагчид дайны хохирогч болдог. Хүмүүнлэгийн эрх зүйн дагуу олзолж авсан гурэн эдгээр хүмүүстэй харьцах талаар бүрэн хариуцна.

- Захирагч нь Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг зөрчсөн тушаал өгвөл цэрэг яах вэ?

Цэргүүд хууль ёсны буюу хууль бус захирамжийг ялгах чадвартай болохын тулд Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн дүрмүүдийг мэддэг байх ёстой. Хэрвээ цэрэг Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг зөрчсөн тушаал, магадгүй дайны гэмт хэрэг ч байж болох үйлдэл гүйцэтгэх хэрэгтэй болсон тохиолдолд татгалзах ёстой. Тушаалыг дуулгавартай биелүүлэх нь уучлах үндэслэл болохгүй. Нөгөөтэйгүүр, цэрэг хүн тушаал биелүүлэхээс татгалзах нь маш хэцүү, ихэнхдээ аюултай гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

- Дайнд ялсан хүчирхэг үндэстнүүдийг яагаад шүүн хэлэлцдэггүй юм бэ?

Бодит амьдрал дээр ялагчид шүүхээс зугтах нь олонтаа тохиолддог. Нэг талаар саяхныг хүртэл олон улсын шүүхийг бүгдэд эрх тэгш хүлээлгэх механизмыг байгаагүйтэй энэ нь холбоотой. Гэвч байдал өөрчлөгдөж байна. Хувь хүмүүсийн харьяаллаас нь үл хамааран шүүхийн өмнө хариуцлага хүлээлгэх, түүнчлэн Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн зөрчлийг шүүн таслах байнгын үйл ажиллагаатай Олон Улсын Эрүүгийн Шүүх 2002 онд байгуулагдсан билээ.

Ангийн хэлэлцүүлэг дээр дараах асуултуудыг асууж болно.

- Хууль сахиулах явц шударга бус байна гэдэг нь хууль эрх зүйтэй байх хэрэггүй гэсэн үг үү?

Та сурагчдад Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг зөрчсөн хэрэгт сэжиглэгдсэн зарим хүмүүсийг шүүх үйл ажиллагаа явагдаж байгаа тухай жишээ баримт хайх, амжилттай хууль сахиулалтын жишээг “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн вебсайтыг ашиглан шалгах зэрэг судалгааны даалгавар өгч болно.

- Зэвсэг зарж их ашиг олж байгаа томоохон үйлдвэрлэгчид шүүхэд татагддаггүйн учир юу вэ?

Хууль бус зэвсэг үйлдвэрлэх, худалдахад хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн хэм хэмжээнээс гадуур авч хэлэлцдэг. Ийм асуудлууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын зохицуулах ажлын хүрээнд багтана. Хууль бус зэвсэг худалдаалж буй бөгөөд зэвсгийн хорио тавигдсан улс оронтой наймаа хийж буй аж үйлдвэрийнхэн шүүхэд татагдах ёстой.

- Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй нь атомын бөмбөгийн талаар юу хийв? Уг хуулийн хамрах хүрээнд юу багтдаг вэ? Лазерын туяа багтаад, цөмийн зэвсэг багтдаггүй гэж ойлгогддог. Яагаад?

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй нь хэрэгцээгүй зовлон шаналал, шаардлагагүй шарх гэмтэл авчрах зэвсэг, энгийн иргэд болон байлдагчдыг ялгахгүй зэвсгийг хориглодог. Эдгээр зарчмуудыг бодолцвол, атомын бөмбөгийн хэрэглээ хууль эрх зүйн дагуу байх тийм нөхцөл байдлыг төсөөлөхөд ч хэцүү юм.

- Зарим дайнууд бусдаасаа илүү “шударга” байдаггүй гэж үү? Эх орноо хамгаалах буюу эрх чөлөөгөө олж авах гэсэн дайн бусад орныг булаан эзлэх дайнаас илүү шударга биш гэж үү?

Энгийн бөгөөд шулуухан хариулт бол: Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй нь дайны учир шалтгааныг шүүдэггүй боловч нэгэнт гарсан мөргөлдөөнийг шалтгаанаас нь үл хамааран зохицуулдаг. Мөн юу мөргөлдөөнд хүргэснээс үл хамааран адилхан дүрэм хэрэглэх замаар гэм буруугүй хүмүүсийг дайны хор хөнөөлөөс хамгаалахыг эрмэлздэг.

Та сурагчдаас Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн төлөв байдлыг дэмжсэн ба эсэргүүцсэн маргаан өрнүүлэхийг хүсч болно. Жишээлбэл, байлдаж буй улс орны зөв бурууг хэрхэн ялгаж үздэгээс энгийн иргэд буюу байлдахааргүй болсон цэргүүдийг хамгаалах байдалд ялгаа үүсвэл яах вэ гэсэн асуулт гарч болно. Ийм тохиолдолд гарах үр дагаврыг хэлэлцэнэ үү.

### Хүндрэлийг шийдвэрлэх

- Хэрвээ аливаа асуудал дээрх зөрөлдөөнтэй саналд аль нь ч буулт хийхгүй бол энэ талаар мэргэжилтнүүд ч гэсэн санал зөрөлддөг гэдгийг хэлэх хэрэгтэй. Мөн тухайн асуудлаар илүү албан ёсны шинжтэй маргаан өрнүүлж болно.
- Та асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа бол орон нутгийнхаа мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж болно.
- Сурагчид аливаа асуудлыг судлахдаа Олон Улсын Улаан Загалмайн Хорооны ажилтнууд, бусад багш, сурагчдаас хариулт авч болох “Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь” хичээлийн вебсайтыг ашиглаж болно.
- “Хялбар бус хариулт” буланд байгаа асуултуудыг дахин дахин хянаж байхыг сануулья.

### Үнэлгээ

Дараах материалыг маргаан явуулах буюу эсэ бичүүлэх зорилгоор ашиглаж болно.  
Швейцарын хуульч Эммерих де Ваттелийн сонирхолтой үзэл бодлоос (“Улс үндэстнүүдийн эрх зүй” 1758):

“Дайтагч талууд өөрсдийн үзэл бодлоо зөвтгөж байхад тэдний зөв бурууг хэн ялгаж салгах ёстой вэ? Шүүгч байхгүй учир дайныг зохицуулах дүрэм журамд найдлага тавихаас өөр аргагүй. Нэгдүгээр дүрэм бол хууль ёсны дайн гэдэг нь дайтагч талуудын аль аль нь шударга гэж тооцогдох дайныг хэлнэ. Хэрэв хүмүүс дайн байлдаан мэтийн

## “Хялбар бус хариулт”

хүчирхийлэлт үйл ажиллагааны үед ямар нэгэн дэг журам, хууль ёсыг нэвтрүүлэхийг хүсч байвал, эсвэл гамшиг зовлонг хязгаарлан ... энх тайвны төлөө үүд хаалгаа үргэлж нээлттэй байлгахыг хүсч байвал ... энэ дүрэм зайлшгүй хэрэгтэй.”

Дайныг зохицуулах дүрэм журмыг тэрээр дараах байдлаар тоймложээ:

“Хэрэгцээгүйгээр дайсанд учруулсан хохирол бүхэн, мөн түүнчлэн ялалт авчрах буюу дайныг эцэслэх зорилгогүй аливаа дайсагнасан үйлдэл... жам ёсны эрх зүйгээр шийтгэгддэг.”

- Улс үндэстнүүдийн эрх зүй, 1758 он (1834 онд Жозеф Читти орчуулсан бөгөөд Хошууч Генерал J.F.C. Фуллер дээрх бичлэгийг иш татав), Дайны зан үйл, 1789-1961, Ратгарсийн Их Сургуулийн Хэвлэл Мэдээлэл, 1961 он

- Дайн хийхийг шударга ёсонд нийцнэ гэж шүүх шүүгч байхгүй гэдэгтэй та санал нийлж байна уу?
- Аль нэг талын дайн эхлэх шалтгааныг буруушаахгүй байх нь гэм буруу тулгахаасаа энх тайванд хүргэх илүү магадлалтай гэдгийг хүлээн зөвшөөрөх үү?
- Де Ваттелийн “жам ёсны эрх зүйгээр шийтгэх” гэж томъёолсон нь дайны хуулийг бүрдүүлэх сайн үндэслэл болж чадах уу?

Хөтөлбөрийн эцэст ямар асуултад хариулсан, яmart нь хариулаагүй байгааг тодорхойлохын тулд “хялбар бус хариулт” буланг дахин харах хэрэгтэй.

### Багш нарт

#### 4. Дилеммаг ашиглах

Диллема нь зэвсэгт мөргөлдөөний үед үүсдэг ёс суртахууны шийдвэр гаргах ярвигтай талбарт сурагчдыг уриалан дууддаг. Ийм ярвигтай асуудал үүсэх наад зах нь З шалтгаан байдаг:

- ▲ Аливаа шийдвэр ихэнх хүмүүст нөлөөлдөг бөгөөд тэдний хувь заяа болон тухайн шийдвэрийг хүлээн авах байдал нь эргээд бусад хүмүүст нөлөөлдөг.
- ▲ Аливаа шийдвэр зарим нь урьдчилан таахын аргагүй хоёрдогч үр дагавартай байдаг.
- ▲ Ганц оролдлогоор зорилгodoо хүрнэ гэж байхгүй. Нэг чухал зорилгын төлөө үйлдэл нөгөө зорилгод хүрэхэд саад болох нь элбэг байдаг. Тийм үчраас, “Сөргөлдөгч зорилгууд” нь дилемма үүсэх нэг шалтгаан болдог.

“Дилемма” гэдэг нэр томьёог ихэвчлэн нэрийн төдий хэрэглэдэг боловч, хүмүүнлэгийн тусlamж шаардлагатай болсон нөхцөл дилеммаг шийдвэрлэхийн төлөө тэмцэл нь томоохон үр дагавар дагуулдаг. Энэ нь амьдралыг уу, эсвэл үхлийг сонгох уу гэсэн асуудал ч байж болох юм. Алийг нь ч сонгохгүй гэж шийдсэнээр дилеммагаас зайлсхийж чадахгүй бөгөөд учир нь юу ч хийхгүй байна гэдэг нь сонголт хийж байна гэсэн үг юм. Дилеммад дүн шинжилгээ хийх аргыг үр дүнтэй ашиглахын тулд багш нар сурагчидтай хамтран дараах хоёр асуултыг задлан шинжлэх хэрэгтэй: Дилемма гэж юу вэ? Үр дагавар нь юу вэ?

#### Зорилго

- ▲ “Дилемма” ба “сөргөлдөгч зорилгууд” хэмээх ойлголтуудыг мэдэж авахад нь сурагчдад туслах
- ▲ Зэвсэгт мөргөлдөөний үед ёс суртахууны шийдвэр гаргахад ихэвчлэн учирдаг ярвигтай байдлыг мэдрэх, ойлгоход сурагчдад туслах
- ▲ Сурагчдад төлөв байдлыг тодорхойлох дадлага олгох
- ▲ Санаатай бус ба урьдчилан хараагүй үр дагавар зэрэг үр дагаврын тухай ойлголт өгөх
- ▲ Үр дагаврын гинжин хэлхээнд дүн шинжилгээ хийх талаар танилцуулах

#### Эхлэх

1. Дилемма хэмээх ойлголтыг дүрслэн харуулахын тулд танил зүйр үг, хэллэгүүдашиглахыг сурагчдад санал болгосноор хичээлээ эхэлнэ. (“Хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага хөөрхий” гэх мэт). Дилемма гэж юу болох талаар санаагаа хэлэхэд нь урам өгнө. Сурагчдаас жишээ гаргахыг хүсэн, тодорхой жишээнүүд нь хэрхэн дилемма болж байгааг тайлбарлана.
2. Диллеманы гол цөмийг тодорхойл. Диллеманы гол шинж чанарыг тодорхойлоход сурагчдад тусална. Үүнд:
  - ▲ Янз бүрийн үйлдэл дундаас (юу ч хийхгүй байх нь үүнд багтана) заавал сонгох шаардлагатай нөхцөл байдал
  - ▲ Сонголт бүрд давуу болон сул тал байdag

3. “Хийхэд зөв зүйл”-ийг сонгох нь хэцүү бөгөөд “дорой нөхцөл байдлаас хүртэл ээрэг үр дүн гаргана” гэдэг бололцоогүй юм шиг санагддагыг сурагчдад сануулаарай. Учир нь:

- ▲ Боломжит сонголт бүр асуудал дагуулах магадлалтай
- ▲ Сонголтуудын үр дагавар ямар байх нь тодорхойгүй байдаг.

4. Таны зорилгод нийцэх ямар нэг дилеммаг сонгоно. Сургалтын материалуудад янз бүрийн диллеманы нөхцөл байдлууд өгөгдсөн байгаа.

### Бүлгийг удирдах

Диллеманы талаар хэлэлцүүлэг удирдахдаа дараах дөрвөн үе шатыг мөрдөнө.

#### 1. Дэвшүүлсэн үйлдлүүдийг судлахын тулд хэд хэдэн асуултуудыг танилцуулна.

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн сургалтын материалд өгөгдсөн түүхэн жишээнүүдийн нэгийг, эсвэл сурагчдын хэлсэн диллема жишээг ашиглана. Диллемад хариу болгон хэд хэдэн үйлдлийг санал болгохыг сурагчдаас хүснэ. Дараа нь, үйлдэл тус бүр ямар үр дүнтэй байж болохыг судлах зорилгоор дараах асуултуудыг тавина. Үүнд:

- ▲ Таны дэвшүүлсэн үйлдлийн болзошгүй эцсийн үр дүн юу вэ?
- ▲ Өөр үр дүн байж болох уу? (Зохимжтой бол үр дүн гаргах үйлдлүүдийн гинжин хэлхээг болон тус бүрийнх нь эцсийн үр дүнг судал.)
- ▲ Тухайн нөхцөлд мэдэгдэхгүй байгаа болон урьдчилан тааж болшгүй зүйлс юу вэ?
- ▲ Өөр ямар хүмүүс оролцож байна? Тэдэнд таны үйлдэл яаж нөлөөлөх вэ? Бусдын үзэл бодол эцсийн үр дүнд нь яаж нөлөөлөх вэ?

Дэвшүүлсэн үйлдэл тус бүрт дээрх асуултуудыг тавина. Явц дунд сурагчид аажим аажмаар асуултыг өөрөө өөртөө тавьдаг болно. Сайн асуулт тавьж сурна гэдэг нь хүүхэд, залуучууд диллемад дүн шинжилгээ хийхтэй холбоотой ойлголт болон ур чадварт суралцаж байгаагийн баталгаа юм.

#### 2. Диллеманы ярвигтай байдалд дүн шинжилгээ хийх

Сурагчдад дараах асуултуудыг тавингаа дэвшүүлсэн үйлдлүүдээ өөр хооронд нь харьцуулсны үндсэн дээр сонголт хийхийг хүснэ:

- ▲ Сонгосон үйлдэл таны хүссэн үр дүнд хүргэхэд хэр өгөөжтэй вэ?
- ▲ Сонголт тань урт хугацаанд янз бүрийн сөрөг асуудлуудыг үүсгэх магадлал хэр байна вэ?
- ▲ Таны үйлдэл ямар зорилготой вэ? Яагаад тэр зорилгыг сонгов?
- ▲ Сонгосон үйлдэл тань бусад чухал үйлдлүүдийг үл ойшоо буюу саад учруулж байна уу?

Дээрх эргэцүүллийн ярвигтай талыг ойлгосны үндсэн дээр тоймлоно уу.

#### 3. Үр дагавруудын гинжин хэлхээг тодорхойлох

Сурагчдаас дараах үйлдэл буюу үйл явдлын боломжит үр дагавруудыг тодорхойлохыг хүснэ үү:

- ▲ Загасчид далайд загасчилж явтал шуурга дэгдэж завь нь хөмрөв.
- ▲ Анчин хандгай буудав.

Сурагчдад зарим үйлдлүүд бусад үр дагаварт хүргэх үр дагавартай байдаг гэдгийг ойлгоход тусал. Үүнийг гинжин нөлөө гэж нэрлэдэг. (Шуурга – завь хөмрөх – загасчны үхэл – гэр бүлийн гашуудал, ядуурал гэх мэт)

Зарим үр дагавар тодорхой зорилготой байж болно (анчин гэр бүлийнхээ төлөө ан хийж хоолтой залгуулна, тэгээд...). Гэтэл зарим нь зорилгогүй байж болно (Үхсэн хандгай саяхан төрсөн бөгөөд янзага нь өнчрөн хоцрох...гэх мэт).

### 4. Үр дагавруудын гинжин хэлхээг мөрдөж олох

Нэг үйл явдал нь үр дагавруудыг хөдөлгөөнд оруулж, эдгээрийн зарим нь эргээд олон үр дагавар төрүүлэх нөхцөл байдлыг сурагчдаар олуулна. Энэ нь ярвигтай гинжин хэлхээ үүсгэнэ.

#### Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Сурагчид шууд дүгнэлтэд хүрч болно. Ийм тохиолдолд сурагчдыг нэг алхам ухраад үйлдэл болон үр дагаварт дүн шинжилгээ хийхийг уриал.
- ▲ Заримдаа нөхцөл байдал хэтэрхий төвөгтэй байж болно. Сурагчид цөхөрч, урам нь хугарч болно гэдгийг хүлээн зөвшөөрөөрэй.

#### Үнэлгээ

Өөрсдийн туршлагадаа түшиглэн ямар нэгэн дилеммаг бичгээр дүрслэхийг сурагчдаас хүснэ.

- ▲ Сөргөлдөгч зорилгууд нь юу байсан бэ?
- ▲ Ямар боломжит үйлдлүүд гарсан бэ?
- ▲ Үйлдсэн үйлдлийн нөлөө нь юу байсан бэ?
- ▲ Боломжит үр дагаврууд болон гинжин нөлөө нь юу байсан бэ?

## Багш нарт

### 5. Дүрд тоглох

Дүрд тоглох нь “бусдын оронд байсан бол” яах байсныг мэдэх, туршлагыг жүжигчилсэн маягаар амьдрвуулах боломж олгодог. Амжилттай тоглолт нь урьдчилсан бэлтгэл болон дараа нь явагдах хэлэлцүүлгээс бүрддэг.

#### Зорилго

- ▲ Сурагчдад өгөгдсөн нөхцөлд олон талт төлөв байдгийг илүү ойлгуулах
- ▲ Сурагчдад хүмүүнлэгийн үйл ажиллагаатай холбоотой байж болох ёс суртахууны диллемаг ойлгуулах
- ▲ Бусдын туршлагатай холбогдоход нь туслах

#### Эхлэх

- ▲ Тухайн нөхцөл байдлыг сайтар тайлбарласнаар сурагчид ямар дүрд юу шаардлагатайг мэдэж авна.
- ▲ Байршил, цаг хугацаа, орчин, нөхцөл байдлын мэдээлэл зэргийг танилцуулснаар сурагчид тухайн дурд тоглох нөхцөл байдлынхаа хаана явж байгаа талаар төсөөлөлтэй болно.
- ▲ Дүрээ тодорхойлоход нь туслах зорилгоор сурагчдад асуулт тавина. Энэ хүн юу хүсч байна, яагаад? Энэ хүн ямар үр дүнд хүрэхэд найдлага тавьж байна вэ?
- ▲ Бэлтгэх, дүрд тоглох, хэлэлцэхэд хугацаа хуваарилах хэрэгтэй.

#### Бүлгийг удирдах

Дүрд сайн тоглохын тулд дараах 4 алхамыг баримтална:

- 1. Бэлтгэл.** Түүхэн жишээ буюу диллемаг танилцуулна. Нөхцөл байдал, тухайн асуудлыг хэлэлцэх хангалттай цаг хугацаа хэрэгтэй. Гол анхаарах асуудлууд нь “Дүрд хэн тоглож байна вэ?” гэхээсээ илүү “Сэдэв нь юу вэ?” “Ямар нөхцөл байдалтай байна вэ?” “Оролцож байгаа хүмүүс ямар шийдвэр гаргахыг оролдож байна вэ?” зэрэг юм. Бэлтгэл хэлэлцүүлэг хамгийн шийдвэрлэх хэлэлцүүлэг байdag. Дүрд тоглох дасгал нь амжилтгүй болсон хэдий ч, бүлэг нь хэлэлцүүлгээс ихийг сурч авдаг. Цөөхөн хүнтэй бүлэгт хуваан дүр ногдуулснаар хэд хэдэн сурагчид нэгэн дүрд тоглох боломжтой болдог. Өгөгдсөн дүрүүдийн хүн чанарыг судлан үнэлэхийг эрхэмлэн засаршгүй гэмт хэрэгтний дүр сонгохоос зайлсхийхийг зөвлөөрэй. Сурагчдын асуултад хариул.
- 2. Сургуулилт.** Найруулагчийн хувьд таны үүрэг бол сурагчид зөв хийж байгааг хянах явдал юм. Дүрээ сургуулилж байгаа үед нь бяцхан дэмжлэг болон өөр арга хэмжээ авч болно. Сурагчдын бүтээлч оролцоог бууруулахгүй гэдгийн дор хэтэрхий их найруулж болохгүй.
- 3. Тоглолт.** Энэ нь дүрд тоглогчийн жинхэнэ завшаан билээ. Та үзэгчдэд хандан янз бүрийн даалгавар, тухайлбал, аль нэг дүрийг оноон түүнийг болон түүний гаргах шийдвэрийг сайтар ажиглах даалгавар өгч болно. Бэлтгэл хэлэлцүүлэг болон тоглолт дундуурх даалгавар нь үзэгчид хүүхдүүдийн жүжиглэх ур чадварыг сонирхоос илүү хөндөгдөж буй тухайн түүхтэй холбоотой асуудлууд, мэдрэмжүүдэд анхаарлаа хандуулахад тустай.

**4. Дүгнэлт.** Хэлэлцүүлгийн үед болон дүрд тоглосны дараа жүжиглэлтээр гарч ирсэн асуудлууд дээр санал бодлоо хуваалцахыг уриална. Сурагчдад зориулсан гарын авлага дээрх асуултуудыг авч үзнэ. Сурагчдаас дүрд тоглосон туршлагадаа дүн шинжилгээ хийхийг, эсвэл тоглолтыг ажиглаад төрсөн сэтгэгдэл болон дэвшүүлсэн асуудал, туршлага зэргийг хэр зэрэг тусгаж авч байгааг асууна. Дүрүүдийн аль нэгний хувьд шинэ ойлгоц, төлөв байдал олж авсан уу? Юу нь болж юу нь болохгүй байсан бэ? Юуг өөрөөр хийх байсан бэ? Сурагчдыг энэхүү дасгалын үндсэн зорилгоо дахин нэг санаахийц тэмдэглэгээ хийснээр дүгнэлтээ дуусгаж болно.

### Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Дүрд тоглох нь хүнийг хөгжөөдөг тул асуудлын мөн чанарыг алдагдуулж болох талтай. Түүнчлэн хүчтэй сэтгэлийн хөдөлгөөнний илрэл инээд нь сэтгэл санаа тайвшуулж чаддаг. Сурагчид (дүрд тоглогчид болон үзэгчид) хэтэрхий их инээж магадгүй. Энэ үед сурагчдад үйл ажиллагааны гол сэдвийг сануулах хэрэгтэй.
- ▲ Хэрэв сурагчид төгсгел нь ямар ч байж болох түүхийн дүрд тоглоод яг юу болсныг мэдмээр байгаа тохиолдолд тэдний сониуч зан, сонирхсон асуултанд хариулан бодит төгсгөлийг хэлж өгөх хэрэгтэй.

### Зогсолт.

“Зогсолт” гэдэг нь эгзэгтэй чухал агшинд дүрд тоглогчид жүжиглэлээ түр зогсоон “хөшөө” мэт хөдөлгөөнгүй зогсохыг хэлнэ. Зогсолтыг ямар нэг шийдвэрийн үр дагаврыг дүрслэн харуулах буюу диллеманы гол цөм, далайцыг харуулахын тулд хэрэглэнэ. Тухайн бүлэг нь ямар шийдвэр гаргах гэж байна вэ? Жүжиглэлтэй харьцуулахад зогсолт нь түүхэн жишээг бүхэлд нь авч үзэлгүйгээр хэд хэдэн хурцад мал асуудалд сурагчдын анхаарлыг төвлөрүүлдэг давуу талтай.

### Үнэлгээ

Хэлэлцүүлгийг ашиглан дүрд тоглох дасгал дууссаны дараа тухайн түүхтэй холбоотой асуудал, диллемаг сурагчид хэрхэн ойлгосныг болон сурагчид бусдын оронд өөрийгөө тавьж үзэх чадвар хэр байгааг тодорхойлж болно.

## Багш нарт

### 6. Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах тухай

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь хүний оюун ухаан, зүрх сэтгэлд хүрч ажиллахыг чухалчилдаг. Тийм ч учраас сурагчид дайнд оролцогсод болох хохирогчид, цэргүүд болон хүмүүнлэгийн ажилтнуудын оронд өөрсдийгөө тавьж үзэх боломжтой. Ингэхийн тулд тус хөтөлбөр нь соёлыг түгээх уламжлалт арга болох ярьж хүүрнэн ярих хэлбэрийг ашигладаг. Дэлхийн олон янзын соёлоос эх үүсвэртэй эдгээр түүх, яриа нь ерөнхийдөө ёс суртахууны шийдвэр гаргах тухай өгүүлсэн байдаг. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь сурагчдыг бодит байдалтай танилцуулж, хэлэлцүүлгийг өрнүүлэхийн тулд түүх ярихаас гадна фото зураг, дүрс бичлэгүүдийг ашигладаг билээ.

#### Зорилго

- ▲ Түүх, фото зураг болон дүрс бичлэгээр дамжуулан сурагчдын сэтгэн бодох чадварыг өдөөх
- ▲ Сурагчдад аливаа ухагдахууныг ойлгоход туслах төсөөлөл дүр зураг, орон зайгаар хангах
- ▲ Аливаа хэлэлцүүлгийн суурь болгон сурагчдад нийтлэг туршлага олгох

#### Эхлэх

- ▲ Аливаа түүхийг ашиглахын өмнө “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалуудад санал болгосон асуудлууд болон суурь мэдээллүүдтэй танилцах хэрэгтэй.
- ▲ Боломжтой бол агуулгатай гүнзгий танилцан хэлэлцүүлгийн цагийг уртасгахын тулд, хичээлийн өмнө өгүүллэгийг уншиж ирэх даалгавар өгөх нь зүйтэй. (дараа нь ангид тоймлон авч үзнэ)
- ▲ Зорилго болон агуулгыг тайлбарласан зургийн эвлүүлгийг үзүүлнэ. Жишээ нь, “Эдгээр нь дайны улмаас шилжин нүүсэн хүмүүсийн зургууд юм” гэх мэт.
- ▲ Дүрс бичлэг үзүүлэхийн өмнөх бэлтгэл болгон танилцуулга хийх, бичлэг дотроос онцолж харах зүйл, ямар нэг асуулт байвал тавих хэрэгтэй. Бичлэг дээрх тодорхой мэдээллийг онцлохын тулд дүрс бичлэгийн тайлбарыг ашиглана.

#### Бүлгийг удирдах

- ▲ Түүх сонсож, зураг харж, бичлэг үзсэний дараа тухайн сэдвээр шүүн хэлэлцэхийн өмнө сурагчдаар тэдний бодол санаа, төрсөн сэтгэгдлийг бичүүлнэ. Зарим түүхийн хувьд шийдвэр гаргах шаардлагатай мочид түр зогсон хэлэлцэх хэрэгтэй болдог. Ийм тохиолдолд өмнөх (Багш нарт 5: Дүрд тоглох) бүлэгт авч үзсэн “зогсолт” аргыг хэрэглэж болно.

Түүх, фото зураг болон дүрс бичлэгийг шүүн хэлэлцэх үед тавигдах онцгой асуултууд дээр нэмж та дараах ерөнхий асуултуудыг бодолцоно уу.

Нөхцөл байдал:                   Хэн аюулд өртөд байна вэ? Аюулын мөн чанар юу вэ?

Хөндлөнгөөс ажиглагчид гэж хэн бэ?

Сонголт:                         Хөндлөнгөөс ажиглагчдад байгаа боломжит хувилбаруудыг тодорхойл.

## Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах тухай

Үр дагавар:	Үйлдэл (санаатай/санаагүй, эерэг/сөрөг, богино болон урт хугацаат гэх мэт) бүрийн үр дагаврыг тодруулан тодорхойл.
Төлөв байдал:	Тухайн нөхцөл дэх өөр хоорондоо ялгаатай үзэл бодлуудаас урган гарах үр дагавруудыг авч үзнэ.
Шийдэл:	Та ямар шийдвэр гаргах вэ? Яагаад?

Хэлэлцүүлгийн үед сурагчид дараах асуултуудыг авч үзэх болно. Үүнд:

- ▲ Хувь хүний амь нас, нэр хүндэд ямар аюул заналхийлж байна вэ?
- ▲ Өөр боломжит үйл ажиллагааны хувилбарууд бий юу?
- ▲ Үйлдэл тус бүрийн үр дагавар юу байх вэ?
- ▲ Гаргасан шийдвэрийн үндэслэл юу вэ?
- ▲ Нийгмийн дарамтын үүрэг юу вэ?

Зарим судалгаа нь зэвсэгт мөргөлдөөн, хүмүүнлэгийн үйл ажиллагааны туршлагатай холбоотой сурагчдын гэр бүл, уламжлалт соёлоос эх үүсвэртэй түүх, яриаг гаргаж ирэхийг зорьдог.

Сурагчдын оруулсан хувь нэмэр бүхий материалуудыг үзүүлэн, жижиг хэмжээний ном, хичээлийн гарын авлага болгох, курс хичээлийн агуулгад багтаах, ямар нэг ухагдахуун буюу туршлагыг дүрслэн үзүүлэхэд хэрэглэн дэлхийн бусад суралцагчидтай хуваалцахын тулд “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн вебсайтад тавьж болно.

### Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Түүх, фото зураг болон дүрс бичлэг нь хүмүүсийн сэтгэлийг хүчтэй хөдөлгөж болно. Тухайн материалаас үүсэлтэй сэтгэлийн хөдлөлөө илэрхийлэхэд сурагчдад байнга бололцоо олгож байх хэрэгтэй.
- ▲ Ямар нэг дүр төрх, төсөөлөл нь хэн нэгэн сурагчид маш хүчтэй нөлөөлсний улмаас тухайн хичээлд оролцохгүй байхыг хүсч магадгүй бөгөөд энэ нь зүй ёсны хэрэг юм.
- ▲ Асуудалтай тулгарсан сурагчтай цаг тухайд нь ярилцаж байх хэрэгтэй.

### Үнэлгээ

- ▲ Сурагчид түүх, фото зураг болон дүрс бичлэгийг илүү өргөн ухагдахууныг ойлгоход ашиглаж байна уу?
- ▲ Сурагчдаас аливаа ухагдахууныг дүрслэн үзүүлэхийн тулд ямар нэгэн түүх, зураг, гар зураг болон дүрс бичлэг хийхийг хүснэ үү.

### Багш нарт

#### 7. Бичих ба эргэцүүлэн бодох

“Бичиж байгаагаа харахаас нааш би юу бодож байгаагаа яаж мэдэх билээ дээ?!?” - C. S. Lewis

Суралцах үйл явцтай бичих чадварыг бүрэн дүүрэн хослуулсан нөхцөлд сурагчид сайн ойлгодог гэдгийг боловсролын нэгэн судалгаа харуулсан байдаг. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээл нь сурагчдад хичээл дээр юу ойлгосноо бичих ур чадвар эзэмшиг бололцоог олгодог.

#### Зорилго

- ▲ Оролцогч бүрт хэлэлцэх асуудлуудын талаар эргэцүүлэн бодох бололцоо олгох
- ▲ Нийт бүлгийнхний саналыг сонсохоос өмнө бодол санаагаа бичгээр буулгах
- ▲ Бичгээр санаагаа илэрхийлэх дадлагатай болгох
- ▲ Дараа нь нягтлах, эргэцүүлэн бодох, цаашид бичиж судлах зорилгоор ашиглаж болох тэмдэглэл хөтлүүлэх

#### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” сэтгүүл гаргах

Боломжтой бол сурагчдаар хичээл дээр бичсэн зүйлээ эмхэтгэн, сэтгүүл буюу файл хийлгэх нь тохиромжтой. Энэхүү сэтгүүл нь сурагчдыг дүгнэх зорилготой бус, зөвхөн тэдэнд санал бодлоо илэрхийлэх, тэмдэглэл хийж сурх орчин бүрдүүлэх явдал юм. Анх удаа бичихэд нь үсэглэл, дүрэм, цэг таслалын талаар санаа зовохгүй байхыг анхааруулна. Хамгийн гол нь тэд бичгээр санаа бодлоо илэрхийлэх чадвартай болоход оршино. Учир нь сэтгүүлд бичигдсэн материалууд нь цаашид сэдвийг гүнзгийрүүлэн судлах, албан ёсны эссе, өгүүлэл бичих үндэс суурь болж өгдөг. Ахлах ангийн сурагчид эдгээр туршлага дээр тулгуурлан цаашдын бие даасан судалгаа явуулах боломжтой.

#### Бичлэгийн бусад төрлүүд

Бичлэгийн олон янзын хэлбэрүүдийг ашиглах бололцоог сургалтын материалууд агуулсан байгаа. Үүнд:

- ▲ Өгүүллэг, дилемма, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх
- ▲ Хувийн түүх, өгүүлэлмж хөтлөх
- ▲ Ярилцлагын материал бэлдэж, ярилцлагагаа бичгээр буулгах
- ▲ Судалгааны тайлан бичих
- ▲ Асуудал шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулах
- ▲ Түүхэн жишээ, түүхийн баримтаас бичих
- ▲ Хичээлийн явцад гарч ирсэн шинэлэг санаа, ухагдахуун, сэдэвтэй холбогдуулан эссе бичих
- ▲ Сурагчид өөрт тохиолдсон туршлага, мэдээллээ баримтжуулах
- ▲ Дэлхийн хэмжээнд эсвэл ангидaa мэтгэлцэж буй асуудлын талаар байр сууриа илэрхийлж бичих
- ▲ Хамтран “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” товхимол гаргах

Дэлхий даяар бусад сурагчидтай санал бодол, байр сууриа хуваалцахын тулд бичсэн зүйлсийн заримыг “Хүмүүнлэгийн Эрх зүйг Судлах нь” хичээлийн вебсайтад тавьж болно.

### Эхлэх

Сурагчдаас хэлэлцүүлэг эхлэхийн өмнө фото зураг, дүрс бичлэг, асуулт болон асуудал зэргээс төрсөн бодол, сэтгэгдлээ бичихийг хүснэ. Тэд ганц хоёр үг, үгс, бүтэн өгүүлбэр бичиж болно. Тэдний бодол санааг бичгээр буулгахад гол зорилго оршино.

### Бүлгийг удирдах

- ▲ Сурагчид юу бичих гэж байгааг, ямар мэдээллийд ашиглагдахыг тодорхой тайлбарлана.
- ▲ Бичих хугацааг хэлнэ.
- ▲ Бичихэд нь санаа өгөхүүц үзүүлэн материал хэрэглэж байгаа бол хүссэн үедээ харж болох газар өлгөх буюу хувилж тараана.
- ▲ Асуултад хариулах хэлбэрийн бичлэг бол асуултыг самбар дээр бичнэ.
- ▲ Ахлах ангийн сурагчдад нээлттэй асуулт тавьж болно.
- ▲ Бага ангийн сурагчдад “энэ зургийг хараад би бodoхдоо ...” гэх мэт өгүүлбэр гүйцээх дасгал тохиромжтой.

### Хүндрэлийг шийдвэрлэх

Бичихэд бэрхшээлтэй байгаа бол сурагчид бодол санаагаа өөр аргаар, тухайлбал зургаар илэрхийлж болно. Сурагчид зурсан зургаа тайлбарлаж байхад багш уг санааг бичгийн хэлбэрээр яаж илэрхийлэхийг зааж тусална.

### Үнэлгээ

- Бичих дасгал үйл ажиллагааны зорилгод хүрэхэд хэрхэн дэмжлэг үзүүлсэн бэ?
- Сурагчид бичсэн зүйлсээ санаа бодлоо илэрхийлэхэд хэр зэрэг ашигласан бэ?
- Сурагчид “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” сэтгүүлийн санаагаа хэрхэн судалгаа болон үйл ажиллагааны төсөл болгож болох вэ?

## Багш нарт

### 8. Ярилцлагын үед

Хэн нэгэн хүний амьдралын туршлагаас сонсохоор урьж авчрах нь сурагчдад асуулт асуух болон дайны талаар шууд ярилцах боломж олгодог. Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн үндсэн зарчмуудыг судлах явцад багш буюу ангийн хамт олон зохих хүнтэй ярилцлага хийхээр товлож болно. Тэр хүн нь дайны тэргүүн шугаманд байж үзсэн ахмад дайчин, хүмүүнлэгийн ажилтан, энгийн иргэн эсвэл сэтгүүлч байж болно. Сурагчид мөн ангиасаа гадуур хэн нэгэнтэй ярилцлага хийж болно. Хэнтэй ярилцаж байгаагаас шалтгаалан зорилго, асуултын төрлүүд янз бүр байж болно.

#### Зорилго

- ▲ Туршлагатай анхдагчдаас мэдээлэл цуглуулах
- ▲ Ярилцлага авах ур чадварыг дээшлүүлэх

#### Эхлэх

- ▲ Хэнтэй ярилцах сонирхолтой байгаа талаар сурагчидтай хэлэлцэх
- ▲ Ямар туршлага, мэргэшилтэй, хэн гэдэг хүн ирэх гэж байгаа талаар бүлэгт мэдээлэл өгөх
- ▲ Зочиндоо тавих асуултуудыг бэлтгэх зорилгоор брейнсторминг буюу оюуны довтолгоон хийн гарсан саналуудыг жагсаан бичнэ. Жишээ нь:
  - Хүмүүнлэгийн үйлст гар бие оролцож буй бусад хүмүүсийн жишээнээс та мэдэх үү?
  - Ямар нэг аюулаас аврагдсан өөр хэн нэгний талаар та мэдэх үү?
  - Хүчирхийллийн үед цэргүүд ямар зан үйлтэй байх талаар та ямар сургалтанд хамрагдсан/ хамрагдах бэ/вэ?
  - Цэргүүд хүнлэг зан үйлтэй байхын учир юунд байна вэ? Эсвэл хүнлэг бус байхын?
  - Хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд хамгийн бэрхшээлтэй асуудал юу байсан бэ?
  - Ямар диллема танд болон бусдад тулгарч байсан бэ?

Бүлэгт тавихыг хүссэн асуултуудаа сонгохыг даалгавар болгоно. Ганцаарчилсан асуулт байвал сурагчдаар тодорхой асуултуудыг бичүүлнэ. Ангиас гадуур бие даан ярилцлага авах гэж буй сурагчид түүх яриулж түүнийгээ хүмүүнлэгийн агуулгад оруулахад нь туслах асуултуудыг урьдчилан бэлдвэл зохино.

#### Бүлгийг удирдах

- ▲ Бүлгийн нэг гишүүнд зочныг хүлээн авах, танилцуулах зэрэг хөтлөгчийн үүрэг даалгана.
- ▲ Ярилцлага хийх хугацааг тогтоон агуулгыг боловсруулж ямар үйл явцтай байхыг бичнэ.
- ▲ Сурагчид бэлдсэн асуултаа тавина.
- ▲ Ярилцлагын асуулт, хариултын солилцоог явц дунд шаардлагад нийцүүлэн өөрчилж болно.
- ▲ Ярилцлагын төгсгөлд бүлгийг төлөөлөн зочинд талархал илэрхийлэн үдэх нэг сурагчийг сонгоно.

## Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Зочны яриа сунжирч магадгүй. Эсвэл сэдвээсээ хазайн өөр зүйл ярьж болно. Энэ үед харилцан яриаг удирдан зөв сэдэв рүү нь буцааж оруулах буюу зочноос сурагчдын асуултад хариулахыг хүсэх хэрэгтэй.
- ▲ Ангиас гадуур ярилцлага авч буй сурагчдад хүмүүст ухаалаг асуулт тавихад нь туслах шаардлага гарч магадгүй.

## Үнэлгээ

- ▲ Ярилцлагын дараа зочноос юу сурч мэдэж авсан ба тэр нь судалж буй тодорхой сэдэв болон Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйтэй ерөнхийд нь хэрхэн холбогдох талаар сурагчдаар бичүүлнэ.
- ▲ Бүлэг нь ярилцлага хэр болсон болон дараагийн удаа юуг өөрөөр хийж болох талаар шүүн хэлэлцэж болно.
- ▲ Дайн буюу хүмүүнлэгийн төлөв байдлын талаар найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ ярилцсан сурагчид энэхүү мэдээллээ ангийнхантайгаа хуваалцан ярилцаж болно.

### Багш нарт

#### 9. Бичил бүлгээр ажиллах

Хүмүүнлэгийн ажлыг ганцаараа бие даан санаачилж болох боловч, цаашид амжилттай үргэлжлүүлэхэд багаар ажиллах шаардлага гардаг. Бичил бүлгээр ажилласнаар бодол санаагаа хуваалцан, ур чадвараа хөгжүүлэхэд дөхөмтэй. Энэхүү сурх бичигт бүлэгт зориулсан ажлууд нилээд багтсан байгаа. Бүлгийн гишүүдийг хэвээр нь байлгаж эсвэл үйл ажиллагаа өөрчлөгдөх тутам гишүүнчлэлийг өөрчилж болно.

Бүлгийн ажлын амжилт нь дараах гурван зүйлээс шалтгаална. Үүнд:

- ▲ Тавьсан зорилтоо тодорхой зааварчилгаатай өгөх
- ▲ Боломжит цаг хугацаа
- ▲ Нийт бүлгийн өмнө уран төсөөлөлтэй, үр дүнтэй илтгэл тавьж чадахуйц байх.

#### Зорилго

- ▲ Хэлэлцүүлэг болон асуудал шийдвэрлэхэд сургч бүрийг оролцуулах
- ▲ Манлайлах, хамтран ажиллах ур чадварт сургах

Бичил бүлгээр ажиллах үед сургчид:

- ▲ Аман ба бичгэн харилцааны ур чадварын болон хамтарч асуудал шийдвэрлэх дадлага хийх
- ▲ Манлайлал, хариуцлагаа ухамсарлах
- ▲ Мэдээллийг тайлагнах буюу сурталчлан түгээх
- ▲ Нийт бүлгээр ажиллахаас илүү үйл ажиллагаанд идэвхитэй оролцох магадлалтай
- ▲ Бодол санаагаа хуваалцах, өргөжүүлэх, шинэ санаа эрэлхийлэх, шийдвэр гаргах
- ▲ Багаар ажиллах туршлагатай болох
- ▲ Шинэ мэдээллийг мэдрэмжтэйгээр хүлээн авах боломжтой.

#### Эхлэх

- ▲ Сургчид бүлэгтэй хуваалцахаас өмнө зохистой үед санаа бодлоо бичгээр илэрхийлнэ. Энэ нь сургч бусдын санааг сонсохоос өмнө өөрийнхийгөө томьёолоход тусална.
- ▲ Тухайн зорилго, үйл ажиллагаагаар хүсэн хүлээж буй үр дүнд шаардлагатай бүлгийн хэмжээ, шинж чанарыг тодорхойлно.
- ▲ Сургчид хос болон хувийн туршлагаа солилцон үзэл бодлоо харьцуулах буюу тодорхой үйлдэл дээр нэгдсэн дүгнэлт гаргана. Хувийн туршлагаа нийт бүлэгтэй хуваалцаж болох бөгөөд нэг нэгэндээ ярьсан ч болно.
- ▲ Аливаа асуудлын талаар сургч бүр санал бодлоо илэрхийлэх боломж олгохыг хүсвэл 3-5 хүнтэй бичил бүлгийг ашиглана.
- ▲ Зорилго, янз бүрийн шалгуураар сургчдыг бүлэгт хуваана. Жишээлбэл, тухайн үйл ажиллагаанд нэмэрлэх туршлага, ур чадварын түвшин, эсвэл нас, хүйс, чадвар болон зэрэгцэн сууж болох эсэх зэрэг шалгууртай. Ижил шинж чанар, төрлөөр сонгогдсон бүлгийнхэн нэг дороо ажиллаж болох бөгөөд ажиллах хурд нь ойролцоо байдгаараа бусад бүлгүүдээс ялгагдана. Холилдсон бүлэгт зарим нь манлайлах буюу зааварлах үүрэгтэй байхад, нөгөө хэсэг нь янз бүрийн ур чадвар, туршлага бүхий бусад сургчидтайгаа харилцахыг илүүд үздэг.

### Бүлгийг удирдах

- ▲ Тавьсан зорилт, хүлээгдэх үр дүнг тодорхой болгоно.
- ▲ Тавьсан зорилтоо биелүүлэхэд шаардагдах эх сурвалж, мэдээллийг тодорхойлж, түүгээр хангана.
- ▲ Зорилтонд хүрэх цагийн хязгаарыг тогтооно.
- ▲ Зуучлагч, тэмдэглэл хөтлөгч, сурвалжлагч зэрэг үүргүүдийг бүлэг дотор хуваарилна.
- ▲ Зуучлагч, тэмдэглэл хөтлөгч, сурвалжлагчийн үүргийг тайлбарлаж эдгээр үүргээ биелүүлэхэд нь сурагчдад тусална.
- ▲ Бүлгийн ажлыг илтгэх арга, тухайлбал аман илтгэл, зураг, диаграм, “зогсолт”, жүжиг гэх мэт хэлбэрийг тодорхойлно.
- ▲ Бүлгийн ажлын ахицын талаар асуух ба дэвшил гарсан эсэхийг шалгана. (Бүлгийн ажлыг залгаж авч болохгүй гэдгийг анхаарна уу.)

### Хүндрэлийг шийдвэрлэх

- ▲ Сурагчид тавьсан зорилтод анхаарлаа төвлөрүүлэхгүй буюу зааварчилгааны ойлгохгүй байвал зорилтоо өөрөө эсвэл сурагчдаар дахин томьёолуулна. Зааварчилгааг хананд хадаж болно.
- ▲ Бүлгийн гишүүд санал зөрөлдөөнөө шийдвэрлэж чадахгүй байвал тэднийг зөвшилцэлд хүрэхэд нь туслах, эсвэл тэднээс ялгаатай үзэл бодлоо илэрхийлэхийг хүсээд цаашид ажлаа хэрхэн үргэлжлүүлэх төлөвлөгөө боловсруулахад нь тусална.
- ▲ Хэрэв зарим сурагч бүлэгт давамгайлах хандлага гаргавал бүлгээр ажиллахын утга учир, зорилго болон зорилтоо биелүүлэхэд гишүүн бүр оролцохын ач холбогдлыг дахин тайлбарлаж өгнө.
- ▲ Бүлгүүдийн тайлан, агуулга нь давтагдах шинжтэй болж магадгүй. Ийм тохиолдолд зөвхөн нэг бүлгийг тайлангаа бүрэн тавихыг хүсээд бусад бүлгээс дурдагдаагүй зүйл дээр нэмж тайлагнахыг хүснэ.

### Үнэлгээ

- Сурагчид хамтран ажиллаж даалгавар гүйцэтгэхдээ хэр чадварлаг байсан бэ?
- Сурагчид ямар ур чадварыг ил тод харуулсан бэ?
- Бүлгийн гишүүн хүнд байх ёстой ямар ур чадвар сурагчдад дутагдалтай байна вэ?
- Дараагийн удаа та юуг өөрөөр хийе гэж бодож байна вэ?
- Агуулгыг ойлгоход Бичил бүлгээр ажиллах нь ямар хувь нэмэр оруулсан бэ?

### Багш нарт

#### 10. Түүх, мэдээ цуглуулах

Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг судлахдаа энэхүү хичээлийн хөтөлбөрт багтсан материалаас гадна хичээлээс гадуур эх сурвалжаас мэдээлэл нэмж ашиглахыг сурагчдад зөвлөнө. Эдгээр нь хэвлэл мэдээлэл, ном, гэр бүлийнхэн болон орчин тойрны хүмүүсийн амьдралд тохиолдсон туршлага, үе уламжлан яригдаж ирсэн түүх зэрэг байж болно. Иймэрхүү материалыудыг хичээлийн хөтөлбөрт хамтатгаж болно.

#### Зорилго

- ▲ Онгөрсөн болон өнөө үеийн дэлхий дахины хүмүүнлэгийн үйлсийн талаар сурагчдын мэдлэгийг дээшлүүлэх
- ▲ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй, хүмүүнлэгийн үйл ажиллагаатай холбогдсон үйл явдал, асуудлуудыг сурагчдад танин мэдүүлэх
- ▲ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн сахиулалт, хэрэгжүүлэлтийн талаарх мэдээллийг баримтжуулахыг уриалах

#### Эхлэх

Бүлэг бүрийн сүүлийн хэсэгт “Хэвлэлийн хуудас” байгаа. Энэхүү хуудсын зорилго нь Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн болон хүмүүнлэгийн төлөв байдал, учир шалтгааны талаарх сурагчдын мэдлэгийг дээшлүүлэхэд оршино. Жишээ нь, 1-р Бүлэгт сурагчдаас найз нөхөд болон гэр бүлийн гишүүдээсээ хүмүүнлэгийн үйлсийн талаар ярилцлага авах, эсвэл сонин сэтгүүл, радио, телевиз, номноос мэдээлэл олж ирэхийг хүссэн байгаа. Тэдний түүх, мэдээлэл нь нууцлагдсан, эсвэл хувийн шинж чанартай байж болохыг сануулна.

Дараагийн бүлгүүдэд хэвлэл мэдээлэл, уран зохиол болон цэрэгт явж байсан буюу хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцож явсан хүмүүстэй ярилцах зэрэг бусад эх сурвалжаас түүх, мэдээлэл цуглуулах зорилтыг сурагчдад тавина.

#### Бүлгийг удирдах

- ▲ Сурагчдад судалгаа хийх даалгавар өгөхдөө тэдний боловсруулсан түүх, тайлан, мэдээллийг цуглуулан ашиглах хэрэгтэй. Жишээ гаргаж ирсэн сурагчид бусдадаа үлгэр дууриал болох бөгөөд хувь нэмэр оруулаагүй сурагчдад өөрсдөө мэдээлэл олох хүсэл зориг, санаа төрүүлэх давуу талтай.
- ▲ Сурагчдын бэлтгэсэн материалыг дэлгэцээр үзүүлэх, бяцхан ном болгох, ярьж танилцуулах зэргээр олон янз, хэлбэрээр ашиглана.
- ▲ Сурагчдын цуглуулсан хүмүүнлэгийн үйлсийн тухай түүхэн жишээг хичээлийн агуулгын нэгэн хэсэг болгон ашиглаж болно. Хичээл бүрийн эхэнд нэг түүхийг товч танилцуулах зорилгоор сонгоно.
- ▲ Тухайн үйл ажиллагааны сэдвийг дүрслэн харуулахын тулд сурагчдын цуглуулсан түүхээс нэг буюу хэд хэдийг ашиглана. Жишээлбэл, 5-р Бүлгийн үйл ажиллагаанд дүрвэгч буюу шилжин нүүсэн хүнийг хамгаалсан хэн нэгний тухай хэвлэл мэдээллийн жишээг ашиглаж болно. 2-р Бүлэгт сурагч анхан шатны сургалтаар дайны хууль дүрмийг хэрхэн зааж байсан талаарх цэргийн дурсамж яриаг ашиглаж болно. Эсвэл дайны гэмт хэрэгтэнг шүүх оролдлогын талаарх мэдээллийн хайчилбар ч байж болох юм. Ийм жишээнүүд нь Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлж болох талаар ойлголт, эерэг сэтгэхүйг төрүүлэх болно.

- ▲ Сурагчдын бэлтгэсэн материалуудыг жүжигчилсэн үзүүлбэр бэлтгэх, дилемма хэлэлцэх үйл ажиллагааны эх үүсвэр болгон ашиглаж болно.

### Хүндрэлийг шийдвэрлэх

Хэрэв сурагчид хүмүүнлэгийн үйлсийн жишээ болж чадахгүй түүх цуглуулсан бол тэдгээрийг хүмүүнлэгийн үйлс гэж юу вэ гэдгийг тодорхойлоход ашиглана. Энэхүү хөтөлбөрт онцгойлон авч үзэж байгаа хүмүүнлэгийн үйлсийн шинж чанаруудыг дахин дурдах хэрэгтэй.

### Үнэлгээ

- Сурагчдын цуглуулсан түүхэн жишээ, мэдээлэл нь Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн ухагдахуунуудын талаарх ойлголтын юуг харуулж байна вэ?
- Эдгээрийг хийлгэхэд түүхээс сурагчдын ярилцлага авах чадвар сайжирсан эсэх нь ямар байдлаар ажиглагдаж байна вэ?

### Сургалт семинар

Сургалт семинарууд нь “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн үндсэн ойлголт, үйл ажиллагаанууд болон тэдгээрийг заахад ашиглах чухал стратегиудыг танилцуулна. Эдгээр сургалтуудыг нэг сургагч багш бие даан явуулж болох боловч тусдаа сургалтуудыг оролцогч багш нар өөрсдөө зохион байгуулна. Багаар болон ганцаарчилсан бүх сургалтыг багш нар удирдаж явуулна. Сургалт бүр 6 хэсэгт хуваагдана. Үүнд:

- ▲ **Зорилго:** Тухайн сургалтын зорилгыг авч үзнэ.
- ▲ **“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалуудыг ойлгох:** энэ хэсэгт багш нар сурагчдын адил материалуудыг гүнзгий судлах бололцоотой.
- ▲ **Туршлага:** энэ хэсэгт сургалтанд оролцогч багш нар бусад багш, сургалтыг хөтлөн явуулагч нар яг ижил материалыг хэрхэн ашиглаж буйг харуулсан видео клипүүдийг үзнэ.
- ▲ **Заах аргадаа нэвтрүүлэх:** энэ хэсэгт багш нар суралцсан материалаа хэрхэн заах талаар өөрийн төлөвлөгөө боловсруулна.
- ▲ **Үнэлгээ:** энэ хэсэгт багш, хэлэлцүүлгийн удирдагч нар өөрсдөө болон сурагчид “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлээс юу сурч мэдэж авсныг үнэлэх аргуудыг боловсруулна.
- ▲ **Дараагийн сургалтанд бэлдэх:** энэ хэсэгт дараагийн сургалтыг удирдах багшийг томилж, унших материалыг олгоно.

[5-р Сургалт нь Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх зүйг түгээн сурталчлах, заах талаар мэргэжсэн хүнийг урих зэрэг нарийвчилсан бэлтгэл ажил шаарддаг. Сурагчдын дэвшүүлж буй дүрэм, журмыг дүрс бичлэгээр оролцогчидтой цуг үзсэний дараа зочин Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн талаар илтгэл тавих бөгөөд оролцогчидтой хамтран Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг сурагчдад заахтай холбоотой асуултуудыг шүүн хэлэлцэнэ.]

Сургалтыг тухайн улс оронд буюу бүсчилсэн хэлбэрээр 1-2 долоо хоногийн зуны сургалт байдлаар зохион байгуулж болно. Нөгөө талаар хичээлийн жилийн үеэр 2 долоо хоногт нэг удаа үдээс хойш буюу амралтын өдрүүдэд нэг сургуулийн багш нар дангаараа эсвэл бусад сургуулийн багш наортай хамтарч сургалтаа явуулж болно. Хэдийгээр мэргэжил нэгтнүүдтэйгээ хамт суралцах нь хамгийн үр ашигтай арга боловч зарим багш нар энэхүү удирдамжийг бие даан судлах боломжтой.

Долоо хоногийн сургалт нь өдөр бүр семинарт 3 цаг зарцуулахаар төлөвлөгдсөн. (Хоёр долоо хоногийн сургалтын хувьд, өдөрт нэг удаа семинараа явуулж үлдсэн цагийг нь хичээлийн материалтай танилцуулахад зориулна.) Сургалт бүрийн эхний хоёр цаг нь “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материал, заах аргыг ойлгох болон энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бусад багш нарын дүрс бичлэгээр дамжуулан “туршлагыг” үзэж суралцахад зориулагдана. Сүүлийн нэг цагаа багш нар уг хөтөлбөрийг өөрийн заах аргад хэрхэн нэвтрүүлж, сурагчдын ойлголтыг яаж үнэлэх талаар төлөвлөгөө гаргахад зарцуулна.

Дүрс бичлэгийн клипүүд сургалтуудад дараах санамжийг өгдөг. Багш болгон өдөр тутам хичээл заах явцад оргил үе болон бүтэлгүйтлийг биеэрээ туулдаг. Зарим дүрс бичлэг зөвхөн оргил үеүдийг нь харуулан багш нарын бүтэлгүйтсэн туршлагыг орхигдуулснаар танхимиийн сургалтын жинхэнэ дүр төрхийг алдагдуулах тал бий. Ангид багш нар нэг л болохгүй байгаа үед юу нь болохгүй байна вэ гэж гайхах буюу урам хугарах байдалд оруулахгүйн тулд дүрс бичлэгийн клипүүдийн дээрх хандлагыг сануулж байх хэрэгтэй.

## **Багш боловсролын сургалтын төлөвлөгөө**

### **Сургалт 1. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг сурагчдад танилууллах:**

*Оришил судалгаа: Төсөөлөл ба ойлголт*

*Багши нарт 1: Хэлэлцүүлэг*

*Багши нарт 2: Брейнсторминг буюу оюуны довтолгоо хийх*

*Багши нарт 3: “Хялбар бус хариулт”*

*Дүрс бичлэг ба тайлбар: “Удирдах хэлэлцүүлэг: Оришил судалгаа” (4:00)*

### **Сургалт 2. Дүрд тоглох: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?**

*Судалгаа 1A: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ? (“Алхам алхмаар”)*

*Судалгаа 1B: Хүмүүнлэгийн үйлс ( “Дайны халуун цэгээс ирсэн дуу хоолой - 1”)*

*Багши нарт 5: Дүрд тоглох*

*Багши нарт 6: Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах*

*Багши нарт 9: Бичил бүлгээр ажиллах*

*Дүрс бичлэг ба тайлбар: “Сурагчдын хариултыг нэгтгэн: Хүмүүнлэгийн*

*үйлс” ( 7: 39)*

### **Сургалт 3. Диллема: Хөндлөнгөөс ажиглагчийн диллема**

*Судалгаа 1C: Хөндлөнгөөс ажиглагчийн диллема*

*Багши нарт 4: Дилеммаг ашиглах*

*Багши нарт 9: Бичил бүлгээр ажиллах*

### **Сургалт 4. Хүний нэр хүндийг фото зураг ашиглан судлах нь.**

*Судалгаа 2A: Сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах нь (2, 3 ба 4-р алхам)*

*Багши нарт 1: Хэлэлцүүлэг*

*Багши нарт 6: Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах*

*Дүрс бичлэг ба тайлбар: “Хүний нэр хүндийг фото зураг ашиглан*

*судлах нь” ( 7: 14)*

### **Сургалт 5: Сурагчдын үзэл бодол: Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн үндэс:**

*Судалгаа 2A: Сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах нь (5, 6-р алхам)*

*Багши нарт 8: Ярилцлага*

*Дүрс бичлэг ба тайлбар: “Сурагчдын үзэл бодол: Зэвсэгт мөргөлдөөний уед ямар*

*дүрэм журам хэрэгтэй вэ?” ( 5:06)*

## **Багш боловсролын сургалтын төлөвлөгөө**

### **Сургалт 6: Дүрс бичлэг: “Цэрэг” хүүхдүүдийн тухай**

Судалгаа 2С: “Цэрэг” хүүхдүүд - (Зургийн эвлүүлэг 2С), дүрс бичлэг ба тайлбар:

“Би буцаж явмааргүй байна” (7:53)

Багши нарт 7: Бичих ба эргэцүүлэн бодох

Багши нарт 6: Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах

Багши нарт 9: Бичил бүлгээр ажиллах

Дүрс бичлэг ба тайлбар: “Дүрс бичлэг үзэх: Бэлтгэл ба хэлэлцүүлэг”

1-р хэсэг: Бэлтгэл: Хүүхэд гэж хэн бэ гэдгийг хэлэлцэх (8:20)

2-р хэсэг: “Би буцаж очмооргүй байна” дүрс бичлэгийг авч хэлэлцэх (5:44)

Дүрс бичлэг ба тайлбар: “Сурагчдын илтгэлүүдээс: “Хэрвээ та дэлхийтэй ярьж чаддагсан бол” (6:39)

### **Сургалт 7. Хэргийн судалгаа: Ми Лай тосгонд – Юу нь болоод, юу нь болоогүй вэ?**

Судалгаа 3С: Хэн хариуцлага хүлээх вэ? (алхам 2)

Хэргийн судалгаа – Ми Лай тосгонд, болон

Дүрс бичлэг ба тайлбар: “Ми Лай тосгонд бид юу хийчих вэ?” (18:55)

Багши нарт 6: Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах

### **Сургалт 8. Бүлгийн ажил: Дайны үр дагавруудад хариу үзүүлэх нь**

Судалгаа 5А: Дайны сүйрэл, хор хөнөөлөөс үүсэх хэрэгцээ.(1, 2, 3-р алхам) -

Дүрс бичлэг ба тайлбар: ”Гэрээс нь хүчээр зайлгуулжсээ” (3:55)

Судалгаа 5С: Хоригдлуудыг хамгаалах – Дүрс бичлэг ба тайлбар: ”Харанхуй дахь гэрэл” (5:02) ба “Хоригдол дурсан санаж байна” (2:50)

Багши нарт 9: Бичил бүлгээр ажиллах

### **Сургалт 9. Хувийн туршилагыг ашиглах: “Төвийг сахих” ба “шуударга” зарчим**

Багши нарт 1: Хэлэлцүүлэг

Багши нарт 7: Бичих ба эргэцүүлэн бодох

Судалгаа 5Е: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүй (1, 2 – р алхам)

Дүрс бичлэг ба тайлбар: ”Төвийг сахих” ба “шуударга” зарчмуудыг хувийн туршилага ашиглан ойлгох нь” (6:18)

### **Сургалт 10: Сурснаа ашиглах: Залуучуудын төсөл**

Дүгнэлт судалгаа: Цаашид юу хийх хэрэгтэй вэ?

Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина – Дүрс бичлэг ба тайлбар:

“Жүжгээр дамжуулан дайныг судлах” (4:00)

Дүрс бичлэг ба тайлбар: “Газрын минад хүний амь үрэгдсээр л байна” (8:18)

## 1.“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг сурагчдад таниулах

“Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн эхний хичээл буюу оршил судалгаа нь уг хөтөлбөрийн гол асуулт, асуудлуудыг дэвшүүлж тавихаас эхэлдэг. Үүнтэй нэгэн адил эхний сургалт нь багш нарт дээрх асуудлуудыг дэвшүүлэх бөгөөд сургалт, судалгаа аль аль нь оролцогчдын үзэл бодлыг судлах зорилготой. Оршил судалгаа нь нээлттэй хэлэлцүүлгийн шинж чанартай. Энэ үе шатанд асуултуудын “зөв” хариулт гэж байхгүй бөгөөд хүн бүр энэ сэдвээр мэдээлэлтэй гэж үзэхгүй.

### Зорилго (10 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг тоймлох:

- ▲ “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн хөтөлбөрийг сурагчдад хэрхэн танилцуулах талаар суралцах
- ▲ Мэдлэг багатай сэдвээрээ хичээл заах арга боловсруулах
- ▲ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн тухай баримтат болон ёс зүйн асуултуудыг судлах
- ▲ “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн турш хэрэглэгдэх “хялбар бус хариулт”-ын механизмыг тодруулах

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (60 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалтад ашиглах дор жагсаасан мэдээллийг хэдэн минут анхааралтайгаар уншина уу.

Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт

Багш нарт 1: Хэлэлцүүлэг

Багш нарт 2: Брейнсторминг буюу оюуны довтолгоон хийх

Багш нарт 3: “Хялбар бус хариулт”

#### 2. Судалгааг удирдан явуулах

Оролцогч багш бүр өөр өөр асуулт асууж хэлэлцүүлгийн нэг хэсгийг удирдах ёстой.

#### 3. Хэлэлцүүлэг

Тэмдэглэлдээ бичсэний дараа хамтрагчтайгаа санал бодлоо хуваалцана.

- ▲ Ямар асуудлууд хамгийн хурц хэлэлцүүлэгт хүргэсэн бэ?
- ▲ Сурагчдын сонирхлыг ямар асуултууд хамгийн их татах вэ?
- ▲ Хэлэлцүүлгийн үеэр таны удирдсан асуултаас гарсан сайн үр дүн юу вэ? Ямар бэрхшээл танд учирсан бэ?

### Туршлага (60 минут)

#### 1. Дүрс бичлэгийн тайлбарыг уншина.

#### 2. Үзэхэсээ өмнө дараах асуултыг хэлэлцэнэ:

## 1. “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг сурагчдад таниулах

► Оршил судалгааны зорилтууд юу вэ?

3. Дүрс бичлэг: “Удирдах хэлэлцүүлэг: Оршил судалгаа” (Ямайк, 14-15 настай сурагчид)  
Багш танилцуулах харилцан ярианы зорилгыг тайлбарлана. Брейнсторминг буюу олон санал дэвшүүлэх аргыг ашиглан сурагчид зэвсэгт мөргөлдөөн болон байлдагчид биеэ хэрхэн авч явах талаар янз бүрийн санал бодлоо дэвшүүлнэ. Тэд өөрийн орны туршлагатай харьцуулан ярилцана.

4. Хос хосоороо хэлэлцэх:

- Оршил судалгааны тавьсан зорилтууд хэр хангагдсан гэж та бодож байна вэ?  
► Багш хэр удирдсан бэ? Хэлэлцүүлгийн ямар арга техникийг ашигласан бэ?  
►Дайны тухай сурагчид юу мэддэг юм шиг санагдсан бэ? Мөн дайны хязгаарлалтуудын талаар?  
►Дүрс бичлэг дээрх хэлэлцүүлгийг танай хэлэлцүүлэгтэй харьцуулахад ямар байна вэ?

5. Дүрс бичлэгийг дахин үзнэ.

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоор буюу жижиг бүлгээр хэлэлцэнэ.

- Энэ судалгааг ашиглан хэлэлцүүлэг удирдахад ямар асуудал тулгарна гэж та бодож байна вэ?  
“Оршил судалгаа: Төсөөлөл ба ойлголт”-ыг заах хичээлийн төлөвлөгөө боловсруулна.  
Үнэлгээний аргуудыг бас оруулна.

### Үнэлгээ (20 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоор буюу жижиг бүлгээр хэлэлцэнэ.

- Энэ хичээлийн агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?  
► “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг зааснаар таны хүсэн хүлээж буй үр дүн юу вэ?  
► Та юунд найдаж байна вэ?  
► Та юунаас эмээж байна вэ?  
► Танд ямар асуултууд байна вэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 2. Дүрд тоглох: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

### Зорилго (10 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг тоймлох:

- ▲ Дүрд тоглох аргыг судалж ашиглах
- ▲ Хөндлөнгөөс ажиглагчийн ойлголттой танилцах

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (100 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалтын өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой.  
Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 1A: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

Судалгаа 1B: Хүмүүнлэгийн үйлс

Багш нарт 5: Дүрд тоглох

Багш нарт 6: Түүх, фото зураг болон дурс бичлэг ашиглах

Багш нарт 9: Бичил бүлгээр ажиллах

#### 2. Судалгааг удирдан явуулах

Сонгогдсон оролцогчид “Өсөн нэмэгдэх үйл ажиллагаанууд хүмүүнлэгийн хүчин чадлыг хэрхэн бүрдүүлдэг вэ” хэмээх дүрд тоглох үйл ажиллагаанд санал болгосон дарааллыг (судалгааны эцэст байгаа) ашиглан судалгаа 1A-г удирдана. (30 минут)

#### 3. Хэлэлцүүлэг

Сурагчдын дунд ашиглахаар төлөвлөсөн асуултуудыг дүрд тоглогчийн үүднээс хэлэлцэнэ:

- Та өөрийн дүр сонголтын талаар та юу бодож байна вэ? Яагаад?
- Уг түүхэнд гарч буй бусад хүмүүсийн хийсэн сонголтын талаар таны бодол? Яагаад?

Одоо үзэгчдийн байр сууринаас дүр гүйцэтгэлийг хэлэлцэнэ үү:

- Дүрд тоглох нь өөр хүний оронд өөрийгээ тавьж сурахад тань яаж тусалсан бэ? Илүү үр өгөөжтэй болгох арга байсан уу?
- Та ямар асуудлуудын талаар өөрийн эрхгүй бодож эхэлсэн бэ?
- Дүрд тоглосны дараа хэлэлцэх ямар чухал асуудлууд байна вэ?
- Дүрд тоглосноор таны хүмүүнлэгийн үйлсийн мөн чанарын тухай ойлгоц ямар байдлаар гүнзгийрч нэмэгдсэн бэ?

#### 4. Судалгаа 1B: Хүмүүнлэгийн үйлс (30 минут)

## 2. Дүрд тоглох: Хөндлөнгөөс ажиглагчид юу хийж чадах вэ?

### Туршлага (30 минут)

1. Дүрс бичлэгийн тайлбарыг уншаад дараа нь үзэхийн өмнө дараах асуултыг эргэцүүлэн бодно уу:  
➤ Сурагчид хүмүүнлэгийн төлөв байдлын талаарх ойлголтоо яаж илэрхийлж байна вэ?
2. “Сурагчдын хариуг нэгтгэн: Хүмүүнлэгийн үйлс“ бичлэгийг үзнэ. (Марокко, 13-15 наасны сурагчид)

Багш нь хүмүүнлэгийн үйлсийн тухай ойлголтыг цэгцлэн ярьж байна. Сурагчдаар хүмүүнлэгийн үйлсийн жишээ хэлүүлэн тэдгээрийг сөрөнхийлөн схемчилж байна.

### 3. Хос хосоороо хэлэлцэх:

- Сурагчид хүмүүнлэгийн төлөв байдлын талаарх ойлголтоо яаж илэрхийлж байна вэ?

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоор буюу жижиг бүлгээр хэлэлцэнэ:

- Та энэ үйл ажиллагааг сурагчидтайгаа хэрхэн удирдан явуулах вэ?  
➤ Сурагчдыг дүрд тоглоход хэрхэн бэлдүүлэх вэ?  
➤ Сурагчдад тань ямар асуудал тулгарч болох вэ?

Эдгээр судалгааг заах хичээлийн төлөвлөгөөгөө бичнэ үү.

### Үнэлгээ

Тэмдэглэлдээ бичээд дараа нь жижиг бүлгээр хэлэлцэнэ:

- Энэ хичээл дээр үнэлгээний ямар арга ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?  
➤ Энэ хичээлийн агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?  
➤ Танд ямар асуулт байна вэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

### 3. Дилемматай ажиллах: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма

#### Зорилго (10 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг тоймлох:

- ▲ Дилемматай ажиллахад сурагчдыг хэрхэн удирдах талаар суралцах

#### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (60 минут)

##### 1. Үншиж тодруулах

Сургалтын өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой.  
Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 1C: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма

Багш нарт 4: Дилеммаг ашиглах

Багш нарт 9: Бичил бүлгээр ажиллах

##### 2. Судалгааг удирдан явуулах

Сонгогдсон оролцогчид Судалгаа 1C-г удирдан явуулна.

##### 3. Хэлэлцүүлэг

Үйл ажиллагааны дараа бичил бүлгүүд нийт бүлэгтээ тэдний үүрэг юу байсан, бичил бүлгээр ажиллахад юу нь чухал байсан талаар тайлagnана.  
Дилемма ашиглах үед шаардагдах үндсэн арга, алхмуудыг тодорхойлно.

#### Туршлага (60 минут)

Одоо буцаад багшийн байр сууринаас дилеммад дүн шинжилгээ хийх туршлагаа тоймлон авч үзье.

- Багшийн хувьд таны хариу үйлдэл юу байсан бэ? Хэлэлцүүлэг дээр ямар асуудлууд гарч ирсэн бэ?
- Таны сурагчид энэ судалгаанд хэрхэн хандах бол?
- Дилемматай ажиллах 4 үе шатыг сурагчид тань хэр амжилттай гүйцэтгэсэн бэ?
- Ангидaa дилемматай ажиллахтай холбогдуулан танд ямар асуулт байна вэ?

### 3. Дилемматай ажиллах: Хөндлөнгөөс ажиглагчийн дилемма

#### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо эсвэл бичил бүлгээр хэлэлцэнэ:

- Та ийм үйл ажиллагааг сурагчидтайгаа хэрхэн удирдан явуулах вэ? Ямар асуудал тулгарна гэж таамаглаж байна вэ?
- Судалгаа 1С-г заах хичээлийн төлөвлөгөө бичнэ үү. Үнэлгээний аргыг оруулна.

#### Үнэлгээ (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо хэлэлцэнэ:

- Энэ хичээл дээр үнэлгээний ямар арга ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?
- Энэ хичээлийн агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?

#### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 4. Хүний нэр хүндийг фото зураг ашиглан судлах нь

### Зорилго (10 минут)

Бүх оролцогчидтой хамтран сургалтын зорилго, хөтөлбөрийг тоймлон хэлэлцэнэ:

- ▲ Хэлэлцүүлэгт сурагчдыг оролцоог хэрхэн идэвхжүүлж ашиглах вэ гэдгийг эргэцүүлэн бодох
- ▲ Үзэл бодол, шинэлэг санаа төрүүлэхэд фото зургийн ач холбогдол ямар байх талаар судлах

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (60 минут)

#### 1. Уншиж тодруулах

Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 2А: Сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах нь

Багш нарт 1: Хэлэлцүүлэг

Багш нарт 6: Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах

#### 2. Судалгааг удирдаж явуулах

Сонгогдсон оролцогчид фото зургуудыг (“Нүдээ боолгосон олзлогдогч” ба “Олзлогдогчдын марш”) тарааж судалгаа 2А-ийн 2, 3 ба 4-р алхмуудыг гүйцэтгэнэ.

#### 3. Хэлэлцүүлэг

Үйл ажиллагаа явуулсны дараа хос хосоороо буюу бичил бүлгээр доорх асуудлуудыг хэлэлцэнэ:

- Зургийг хараад та ямар хариу үйлдэл, сэтгэлийн хөдлөл үзүүлсэн бэ?
- Таны оролцоонд фото зургууд ямар хувь нэмэр оруулсан бэ?

### Туршлага (60 минут)

#### 1. Дүрс бичлэгийн тайлбарыг уншаад доорх асуултуудаас нэг, хоёрыг уг бичлэгийг тоймлон хэлэлцэх гол асуулт болгон сонгоно:

- Фото зураг сурагчдын оролцоонд ямар хувь нэмэр оруулдаг вэ?
- Эргэцүүлэн бодоод бичих нь хэлэлцүүлгийн оролцоог хөхиулэн дэмжихэд яаж хэрэглэгдэж байна вэ?
- Багшийн үүрэг юу вэ?
- Сурагчдын саналбодлоо солилцохыг хөхиулэн дэмжихэд ямар стратегиудашиглагдсан бэ?
- Багш хөндлөнгөөс оролцож болох боловч оролцоогүй тохиолдлууд байсан уу?

#### 2. “Хүний нэр хүндийг фото зургууд ашиглан судлах нь” бичлэгийг үзнэ. (Өмнөд Америк, 16-17 настай сурагчид)

Багш нь зэвсэгт мөргөлдөөний үед хүний нэр хүндийг хамгаалах тухай сэтгэгдэл, санаа төрүүлэх зорилгоор нүдийг нь боосон олзлогдогчийн зургийг ашиглаж байна.

## 4. Хүний нэр хүндийг фото зураг ашиглан судлах нь

3. Бичлэгийг үзсэний дараа бичил бүлгүүдээр буюу бүгдээрээ дараах асуудлуудыг хэлэлцэнэ:
- Бичлэг үзсэний дараах таны хариу үйлдэл, сэтгэлийн хөдлөл ямар байна вэ?
  - Дүрс бичлэг дээр нэг сурагч асуулт асуухад багш нь хариулахгүй байна. Яагаад тэр вэ? Та ямар нэг байдлаар өөрөөр хандах байсан уу?

### Өөрийн заах аргад нэвтрүүлэх (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо буюу бичил бүлгээр дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Энэ судалгааг та хэрхэн өөрийн бүлэгт тохируулж хэрэглэх вэ?
- Судалгаа 2А-г заах хичээлийн төлөвлөгөө бичнэ үү.

### Үнэлгээ

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Энэ хичээл дээр үнэлгээний ямар арга ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?
- Энэ хичээлийн агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг хэрхэн удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.
- ▲ Дараагийн сургалтанд Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн мэргэжилтнийг урих бэлтгэл ажлыг хангаж, тэрхүү зочиндоо сургалтанд ямар зорилго, үүрэгтэй байх талаар тодорхой мэдээлнэ.

## 5. Сурагчдын үзэл бодол: Олон улсын хүмүүнлэгийн эрхзүйн үндэс

### Зорилго (10 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг бүгдээрээ тоймлон хэлэлцэнэ:

- ▲ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн зарим үндсэн дүрмүүдийг мэдэж авах
- ▲ Хүний эрх ба Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн хоорондын ялгааг ойлгох
- ▲ Дүрмийг дагаж мөрдөх хариуцлагын тухай асуудлыг авч үзэх
- ▲ Эдгээр мэдээллийг сурагчдад хэрхэн хүргэх талаар авч үзэх
- ▲ Зочноос ярилцлага авах аргыг ашиглаж суралцсан
- ▲ Шинэ сэдэв танилцуулах үед сурагчдын мэдлэг дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулах тухай судлах

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (40 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 2А: Сүйрэл, хор хөнөөлийг хязгаарлах

Багш наарт 8: Ярилцлага

#### 2. Судалгааг удирдаж явуулах

Сонгогдсон оролцогчид Судалгаа 2А-ийн 5, 6-р алхмыг удирдаж гүйцэтгэнэ.

### Туршлага (70 минут)

1. Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй ба хүний эрхийн талаар зочноор яриа хийлгэх бэлтгэл болгон сурагчид өөрсдийн дүрэм журмыг гарган ирж байгаа тухай дүрс бичлэг үзүүлнэ.
2. Зочинтойгоо хамт тайлбарыг уншингаа “Сурагчдын үзэл бодол: Зэвсэгт мөргөлдөөнд ямар дүрэм журам хэрэгтэй вэ?” бичлэгийг үзнэ. (Өмнөд Африк, 16-18 настай сурагчид)

Дайны үр дагаврыг харуулсан зургийн эвлүүлэг үзээд сурагчид зэвсэгт мөргөлдөөний үед ямар дүрэм журам шаардлагатай талаар өөрсдийн саналыг дэвшүүлнэ.

3. Зочноор Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй ба хүний эрхийн талаар яриулж эдгээр нь мөргөлдөөнт ба/буюу мөргөлдөөнт бус үед яаж хэрэглэгдэх талаар тайлбарлуулна.
4. Асуултуудыг нээлттэйгээр шүүн хэлэлцэнэ. Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн талаар сурч мэдсэнээ сурагчдад тайлбарлах үед учирж болзошгүй хүндрэлүүдийг авч үзнэ. Тэдгээрийг нийт бүлэг болон зочинтой хуваалцаж, шийдлүүдийг хамтдаа эрэлхийлнэ.

## 5. Сурагчдын үзэл бодол: Олон улсын хүмүүнлэгийн эрхзүйн үндэс

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх

Тэмдэглэлдээ бичээд бичил бүлгээр хэлэлцэнэ:

- Сурагчид Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг ойлгохын тулд хамгийн чухал 3 зүйл юу вэ?
- Судалгаа 2А-ын хичээлийн төлөвлөгөөг гүйцэтгэнэ.

### Үнэлгээ

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоор дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Энэ хичээл дээр үнэлгээний ямар арга ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?
- Энэ хичээлийн агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх нь

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг хэрхэн удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 6. Дүрс бичлэг: “Цэрэг хүүхдүүд”

### Зорилго (5 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг бүх оролцогчидтой хамтран хэлэлцэнэ:

- ▲ Хэлэлцүүлэг өрнүүлэх хэрэгсэл болгож дүрс бичлэгийг ашиглан судлах
- ▲ Хүүхдүүдийг цэрэг болгон ашиглаж байгаа тухай асуудал, материалуутдтай танилцах

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (80 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 2С: “Цэрэг” хүүхдүүд

Багш нарт 6: Түүх, фото зураг болон дүрс бичлэг ашиглах

Багш нарт 7: Бичих ба эргэцүүлэн бодох

Багш нарт 9: Бичил бүлгээр ажиллах

#### 2. Судалгааг удирдан явуулах

Сонгогдсон оролцогчид Судалгаа 2С-ын 1-4-р алхмуудыг удирдаж явуулна.

“Би буцаж очмооргүй байна” бичлэгийг үзээд тайлбартай уншиж танилцана. Судалгаа 2С-ын 5-р алхмыг гүйцэтгэнэ.

#### 3. Хэлэлцүүлэг

Үйл ажиллагааны дараа бичил бүлгүүдээр дараах асуудлыг хэлэлцэнэ:

► Танай орон нутагт энэхүү үйл ажиллагаанд хэрэглэж болохоор хүүхэд ба хүчирхийлэлтэй холбогдсон асуудал байна уу?

4. 3-р алхамд дурдсан “Хүүхдийн эрхийн тухай Конвенц”-ийн талаарх мэдээллийг тоймлон үзээд эдгээр мэдээллийг сурагчдад хэрхэн хүргэх талаар хэлэлцэнэ. Асуудал гарвал шийдвэрлэнэ.

### Туршлага (60 минут)

1. Дүрс бичлэг үзэхийн өмнө бичлэгийн тайлбарыг уншаад дараах асуултуудыг эргэцүүлэн бодно:

► Хүүхдийн эрх ашиг, хэрэгцээг хялбараар ойлгуулахад багш нар ямар үүрэг гүйцэтгэх вэ?  
► “Хүүхэд гэж хэн бэ?” гэсэн асуултыг авч үзсэнээр хүүхдүүд цэрэг болохын үр дагаврыг хэлэлцэхэд яаж тус болж байна вэ?

2. “Дүрс бичлэг үзэх: Бэлтгэл ажил ба хэлэлцүүлэг” бичлэгийг үзнэ. (Марокко, 13-15 настай сурагчид)

1-р хэсэг: “Би буцаж очмооргүй байна” бичлэгийг үзэх бэлтгэл болгон багш нар сурагчдаас “Хүүхэд гэж хэн бэ?”, “Хүүхдийн эрх ашиг, хэрэгцээ юу вэ?” гэсэн асуултуудыг анхааралдаа аваарай гэж хэлж байна.

2-р хэсэг: Энэ түүхэн жишээнд гарч буй янз бурийн дүрүүдийг хүүхдүүд анхааралдаа авч, “цэрэг” хүүхдүүдэд дайн хэрхэн нөлөөлж байгаа талаар, дэслэгч ба бусад насанд хүрэгчдийн үүргийн талаар санал бодлоо тайлагнан ярьцааж байна.

## 6. Дүрс бичлэг: “Цэрэг хүүхдүүд”

3. Хэлэлцүүлэг:

- “Албадлагын” болон “сайн дурын” цэрэг татлагын ялгаа, мөн энэ нь хүүхдэд яаж нөлөөлж байгаа талаарх ойлголтыг сурагчид хэрхэн илэрхийлж байна вэ?

4. “Сурагчдын илтгэл: Хэрвээ та дэлхийтэй ярьж чаддагсан бол” бичлэгийг үзнэ. (Өмнөд Африк, 16-18 настай сурагчид)

Багш сурагчдад “Цэрэг” хүүхдүүдийн асуудлаар байр сууриа олон нийтэд чөлөөтэй илэрхийлэх бололцоог олгож байна. Бичлэг дээр хүүхдүүд илтгэлээ уншицааж байна.

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (20 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хамтрагчтайгаа хэлэлцэнэ:

- “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн асуудлуудын ойлголтыг дээшлүүлэхэд сурагчдын туршлага, сонирхлыг та яаж ашиглах вэ?
- Судалгаа 2C-г заах хичээлийн төлөвлөгөөг боловсруулна уу.

### Үнэлгээ

Тэмдэглэлдээ бичээд дараа нь бичил бүлгээр дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Хоёр бүлгийн (Марокко ба Өмнөд Африкийн) хүүхдүүд цэрэг болсноор тэдний ирээдүйн хөгжилд ямар үр дагавар үлдээж байгаа талаар ойлгож авснаа хэрхэн илэрхийлж байна вэ?
- Сургалтын агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг хэрхэн удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 7. Хэргийн судалгаа: Ми лай тосгонд

### Зорилго (5 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг бүх оролцогчидтой хамтран тоймлон хэлэлцэнэ:

- ▲ Сурагчдыг хэргийн судалгаанд хэрхэн оролцуулах талаар мэдэж авах
- ▲ Эдгээр материалуудаас болж янз бүрийн сэтгэлийн хөдөлгөөн гарч болох талаар бэлтгэлтэй байх
- ▲ Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг хэрэгжүүлэх, сахиулахад учирж болох зарим асуудал, дилеммаг ойлгох

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (145 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг хамтдаа тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 3C: Хэн хариуцлага хүлээх вэ?

Хэргийн судалгаа: Ми Лай тосгон – Юу нь болоод, юу нь болоогүй вэ?

Багш нарт 6: Түүх, фото зураг болон дурс бичлэг ашиглах

#### 2. Судалгааг удирдан явуулах ( 95 минут)

Оролцогч Судалгаа 3C-ийн 2-р алхмыг удирдан явуулна.

Сонгогдсон оролцогчид “Хэргийн судалгаа – Ми Лай тосгонд...”-ын 1-р хэсгийг удирдан явуулна.

Дүрс бичлэгийн тайлбарыг уншаад “Ми Лай тосгонд бид юу хийчих вэ” бичлэгийг үзнэ.

#### 3. Хэлэлцүүлэг ( 10 минут)

- Дүрс бичлэгийг үзээд танд юу мэдрэгдэж байна вэ?
- Энэхүү бичлэг таны хувьд Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг хэрэгжүүлэх, сахиулах талаар ямар асуултуудыг төрүүлж байна вэ?
- Эдгээр асуултуудад хариулахад энэ үйл ажиллагаа яаж тус болох вэ?
- Эдгээр материалуудыг сурагчидтай хамтран судлахад танд ямар бэрхшээлүүд тохиолдож болох вэ?
- Сурагчдад энэхүү бичлэгийг үзүүлэхэд та юунд эргэлзэж, юунд найдаж байна вэ?
- Тэдний сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг та хэрхэн зохицуулах вэ?

#### 4. Судалгааг удирдан явуулах (40 минут)

Сонгогдсон оролцогчид “Хэргийн судалгаа – Ми Лай тосгон...”-ын 2-р хэсгийг удирдан явуулна.

## 7. Хэргийн судалгаа: Ми лай тосгонд

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (15 минут)

Тэмдэглэлдээ бичээд хос хосоороо буюу бичил бүлгээр хэлэлцэнэ:

- Энэ хичээлийг заахдаа та ямар өөрчлөлт оруулах вэ?

Хэргийн судалгааг судлах хичээлийн төлөвлөгөө боловсруулна уу.

### Үнэлгээ (10 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь бичил бүлгээр дараах асуудлүүдиг хэлэлцэнэ:

- Сургалтын агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?
- Энэ хичээлд үнэлгээний ямар арга барилууд ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг хэрхэн удирдах вэ гэдгийг шийднэ.
- Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 8. Бүлгийн ажил: Дайны үр дагавруудад хариу үзүүлэх

### Зорилго (5 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг бүх оролцогчидтой хамтран тоймлон хэлэлцэнэ:

- ▲ Сурагчдын оролцоог нэмэгдүүлэхэд Бичил бүлгийг ашиглах талаар судлах
- ▲ Үйл ажиллагаан дахь багш, сурагчдын оролцооны тэнцвэртэй харьцааг авч үзэх
- ▲ Дайны үр дагаврын тухай материалуудтай танилцах

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (115 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 5A: Дайны сүйрэл, хор хөнөөлөөс үүсэх хэрэгцээ

Судалгаа 5C: Хоригдлуудыг хамгаалах

Багш нарт 9: Бичил бүлгээр ажиллах

#### 2. Судалгааг удирдан явуулах

Сонгогдсон оролцогчид Судалгаа 5A-ийн 1-3-р алхмуудыг удирдан явуулна. (60 минут)  
“Гэрээс нь хүчээр зайлцуулжээ” бичлэгийг үзнэ.

Бусад сонгогдсон оролцогчид Судалгаа 5C-ийн 1-3-р алхмуудыг удирдан явуулна. (55 минут)

“Харанхуй дахь гэрэл” бичлэгийг үзэж хэлэлцэнэ.

Судалгаа 5C-ийн төгсгөлд “Хоригдол дурсан санаж байна” бичлэгийг үзэж хэлэлцэнэ.

### Туршлага (30 минут)

Бичил бүлгээр хэлэлцээд дараа нь нийт бүлэгтээ илтгэнэ:

- Судалгаа 5A-д таны сурагчид хэрхэн хандах бол? Энэ материалыг заахад танд ямар бэрхшээл учирна гэж таамаглаж байна вэ?
- Судалгаа 5C-д таны сурагчид хэрхэн хандах бол? Энэ материалыг заахад танд ямар бэрхшээл учирна гэж таамаглаж байна вэ?

### Өөрийн заах аргадаа нэвтшүүлэх (15 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоор буюу бичил бүлгээр дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Бичил бүлгээр ажиллахын давуу ба сул талуудыг та юу гэж үзэж, таамаглаж байна вэ?

Судалгаа 5A ба 5C-ийн хичээлийн төлөвлөгөөг боловсруулна уу.

## 8. Бүлгийн ажил: Дайны үр дагавруудад хариу үзүүлэх

### Үнэлгээ (15 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь бичил бүлгээр дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Сургалтын агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?
- Энэ хичээлд үнэлгээний ямар арга барилууд ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг хэрхэн удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 9. Хувийн туршлагыг ашиглах: “Төвийг сахих” ба “Шударга” зарчим

### Зорилго (10 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг бүх оролцогчидтой хамтран тоймлон хэлэлцэнэ:

- ▲ Ойлголт, ухагдахуунуудыг заахад хувийн туршлага ашиглах талаар судлах
- ▲ Бүхэл бүтэн үйл ажиллагааг заахад хэрэглэгдэх янз бүрийн стратегийг ажиглах
- ▲ “Төвийг сахих” ба “шударга” зарчмуудыг ойлгох

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалыг ойлгох (60 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Судалгаа 5E: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны ёс зүй

Багш нарт 1: Хэлэлцүүлэг

Багш нарт 7: Бичих ба эргэцүүлэн бодох

#### 2. Судалгааг удирдан явуулах

Сонгогдсон оролцогчид Судалгаа 5E-ийн 1, 2-р алхмуудыг удирдан явуулна.

### Туршлага (50 минут)

#### 1. Дүрс бичлэг үзэхийн өмнө бичлэгийн тайлбарыг уншаад дараах асуултуудыг авч үзнэ. 2 бүлэгт хуваагдаад дараах асуултуудыг нэг нэгээр нь тавина:

- “Төвийг сахих” ба “шударга” зарчмыг сурагчдад ойлгуулахад багш ямар стратегийг хэрэглэх вэ?
- Эдгээр зарчмуудын ойлголтыг сурагчид хэрхэн илэрхийлж байна вэ?

#### 2. ”Хувийн туршлага ашиглан аливаа ухагдахууныг ойлгох нь” бичлэгийг үзнэ.

(Өмнөд Африк, 14-15 наасны сурагчид)

Багш сурагчдаас тухайн ухагдахууныг тодорхойлохыг, дараа нь материалд өгөгдсөн тодорхойлолтыг дурдахыг хүсч байна. Сурагчид тухайн ухагдахуун нь хэрэглэгдэж буй жишээг тодорхойлж, тэд яагаад тийм сонголт хийснийг учирлан тайлбарлаж байна. Сурагчид дараа нь өөрсдийн хувийн туршлагадаа тулгуурлан богино өгүүллэг бичиж, дээрх ухагдахуунуудыг хэрхэн ойлгосноо илэрхийлж байна. Багш хэд хэдэн өөр арга хэрэглэн сурагчдад дээрх ухагдахуунуудыг ойлгуулах гэж оролдож байна.

#### 3. Бичлэг үзсэний дараа бүлгээрээ хэлэлцэх асуултууд:

- Сурагчдад тухайн ухагдахууныг ойлгуулахын тулд багш ямар стратеги хэрэглэсэн бэ? Хэр амжилттай байсан гэж бодож байна вэ?
- Сурагчдын ойлголтыг (буюу эс ойлголтыг) ямар нотолгоо харуулж байна вэ?

## 9. Хувийн туршлагыг ашиглах: “Төвийг сахих” ба “Шударга” зарчим

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь бичил бүлгээр дараах асуудлыг хэлэлцэнэ:

- “Төвийг сахих” ба “шударга” зарчмуудыг сурагчдад найдвартай ойлгуулж, хэрэглэдэг болгохын тулд та ямар стратеги баримтлах вэ?

Судалгаа 5Е-ийн хичээлийн төлөвлөгөөг боловсрууна уу.

### Үнэлгээ (10 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Сургалтын агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?
- Энэ хичээлд үнэлгээний ямар арга барилууд ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?

### Дараагийн сургалтанд бэлдэх

- ▲ Дараагийн сургалтанд аль оролцогчид судалгаануудыг хэрхэн удирдах вэ гэдгийг шийднэ.
- ▲ Чөлөөт цагаараа санал болгосон “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн материалууд болон багш нарт зориулсан санамжуудыг уншин дараагийн сургалтанд бэлдэнэ.
- ▲ Хэрэв та дараагийн сургалтын нэг хэсгийг буюу бүхлээр нь удирдах гэж байгаа бол хичээлээ төлөвлөх хэрэгтэй.

## 10. Сурснаа ашиглах: Залуучуудын төсөл

### Зорилго (5 минут)

Сургалтын зорилго, хөтөлбөрийг бүх оролцогчидтой хамтран тоймлон хэлэлцэнэ:

- ▲ “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийн төслүүдээр сурагчдад туслах арга замуудыг судлах
- ▲ Эдгээр сургалтуудын үр өгөөжийг үнэлэх

### “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь”хичээлийн материалыг ойлгох (60 минут)

#### 1. Уншиж тодруулах

Сургалт эхлэхээс өмнө хүн бүр дор жагсаасан судалгаа, санамжуудыг уншсан байх ёстой. Эдгээр мэдээллийг тоймлоход хэдэн минут зарцуулна уу:

Төгсгөл судалгаа: Цаашид юу хийх хэрэгтэй вэ?

Судалгаа 2D: Хүний эсрэг газрын мина

[Бүх дүрс бичлэгийг үзэж гүйцэхийн тулд энэ сургалтын үед Судалгаа 2D-ийн “Газрын минаас болж хүний амь үрэгдсээр л байна” бичлэгийг үзүүлнэ.]

#### 2. Судалгааг удирдан явуулах

Сонгогдсон оролцогчид “Жүжиглэлээр дамжуулан дайныг судлах нь” бичлэгийг ашиглан “Төгсгөл судалгаа”-г удирдан явуулна.

#### 3. Хэлэлцүүлэг

Судалгаа удирдан явуулсны дараа сургууль, орон нутаг, улсын хэмжээний бичил бүлгүүд үүснэ. Дараах асуудлуудаар брейнсторминг буюу оюуны довтолгоон хийнэ:

- Сурагчид тань тохирсон төслийн төрлүүд
- Олон нийтэд хүрч очих төслүүд дээр бусад багш нар болон сургуулиудтай хамтарч ажиллах арга замууд

### Өөрийн заах аргадаа нэвтрүүлэх (30 минут)

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо буюу бичил бүлгээр дараах асуудлыг хэлэлцэнэ:

- Тохиромжтой төслүүдтэй холбоотой ямар асуудлаар сурагчдад маань тусlamж хэрэгтэй болох вэ?

Энэ судалгааг хэрхэн ашиглах талаар төлөвлөгөө боловсруулна уу.

### Өөрийн сургалтыг үнэлэх нь (25 минут )

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хэлэлцэнэ:

- Сургалтаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?
- Залуучуудын төсөлд үнэлгээний ямар арга барилуудыг хэрэглэж болох вэ?

## 10. Сурснаа ашиглах: Залуучуудын төсөл

### Сургалт семинарыг үнэлэх нь ( 60 минут )

Сургалтын эхэнд бичсэн асуултуудын хариултуудыг одоо бичнэ:

- “Хүмүүнлэгийн Эрх Зүйг Судлах нь” хичээлийг зааснаар таны хүсэн хүлээж буй үр дүн юу вэ?
- Та юунд найдаж байна вэ?
- Та юунаас эмээж байна вэ?
- Танд ямар асуултууд байна вэ?

Одоо өмнө нь бичсэн хариултуудаа эргэн санана уу. Тэдгээрийг харьцуулж үзэнгээ дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Хүсэн хүлээж байсан үр дүн маань хэр биелсэн бэ?
- Цаашид гарч ирэх асуудлуудыг хөндөж тавихын тулд би юу хийж чадах вэ?
- Багш бэлтгэх сургалтаар би юу сурч авсан бэ?
- Юу нь учир дутагдалтай байсан бэ? Илүү сайн болгох ямар санаануудыг дэвшүүлж болох вэ?

### Үнэлгээ (25 минут )

Тэмдэглэлдээ бичээд дараа нь хос хосоороо дараах асуудлуудыг хэлэлцэнэ:

- Сургалтын агуулга, арга барилаас та юу сурч авсан бэ?
- Танд ямар асуулт байна вэ?
- Энэ хичээлд үнэлгээний ямар арга барилууд ашиглагдсан болон ашиглагдаж болох байсан бэ?
- Эдгээр сургалтуудаас та юу сурч авсан бэ?

## ТАЙЛБАР

### УДИРДАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: ОРШИЛ СУДАЛГАА ДАЙНЫ ТУХАЙ ТАНЫ ТӨСӨӨЛӨЛ

Багш: Та бүхний үзэл бодол, санаа, та нарын юу мэдэж байгаа болон юу мэдэхгүй байгаа, юу сонсож мэдсэн, юуг сонирхож байгааг мэдмээр байна. Дайны тухай бodoход та нарын толгойд хамгийн түрүүнд ямар үгс орж ирдэг вэ? Та нар юу харж, мэдэрч, сонсч байна вэ?

Хөвгүүн: Гамшиг.

Багш: Гамшиг. Тийм ээ?

Охин: Аюул.

Багш: Аюул.

Охин: Хүчирхийлэл.

Багш: Аюул, хүчирхийлэл. За, тэр ард.

Охин: Байлдаан.

Багш: Байлдаан.

Охин: Үхэл.

Багш: Байлдаан ба үхэл.

### ДАЙНЫ ХЯЗГААРЛАЛТУУД

Багш: Дайн байлдааны үед хэрхэн байлдаа буюу дайныг яаж явуулах талаар хууль дүрэм байх хэрэгтэй гэж та нар боддог уу?

Хөвгүүн: Хоёр хүн байлдаадаа хүнгүй газар очиж байлдаа хэрэгтэй, багш аа, тэгэхээр тэд байлдаж байхдаа өөр зэвсэг олно гэж байхгүй, тийм болохоор байлдаанд оролцоогүй хүмүүст гай учуруулахгүй.

Охин: Миний бодлоор тийм дүрэм байх хэрэгтэй гэж бодож байна, яагаад гэвэл хоёр улс ч юм уу, хоёр хүн байлдаа болбол гэмгүй хүмүүс аюулд өртөх магадлалтай. Ийм учраас тийм улсуудад дүрэм хэрэгтэй, бас зарим газрууд руу явж болохгүй.

Хөвгүүн: Ер нь аливаа улс орон, хүмүүсийн хооронд ямар ч дайн байж болохгүй гэж бодож байна. Бурхны зааснаар бид энх тайвнаар амьдрах ёстой. Тийм болохоор дайн ч байж болохгүй, дайн байхгүй болохоор дүрэм ч хэрэггүй.

## Дүрс бичлэгийн тайлбар

### ТА БАГШ БАЙСАН БОЛ ЯАХ БАЙСАН БЭ? ДАЙНТАЙ ТӨСТЭЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Охин: Багш аа, хоёр хүн байлдаан болбол хүнгүй газар очих ёстой гэж Роберт хэлсэн. Заримдаа байлдаан болоход хүүхдүүд оролцож болно, тэгээд байлдааныг зогсоон гэж оролдсон хүүхэд гэмтэж бэртэж болно. Тийм болохоор хэн ч байхгүй газар очих нь гол биш гэж бодож байна.

Багш: За тэгвэл та нар дотроос дайнд эсвэл дайнтай төстэй нөхцөл байдал буюу зэвсэгт мөргөлдөөнд байж үзсэн хүнийг мэдэх хүн байна уу?

Хөвгүүн: Манай нэг найз жижиг дайнд оролцож үзсэн.

Багш: Жижиг дайн гэнээ. Хэрвээ буу зэвсэгтэй бол...

Хөвгүүн: Буу, хутгаа тэд нар хураалгаад тэгээд зодуулсан гэсэн. Тэгээд энэ манай тал, танай нутаг дэвсгэр биш болохоор битгий буцаж ирээрэй гэсэн гэнэлээ.

Багш: Аан, гэмт хэрэгтний бүлэглэл байсан байхнээ...

Хөвгүүн: Тийм, тийм.

Багш: Энд Ямайkad уу?

Хөвгүүн: Тийм, энд.

Багш: Ямайкчууд байсан байх нь. Тэдэнд дүрэм журам байдаг уу?

Хөвгүүн: Үгүй, ямар ч дүрэм байхгүй.

Багш: Дүрэм байх хэрэгтэй юу?

Хөвгүүн: Хэн нэгэнтэй тулалдах гэсэн хүн ганцаараа тулалдах хэрэгтэй. Тэгэхээр өөр хүн аюулд өртөхгүй, хэрвээ өртөж байвал тэр хүн өөрөө л буруутай.

Охин: Заримдаа хүмүүс өчүүхэн жижиг зүйл, мөнгө төгрөгнөөс болж тулалддаг. Тэгээд тулалдаж байснаа гэнэт болиод “Бид ингэж болохгүй, тэгэж болохгүй” гэхгүй шүү дээ. Зүгээр л тулалдаад байна, тийм болохоор дүрэм журам хэрэгтэй гэж би л лав бодохгүй байна.

Охин: Багш аа, ер нь тулалдаан байж болохгүй.

Багш: За, тэгэхээр дайн тулаан ерөөсөө хэрэггүй байх нь. Гэтэл огт дайн байлдаангүй байж чадаж байна уу?

Охин: Үгүй.

Багш: Ийм учраас л бид энэ талаар юу хийх ёстойг судалж байгаа юм шүү дээ, ойлгов уу?

## Дүрс бичлэгийн тайлбар

“ДАЙНЫ ХАЛУУН ЦЭГЭЭС ИРСЭН ДУУ ХООЛОЙ”-Г ХЭЛЭЛЦСЭНИЙ ДАРАА  
БҮЛГЭЭРЭЭ ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛСИЙН ТОДОРХОЙЛОГЧ  
ШИНЖ ЧАНАРУУДЫГ ТОЙМЛОНО.

Багш: Бид одоо энэ бүх мэдэгдэл мэдээллийг үзсэн юм чинь дүгнэлт гаргагаая. Бүгдээрээ багана бүрээс нэг дүгнэлт гаргана шүү. Нэгдүгээр баганаас эхэлье.

Охин: Дайсныхаа төлөө хүмүүнлэгийн үйлс хийдэг хүмүүс байна.

Багш: Ердийн нөхцөлд бидэнд туслах албагүй хүмүүс энэ хүмүүнлэгийн үйлсийг хийж байна. Өөрөөр хэлбэл дайсан нь дайсандаа тусалж байна гэсэн үг. Тэгэхээр үүнийг 1-р тодорхойлогч шинж чанар гэж үзье. Энэ бол хүмүүнлэгийн үйлсийн онцлог юм. Энэ нь хүн ахдаа, найдваа ч юм уу ээждээ туслахаас ондоо. Ийм учраас гэр бүлдээ туслах нь хүмүүнлэгийн үйлст багтдаггүй байх нь. Одоо хоёрдугаар баганыг үзье.

Хөвгүүн: Бие биедээ зүй зохисгүй харьцаж байгааг эс тооцвол дайсан нь дайсандаа өөрийн эрхэмлэдэг зүйлс, ёс суртахуун нь ямар байхаас хамааран тусалж болох л юм.

Охин: Энэ нь материаллаг буюу ёс суртахууны тусламж, хүмүүнлэгийн үйлс байж болно.

Багш: Тэгвэл энэ материаллаг буюу ёс суртахууны тусламжийг ямар зорилгоор үйлддэг вэ? Хүмүүстэй ямар нэгэн байдлаар холбоотой юу?

Хүү: Тусалж хамгаалах гэж

Багш: Хэнийг хамгаалах гэж?

Охин: Гэмгүй хүмүүсийг

Багш: Хүн төрөлхтөнд хамаатай байх нь.

Охин: Хүний нэр хүндтэй холбоотой.

Багш: Тэгэхээр хүмүүнлэгийн үйлсийн хоёрдугаар шинж чанар нь хүний нэр хүндийг хамгаалаад оршдог байх нь. Энд ямар дарамт учирч байна вэ?

Хөвгүүн: Энд нийгмийн болон сэтгэл зүйн дарамт байгааг бид харж байна.

Багш: Эдгээр нийгмийн болон сэтгэл зүйн дарамтаас бид хүмүүнлэгийн үйлсийн ямар шинж чанарыг дүгнэн гаргаж чадах вэ?

Охин: Зарим хүмүүс эрхэмлэдэг зүйлс, хүн чанараасаа болж бусдыг зовж шаналж байхад нь зүгээр сууж чадахгүй учир учрах дарамтыг тоолгүйгээр дайсандаа тусалж байна.

Хөвгүүн: Дайснаа ч гэсэн өрөвдөх сэтгэл төрөхөөр тийм нөхцөл байдал байгаа учир тэр хүн хэдийгээр дайсан байлаа ч гэсэн хоригдолд тусалж байна.

Багш: Бүгдээрээ дүгнэлтүүдээ нэгтгээ.

Охин: Нийгмийн болон сэтгэл зүйн дарамтаас үл шалтгаалан хүмүүнлэгийн үйлс хийх тухай

Багш: Нийгэм, сэтгэл зүйн дарамттай үед тусламж үзүүлж байгаа хүнд, яах вэ?

Охин: Зөндөө олон саад байна, саад бэрхшээл, эрсдэл байна. Тэр хүн өөрийгөө эрсдэлд оруулж байна.

Багш: Бас өөрийгээ золиосолж байна, бусдын төлөө өөрийгээ золиосолж байна гэсэн үг. Цаад хүн нь түүний гэр булийн хүн биш, найд нөхөр ч биш, харин дайсан нь юм. Тэгэхээр хүмүүс тусална гэж бодоогүй байсан. За одоо бид нар хүмүүнлэгийн үйлсийн 3 онцлох шинж чанарыг мэдэж авлаа.

### “ДАЙНЫ ХАЛУУН ЦЭГЭЭС ИРСЭН ДУУ ХООЛОЙ -1” ИШЛЭЛЭЭР СУРАГЧИД ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛЖ БАЙНА.

ДАРААХ ДАРААЛЛААР ХАРИУЛТУУД НЭГТГЭГДСЭН БАЙГАА:

1. Хэн хэний төлөө хүмүүнлэгийн үйлс хийж байна вэ?
2. Тэр яг юу хийсэн бэ?
3. Түүнд ямар бэрхшээл, дарамт учирсан бэ?

Багш : Хэн нь хэний төлөө хүмүүнлэгийн үйлс хийж байна вэ?

Охин : Дайсны талын нэг эр хүмүүнлэгийн үйлс хийж байна.

Багш: Хэний төлөө?

Охин: Тэр нэг хоригдлын төлөө.

Багш: Тэр дайсан хоригдолд юу өгсөн бэ?

Хөвгүүн: Тэр хоол, хувцас өгсөн.

Багш: Дайсан тэр хоригдлыг хамгаалж аюулгүй байдлыг нь хангаж байна гэж хэлж болно. Харин энэ дайсандaa тусалж байгаа хүнд ямар бэрхшээл дарамт шахалт учирч байна вэ?

Охин: Тэдгээр дайснууд эсрэг талынхаа хэнд ч туслахыг өөрийн хүмүүстээ хориглосон. Тиймээс тэр хүн аюулд учраад байна.

Багш: Тэгэхээр бусдын зүгээс дарамт учирдаг юм байна. Дайсандaa тусалсан гэдгийг нь тэд мэдчих вий гэсэн дарамт учирч байна. Тийм болохоор энэ нь нийгмийн дарамт юм. Бусдаас айх нийгмийн дарамт. За тэгвэл энэ хүмүүнлэгийн үйлсийг хэний төлөө хийж гүйцэтгэсэн бэ?

Охин: Тэр дайсан эсрэг талынхаа нэгэн гэр бүлд тусалж байна.

Багш: Тэд энгийн иргэд байна. Тэдэнд юугаар тусалж байна вэ?

Хөвгүүн: Тэднийг хамгаалж байна.

Багш: Тийм ээ. Аюул дуустал хамгаалж, аюулгүй байдлыг нь хангаж байна. Энд ямар төрлийн дарамт байна вэ?

Охин: Тосгоны оршин суугчид тэр гэр бүлийнхнийг алж тосгоноос хөөн гаргахыг хүсч байна.

Багш: Тэгэхээр энэ нь дарамт, гэр бүл, бусдаас айх явдал юм.

Хүү охин хоёр: Нийгмийн дарамт

Багш : Одоо хувийн ба сэтгэл зүйн гэсэн 3 дахь категорийг авч үзье.

# Дүрс бичлэгийн тайлбар

Хөвгүүн: Яг тийм.

Охин: Уучлаарай. Би (өмнөх сурагчтай) санал нийлэхгүй байна. Хэрвээ хүн л бол хүнд нэр хүнд байх ёстой гэж хэлж байсан. Юу хэлэх гээд байна вэ гэвэл, цэрэг хүн юу хийх ёстойгоо мэддэг, дайнд оролцохынхоо өмнө хүн алахаар сургагддаг. Алахгүй бол олзолж, эзэлж авах ёстой. Зорилго нь бол дайнд ялах шүү дээ. Яагаад хүний нэр хүнд, хүний амь насыг аврах тухай бодох ёстой юм бэ? Хүний амь аварна гэдгээ мэдэж байгаа юм бол цэрэг байх шаардлага юунд байгаа юм бэ? Эмч ч юм уу, өөр хүн болж болох байсан юм биш үү...  
(Инээлдэнэ.)

## ТА БАГШ БАЙСАН БОЛ ЯАХ БАЙСАН БЭ?

Багш: Цэргүүд тэгвэл хүн биш юм уу?

Охин: Хүн мөн л дөө, гэхдээ тэд хүний нэр хүндийг ор тас мартдаг. Тэд юу болох гэж байгаад л анхаарлаа хандуулдаг. Гал, дэлбэрэлт гээд л... Хүн хүнээ ална гэдэг үнэхээр амар зүйл биш шүү дээ, тэгэхээр тэд их хэцүү байдалд ордог. Би хүн алах гэж байгаа шүү дээ гэж бодоход тэдэнд үнэхээр хэцүү. Хэдийгээр хүн ч гэлээ маш аймшигтай байдалд ордог. Миний бодлоор тэдэнд бодох цаг гэж байхгүй байх.

Багш: Ямар ч дайны нөхцөл байдал ийм л байна. Тэглээ гээд хүмүүс магадгүй...

Охин: Гэхдээ...

Багш: Би чамтай санал нийлэхгүй байна гэж хэлэхгүй. Юу хэлэх гээд байгааг чинь ойлгож байна. Заримдаа бид дайны үед амьд гарахаа л бодож бусад зүйлсийг мартдаг.

Хөвгүүн: Цэргүүд бас өөрсдийн ухамсартай хүмүүс гэдгийг би онцолж хэлмээр байна. Хүн алах нь тэдний хүсэл биш, харин эх орноо хамгаалах гэж бэлтгэгдсэн хүмүүс шүү дээ. Сургууль руу явж ороод л хүмүүсийг буудаад байдаг цэрэг гэж та нар сонсоогүй биз дээ. Тэд бүгдээрээ хүчирхийлэгчид биш, бид нар шиг л хүмүүс байж байгаа. Тэд нар хийхээсээ өмнө бодлог, тэгээд ч ямар нэгэн зүйл бодож, төлөвлөхгүйгээр хийнэ гэж байхгүй. Тийм болохоор эзэлж авах ч юм уу, эсвэл нэг юм хийхийнхээ өмнө тэр нь амьд гарна, тэрийг нь ална гэх мэтээр төлөвлөдөг. Эмч нар ч гэсэн харагдаж байгаа шигээ зоригтой биш хүмүүс байж л байдаг шүү дээ. Яг л цэргүүдтэй адил.

Багш: За одоо өөр зүйл ярья, хурдан...

Охин: Би түүний хэлж байгааг сонслоо, зарим нэгэн зүйлс нэмж хэлье. Цэрэг хүн алахаар сургуулилагдсан байдаг талаар. Хэрвээ цэрэг хүмүүнлэг зан гаргах юм бол олзлогдогч эсрэгээр цэргийг маань алж мэнднэ. Тиймд цэрэг өөрийнхөө л амьдралыг бодно, олзлогдогчийг биш. Миний бодлоор цэрэг олзлогдогчийг алахаас өөр аргагүй...

Багш: За одоо дайны зорилгоор ашиглах ёстой ямар нэгэн хууль дүрэм бодож байгаад хэлэх хүн байна үү?

## ХҮНИЙ НЭР ХҮНДИЙГ СУДЛАХАД ФОТО ЗУРАГ АШИГЛАХ НЬ

[СУРАГЧИД ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭН САНААНУУДАА БИЧСЭН БАЙГАА.]

“ОЛЗЛОГДОГЧИЙН НЭР ХҮНДЭД ЯМАР ЭРСДЭЛ УЧИРЧ БАЙНА ВЭ?”

“ОЛЗЛОГЧИЙН НЭР ХҮНДЭД ЯМАР ЭРСДЭЛ УЧИРЧ БАЙНА ВЭ?”

Охин: Олзлогдогч хүн ялангуяа мэдээллээ хэлчихсэн бол бараг л амьдралаа сүйрүүллээ гэсэн үг бөгөөд хэлсэндээ харамсч ямар нэгэн сайн зүйл болоосой гэж залбирч эхэнэ. Залбирч байгаа хүнийг харахаар хүн шүү гэдгийг нь мэдрэх учир надад лав ийм хүнийг алах сэтгэл төрөхгүй. Би түүний амьдралыг, мөн нэр хүндийг нь хүндэтгэх ёстой. Тэр хүн үхэх ч юм уу, эсвэл түүнд юу ч үлдэхгүй гэдэг нь тодорхой учраас.

Нөгөө талаас олзлогч этгээдийн хүний нэр хүндийн тухай асуулт гарч ирнэ. Тэр хэрвээ олзлогдсон хүнийг алвал өөрийгээ алуурчин, зандалчин, хүний амийг бүрэлгэсэн этгээд гэж бодох болно. Олзлогдсон хүнийг алснаар түүний амьдрал ингэж алахаас өмнө байсан шиг тайван сайхан байж чадахгүй болно.

Багш: Сайн байна. За одоо олзлогчийн нэр хүндийн талаар ярья.

Охин: Мэдээж түүний хувьд хүний нэр хүнд гэхээр юм үлдэхгүй болно. Одоо тэр өөрийгээ хүн гэж төсөөлөхөд хэцүү, дээгүүр нь харанхуй үүл бүрхсэн юм шиг болж, гэмгүй хүний амийг хөнөөгч, өршөөл гүйж байсан хэн нэгнийг хайр найргүй хороосон алуурчин машин шиг л аашилсан учраас.

Багш: За тийм байж.

Хөвгүүн: Олзлогдсон хүний нэр хүнд гэвэл бас л аюулд учраад байна. Тэр боол болох эсвэл бүр алуулж ч магадгүй.

Багш: Олзлогдсон хүний нэр хүнд...

Хөвгүүн: Олзлогдсон хүн

Багш: Аюулд ороод байна.

Хөвгүүн: Тийм ээ. Тэр нэг бол боолчлогдох эсвэл алуулах болоод байна.

Багш: Сайн байна. Харин олзлогчийн хувьд юу хэлэх вэ?

Хөвгүүн: Олзлогч... Тэр хадны завсар хавчуулагдаад байна гэхүү дээ.

Багш: Яаж тэр вэ?

Хөвгүүн: Тэр нэг талаас тушаал биелүүлэх ёстой, гэвч нөгөө талаас ёс суртахуунаа дагах хэрэгтэй болж байна. Хүн алж болохгүй энэ тэр гээд л...

Багш: Зөв. Маш сайн байна.

Хөвгүүн: Тэр жишээ надад их таалагдаж байна. (Зураг руу заана) Цагаан арьстнуудын сургуульд явдаг, ихээхэн хавчигдаж байсан, цагаан хүмүүстэй уулзаж байгаа тэр хар арьстай хүүхэд байна. Тэр бол дайсандаа олзлогдсон цэрэгтэй адил юм. Хар арьстай хүүхдийг ялгаварлан гадуурхаж байгаа цагаан арьстнууд хүний нэр хүндийг гутаан доромжилж байгаа учраас энэ олзлогч цэргүүдтэй ижил байна. Олзлогдсон цэргүүд өөрсдийгээ өчүүхэнд тооцон хүний нэр хүндээ умартан амьтантай адил байгаа мэтээр сэтгэж эхлэх учир бусад хүмүүсийг бас хайрлахaa болино. Та өөрийгээ амьттан гэж бодож байгаа бол бусад хүн юу мэдэрч байгаа нь танд хамаагүй болно шүү дээ.

Багш: Тэгэхээр хүн бусдын эрхийг үнэлэхгүй бол өөрийнхийгээ ч бас үнэлэхгүй байх нь ээ?

## СУРАГЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ: ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД ЯМАР ДҮРЭМ ЖУРАМ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Багш: За ингэцгээе, дайны үед хэрэглэж болох хууль дүрмийг бодолцье. Ийм хуулийг та нар мэдэж байвал цаасныхаа доод хэсэгт дор хаяж 2 юм уу 3-ыг бичээрэй.

Хөвгүүн: Дайны үед зэвсэгтүй цэргүүдийг алах ёсгүй. Хэрэв цэрэг хүн алаагүй бол тэд түүнийг буудах ёсгүй.

Багш: За.

Охин: Олзлогдсон хүмүүсийн амийг өршөөх ёстай.

Багш: Олзлогдсон хүмүүсийн амийг өршөөх гэсэн үү?

Охин: Энгийн иргэд аюулгүй байдалд байх ёстай. Мөн ялагдсан цэргүүдийг алах ёсгүй.

Багш: Тэгэхээр тэд бас аюулгүй байдалд байх ёстай гэсэн үг үү?

Хөвгүүн: Дайн цаг хугацаа шаарддаг. Хүмүүс байлдах ёстай бол магадгүй жишээлбэл 6 сар байлдах ёстай.

Багш: 6 сар аа?

Хөвгүүн: Учир нь дайн эдийн засаг гэх мэтэд нөлөөлөх учраас.

Багш: Чи дайны үед эдийн застийн ямарваа догондол байх ёсгүй гэж хэлэх гээд байна аа даа?

Хөвгүүн: Тийм ээ.

Хөвгүүн: Зөвхөн өөрийгээ хамгаалах зорилгоор л алах ёстай юу?

Багш: Аан?

Хөвгүүн: Зөвхөн өөрийгээ хамгаалах зорилгоор алах ёстай юу?

Багш: Тиймээ, зөвхөн өөрийгээ хамгаалж байхдаа...

Хөвгүүн: Аргагүй хамгаалалт

Багш: Тийм, өөрийгээ хамгаалж алах ёстай.

Хөвгүүн: За.

Охин: Цөмийн зэвсэг биш зөвхөн сумтай буу л хэрэглэх ёстай.

Багш: Цөмийн зэвсэг огт болохгүй юу?

Охин: Тийм ээ.

Багш: Сонирхолтой байна.

Хөвгүүн: Олзлогдсон хүмүүсийг алж болохгүй, харин бөөнөөр нь хорих лагерь байгуулах хэрэгтэй гэж бодож байна. Бас энгийн иргэдийг алж болохгүй, тэднийг хамгаалж, аюулгүй байлгах ёстай.

Багш: Тэгэхээр энгийн иргэдийг алж болохгүй нь ээ.

Хөвгүүн: Бас шархадсан цэрэг зэрэг хүмүүст эмнэлгийн тусlamж үзүүлж буй хүмүүсийн тухай ч тийм байхаа гэж бодож байна. Жишээлбэл, Улаан Загалмайн хүмүүсийг алж болохгүй. Тэд тулалдах зорилгогүй учраас тэднийг алж болохгүй. Тэдний гол зорилго нь шархадсан хүмүүст туслах биз дээ.

## Дүрс бичлэгийн тайлбар

Багш: Сайн байна.

Хөвгүүн: Зөвхөн цэргүүд л байлдааны үйл ажиллагаанд оролцох ёстай.

Багш: Зөвхөн цэргүүд ээ?

Хөвгүүн: Тийм.

Хөвгүүн: Газар доорх бөмбөг хэрэглэж болохгүй, бүгд биш ч гэсэн бөмбөг дэлбэрч болно. Автоматаар ч дэлбэрч болно шүү дээ.

Багш: Газрын минийг ерөөсөө хэрэглэж болохгүй.

Хөвгүүн: Тийм.

Хөвгүүн: Иргэний болон цэргийн объектуудыг ялгах хэрэгтэй.

Багш: Иргэний болон цэргийн объектуудыг ялгах

Хөвгүүн: Тийм. Бид тэдний дайсан болохоос найз нь биш гэдгээ санаж байх ёстай.  
(Инээлдэнэ.)

Багш: Юу гэсэн бэ?

Хөвгүүн: Онцгой газар, цөлд ч юм уу байлдах хэрэгтэй. Тэгснээр энгийн иргэдийг хамгаалж чадна.

Багш: Цөлд гэсэн үү? За.

Хөвгүүн: Тийм.

Охин: Эмнэлгийн үйлчилгээ байх хэрэгтэй биздээ.

Багш: Эмнэлгийн үйлчилгээ? Дайны үед зөвшөөрөгдөх үү?

Охин: Шаардлагагүй бол ер нь дайн хийх хэрэггүй.

Багш: Шаардлагатай биш ээ? Шаардлагатай дайн гэж байдаг болохоор ... уу?

Охин: Дайнаас болж хэрэгтэй газруудыг устгаж болохгүй.

Багш: Юу?

Охин: Хэрэгтэй газрууд...

Багш: Хэрэгтэй газруудыг яж болохгүй гэж?

Охин: Устгаж

Багш: Устгаж болохгүй

Хөвгүүн: Бас олзлогдсон хүмүүстэй харгис харьцаж болохгүй.

Багш: Олзлогдсон хүмүүстэй харгис харьцаж болохгүй ээ?

Охин: Онцгой хэрэгцээтэй хүмүүсийн эрхийг үгүйсгэж болохгүй.

Багш: Ямар онцгой хэрэгцээ гэж?

Охин: Сохор, дүлий гэх мэт хүмүүс

Багш: Эрхийг нь үгүйсгэж болохгүй. За сайн байна.

Хөвгүүн: Бас цэрэг бүр яг тодорхой тооны хүнийг л алах ёстай.

## ТА БАГШ БАЙСАН БОЛ ТА ЯАХ БАЙСАН БЭ?

Хөвгүүн: Тэд энгийн иргэдийг хүндлэх ёстoy.

Багш: За.

Хөвгүүн: Ер нь хүмүүс сүм, сургуулийг бөмбөгдөж, довтолж болохгүй гэж хэлдэг шүү дээ. Дайсны талын цэргүүд сүм, сургуулийг довтолж болохгүй гэдгийг мэддэг учраас булаан эзэлж болохгүй гэсэн дүрэм журам байх ёстoy. Тийм болохоор цэргийн лагераа өөр газар барих ёстoy гэж бодож байна.

Багш: Өөрөөр хэлбэл тэд иргэдийн эд хөрөнгийг хүндэтгэх ёстoy.

Хөвгүүн: Тийм

Охин: Цэргүүдийг хийхээсээ өмнө боддог байх талаар сургах ёстoy.

Багш: Эсвэл цэргүүдэд Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйг заах ёстoy.

Охин: Дайнд зөвхөн генералууд тулалдаж харин цэргүүд тэдэнд тусалдаг бол...

## ДҮРС БИЧЛЭГ ҮЗЭХ: БЭЛТГЭЛ БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### 1-Р ХЭСЭГ

#### БЭЛТГЭЛ: ХҮҮХЭД ГЭЖ ХЭН БЭ ГЭДГИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАЙНА.

Багш: Эхний асуулт: Гудамжинд чамайг цагдаа зогсоогоод биеийн байцаалтаа үзүүл гэвэл чи яах вэ?

Хөвгүүн: Би эхлээд яагаад миний биеийн байцаалтыг үзэх гэснийг асууна.

Багш: Шалтгаан нь чи шөнө явж байгаа учраас.

Охин: Би л лав би шөнө гадуур явах эрхтэй гэж хэлнэ. Миний биеийн байцаалтыг үзэх ямар эрх танд байгаа юм бэ гэж асууна.

Багш: Цагдаа тэгвэл аюулгүй байдлын үүднээс зүгээр л шалгаж байна. Биеийн байцаалтаа өгнө үү гэж хэлнэ. Та нарт биеийн байцаалт бий юу? Та нар юу гэж хэлэх вэ?

Оюутан: Үгүй. Надад биеийн байцаалт байхгүй гэж хэлнэ.

Багш: Яагаад та нарт биеийн байцаалт байхгүй гэж?

Хүү охин хоёр: Бид биеийн байцаалт авах насанд хүрээгүй. Би жаахан. Би хүүхэд. Тийм учраас надад биеийн байцаалт байхгүй.

Багш: Тэгэхээр хүүхэд гэж хэн болж таарч байна вэ?

Охин: 18 нас хүрээгүй, 18-аас доош насны хүнийг хэлнэ.

Багш: Хүүхэд гэж 15-аас доош насны хэн нэгнийг хэлнэ. Өсвөр насныхан бол 20-оос доош насныхан. Насанд хүрсэн хүн гэж 20-оос дээш насны хүнийг хэлнэ. Тэгэхээр та нар бол хүүхдүүд шүү дээ.

## Дүрс бичлэгийн тайлбар

ХҮҮХДЭД ЯМАР ХЭРЭГЦЭЭ БАЙДАГ ВЭ?  
БАГШ ХЭРЭГЦЭЭНИЙ З ТӨРЛИЙГ АШИГЛАНА.  
Биологийн Сэтгэл зүйн Нийгмийн

Багш: Дараагийн асуулт: Хүүхдийн 3 гол хэрэгцээ юу вэ?

Охин: Хувцас

Хөвгүүн: Эрүүл мэнд

Охин: Биеийн бойжилт

Хөвгүүн: Бие

Багш: Сэтгэлзүйтэй холбоотой өөр зүйл байна уу?

Охин: Халамж

Охин: Тэгээд бас сэтгэл зүйн хэрэгцээ байна. Эдгээр нь хүүхдийг тодорхойлдог хүчин зүйлс юм.

Хөвгүүн: Нийгмийн тодорхойлогч шинж чанар бас байна.

Багш: Хүүхдийн бие махбодийн хэрэгцээний талаар

Охин: Хүүхдэд хүнс, хувцас, орон байр, хамгаалалт хэрэгтэй.

Багш: Энэ хэрэгцээг хангах нь хүүхдэд ямар ашигтай вэ?

Хөвгүүн: Ингэснээр хүүхэд эрүүл мэнд, хөгжил сайтай болно.

Багш: Оюун ухаан ч гэсэн зөв хөгжинө. Бид “Эрүүл биед саруул ухаан оршино” гэж ярьдаг шүү дээ. Харин сэтгэл зүйн хэрэгцээний талаар юу хэлмээр байна.

Хөвгүүн: Хүүхэдтэй эелдэг харьцах хэрэгтэй.

Охин: Хүүхдийг ойлгох хэрэгтэй.

Хөвгүүн: Хүүхдийг хамгаалах хэрэгтэй.

Охин: Сэтгэл зүйн эдгээр хэрэгцээг хангах ёстой. Хүүхдэд хайр, халамж, тогтвортой байдал шаардлагатай байдаг.

Багш: Эдгээр хэрэгцээг хангах нь юунд хүргэдэг вэ?

Охин: Ингэснээр хүүхдийн бие хүн төлөвшин амьдралд бат сууриа олно.

Багш: Нийгмийн хэрэгцээний тухай юу хэлэх вэ?

Охин: Хүүхэд гэр бүлтэйгээ амьдрах ёстой.

Хөвгүүн: Хүүхэд гэр бүлээсээ хайр хүсдэг.

Багш: Хүүхдэд гэр бүл нь хэрэгтэй.

Охин: Хүүхэд наасаа бас хөгжилтэй өнгөрөөх ёстой.

Хөвгүүн: Тэр харилцан ярихыг, нийгэм дотор харилцаж чаддаг байхыг хүсдэг.

Багш: Нийгэм нь түүнд ийм яриа, ардчилсан яриаг зааж өгөх шаардлагатай байдаг.

Багш: Эсрэг тохиолдолд яах вэ гэдгийг авч үзье.

## Дүрс бичлэгийн тайлбар

Хөвгүүн: Түүнд сэтгэл зүйн асуудлууд учрах болно.

Охин: Тэр сул бие хүн болно.

Охин: Тэр өөрийгөө алдах болно.

Багш: Тэр учраа олохoo болино. Тэр сул бие хүн болно. Тэр гутралд орно. Тэр ганцаардаж, уйтгарлах болно. Харин юм санаснаар нь бүтэхгүй бол нийгмийн үр дагавар нь юу байх вэ?

Хөвгүүн: Тэр нийгмийн хөгжлөөс хоцорно.

Охин: Тэр юмыг үл тоомсорлодог болно.

Хөвгүүн: Бичиг үсэггүй болно.

Багш: Яагаад гэвэл энэ бүхнийг сургуульд заадаг учир. Тэр нийгмээс тасрах нь.

Хөвгүүн: Гэр оронгүй ч болно.

Багш: Бид энэ талаар хангалттай ярилаа. Одоо харин хүүхдийн хөгжиж бойжих үүр нь юу вэ?

Багш: Түүний гэр

Охин: Түүний гэр бүл

Оюутан\*: Гэр орон, гэр бүл

Багш: Гэр бүлгүйгээр тэр орон гэргүй болно.

Оюутан\*: Орон гэргүй...

Багш: Хамгийн түрүүнд энэ байх нь. Хоёрдугаар үүр юу байх вэ?

Охин: Сургууль.

Багш: Сургуульд янз бүрийн зүйлийг сурах учраас.

Багш: Хүүхэд сургуульд явахгүй бол яах вэ?

Охин: Үл тоомсorлогч болно.

Охин: Бичиг үсэггүй болно.

Багш: Тэгэхээр бид хүүхдэд амин чухал хэрэгцээнүүдийг дурдлаа. Бие махбодийн, сэтгэл зүйн, нийгмийн, гэр орон, сургууль гээд л. Эдгээргүйгээр хүүхэд төөрөлдөж ямар ч ирээдүйгүй болно.

## ДҮРС БИЧЛЭГ ҮЗЭХ: БЭЛТГЭЛ БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2-Р ХЭСЭГ

“БИ БУЦАЖ ОЧМООРГҮЙ БАЙНА” БИЧЛЭГИЙГ ХЭЛЭЛЦЭЖ БАЙНА  
БИЧЛЭГ ҮЗЭХИЙН ӨМНӨ СУРАГЧДЫГ ДАРААХ БҮЛГҮҮДЭД ХУВААСАН.

АБРААМ (“ЦЭРЭГ” ХҮҮ)

КОМФОРТ КАССЕЛЛ (“ЦЭРЭГ” ОХИН)

КАМАРРА (ЗАХИРАГЧ)

Багш: За бүгдээрээ хүснэгт хийгээд мэдээллээ нэгтгэн илтгэгчээ сонгоё. Та нар хэлэлцүүлгийн үед бие биендээ туслах болно. Бусад чинь асуулт асууж магадгүй учир сайн бэлдэх хэрэгтэй.

Оюутан\*. Тэд бид нараас юу асууж болох вэ?

Багш: 1-р бүлэг, Абраамын бүлэг- Абраамын тухай авч үзэх бүлэг...

Хөвгүүн: Абраам тайван сайхан амьдарч байтал дайн гарч гэр бүлээ дайнд алдсан. Тиймээс тэр дайнд оролцож олон хүн алсан. Эцэст нь тэр мэдээж нийгэмдээ эргэж уусах гэж оролдсон боловч зөндөө бэрхшээлтэй тулгарсан.

Багш: Нас нь.. Тэр хэдтэй вэ?

Хөвгүүн: Арван нэгтэй.

Багш: Тэр дайнд сайн дураараа орсон уу, эсвэл албадуулсан уу?

Оюутан\*: Тэр сайн дураараа орсон.

Багш: Яагаад?

Оюутан: Тэр эцэг эхийнхээ өшөөг авахыг хүссэн. Өшөө авалтын асуудал байсан.

Оюутан\*: Тэр эцэг эхийнхээ өшөөг авахын тулд цэрэг болсон.

Охин: Тэр найз нар шигээ байх гэж, найз нартайгаа хамт байх гэж цэрэг болсон гэж хэлж байна.

Багш: Тоглож наадах өөр найз байхгүй учир. Тэгэхээр өшөө авах, найз нартайгаа хамт байх гэсэн хоёр шалтгаан байна.

Оюутан: Түүний гэр бүл үгүй болсон, эмээгээсээ өөр гэр бүлийн хүнгүй болсон байна.

Охин: Амьдрал нь сөнөсөн.

Багш: Тэгэхээр тэр сайн дураараа орж уу, үгүй юу?

Охин: Юм бүхэн түүнийг цэрэгт орохоос өөр аргагүй болгосон. Түүнийг цэрэг, байлдагч болгох нөхцлийг бүрдүүлсэн гэж хэлж болно.

Багш: Тэгэхээр нөхцөл байдал түүнийг албадан цэрэг болгосон байна. Гэр бүл, найз нөхөдгүй болсон учраас. Эцэст нь тэр эмээтэйгээ цуг байж энгийн амьдраалаар амьдрахыг хичээсэн.

Оюутан\*: Тэр хүчинд автсан гэж хэлж болно. Хэрэв тэр сайн дураараа явсан бол цэрэгт илүү удаан үлдэх байсан.

**СУРАГЧДЫН ИЛТГЭЛҮҮД**  
**“ХЭРВЭЭ ТА ДЭЛХИЙТЭЙ ЯРЬЖ ЧАДДАГСАН БОЛ”**  
“БИ БУЦАЖ ОЧМООРГҮЙ БАЙНА” БИЧЛЭГИЙГ ҮЗЭЖ ХЭЛЭЛЦСЭНИЙ ДАРАА  
ХҮҮХДҮҮДЭД ИЛТГЭЛ ТАВИХАД БЭЛТГЭХ 15 МИНУТЫН  
ХУГАЦАА ӨГСӨН БАЙГАА.

Хөвгүүн (уншиж байна): “Дайны командалгач нарт. Удирдлагыг гартаа барьж буй та бүхэнд дэлхий нийтээрээ хандаж байна. Голландын эрхэм дээдэс Катерина ‘Өнөөдрийн үйлдэл тань маргаашийн ирээдүйг тодорхойлно’ гэж хэлснийг онцлон дурдаж үгээ эхэлмээр байна. Бидний ирээдүй бол бидний хүүхдүүд юм. Тэднээр сайн юм хийлгэж болохоор байхад яагаад муу зүйл хийлгэх ёстой юм бэ? Тэднийг хайрлах байтлаа яагаад зовоож байна вэ? Хүүхдүүд бил та бүхнээс 18-аас доош насны хүүхдүүдийг битгийг дайнд оролцуулаач, битгий цэрэгт элсүүлээч гэж гүйж байна. Бидний хүсэлт та бүхний таалалд нийцнэ гэдэгт найдаж байна. Баярлалаа.”  
(Алга ташиж байна)

- Багш: Одоо охидуудын ширээнд очьё.
- Охин (уншиж байна): “Удирдагч та бүхэн бяцхан хөвгүүдийг тэр бүү хэл охидуудыг цэрэг болгон ашиглаж байгаа тухай би энэхүү чухал баримтдаа дурдахыг хүсч байна.”
- Охин (уншиж байна): ”Дайнд хүүхдүүдийг ашиглах нь бусдад сөрөг төсөөлөл өгч байна гэдгийг та бүхэн ойлгохгүй байна гэж үү? 18-аас доош насны хүүхдийг дайнд ашиглаж болохгүй. Тэд боловсрол ч эзэмшиж амжаагүй, бас сэтгэл зүйн хямрал амсч байгаа. Дайнд оролцоно гэдэг нь тэдний ердийн хүмүүжлийг алдагдуулна гэсэн үг. Тэд нийгэмдээ аюултай этгээд болон хувирч болно. Хамгийн гол нь тэд маргаашийн удирдагч нар шүү дээ.”
- Охин (уншиж байна): ”Би хүүхдүүдийг дайнд оролцуулахыг тэр бүү хэл энгийн цэрэгт татахыг эсэргүүцэж байна. Тэд бүгдээрээ л дайнаас айдаг шүү дээ. Харин тэд маргаашийн удирдагчид гэдэгтэй санал нэг байна.”
- Багш: Сайн болсон байна.  
(Алга ташиж байна)

Хөвгүүн: За. (уншиж байна) “Оройн мэнд ноёд хатагтай нар аа! Ертөнцийн бүх хүүхдүүдийн нэрийн өмнөөс хүүхдүүд бил цэрэг болохыг хүсэхгүй гэдгийг хэлмээр байна. Учир нь бидний алсан хүмүүс бидний санаа сэтгэлээс хэзээ ч гараахгүй зовоодог, дайны үеийн миний найзуудаас зарим нь амия хорлосон, зарим нь одоо ч сэтгэл зүйн нөхөн сэргээх төвд байгаа гэх мэт олон аймшигтай зүйлийг хэлж чадна. Надад ч гэсэн амия хорломоор санагдаж байсан үе байгаа. Гэхдээ одоо би дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүүхдүүдийг өөр шигээ болгохгүйн төлөө, өөрийн туулж өнгөрүүлсэн тэр тамыг үзүүлэхгүйн төлөө хөл дээрээ баттай зогсч тэмцмээр байна. Миний амьдрал авах юмгүй болсныг та нар харж байна. Намайг хараач, миний сэтгэлд юу байна вэ? Би цөхөрсөн арчаагүй амьтан харагдаж байгаа биз. Харин та нар хүүхдүүдээ над шиг болгохыг хүсэхгүй бол хүүхдүүдийг дайнд битгий ашиглаарай л гэж хүсэх байна.”  
(Алга ташиж байна.)

Хөвгүүн (уншиж байна): Оройн мэнд ноёд хатагтай нар аа! Ертөнцийн бүх хүүхдүүдийн нэрийн өмнөөс та бүхэндээ хандаж байна. Байлдаж байгаа хүүхдүүдийн тухай хүсэлтээ хэлэхийг хүсч байна. Дайнд гэр бүлийнхэн нь үрэгдсэн эхийн сэтгэлийг ядаж хүндлэх үүднээс энэ хүүхдүүд байлдах ёсгүй, энэ явдлыг бушуухан эцэс болгомоор байна. Удирдагч нар л хүүхдүүдийн сэтгэл зүйн хямралаас ашиг олж байна. Дайн дуусахад удирдагч нар л ашиг олсон байдаг. Харин алагдан тэдгээр хүүхдүүд маргаашийн удирдагч болж болох байсан учраас миний хэлсэн үгийг анхааралдаа аваач гэж гүйж байна.”

- Багш: Сайн байна.  
(Алга ташиж байна.)

Багш: Сүүлийн ширээ.

Хөвгүүн (уншиж байна): “Эрхэм хүндэт заяа нэгт хүн төрөлхтөн, эрхэм дайны удирдагч нар аа. 2000 оны 7-р сарын 4-ний энэ оройн мэнд хүргэе! Ертөнцийн хүүхдүүд бил хүн төрөлхтнийг мөхлөөс аврахын тулд өөрсдийн үгээ хэлэхийг хүсч байна. Ирээдүйн залуу үе, хүүхэд билдний гарг

## Дүрс бичлэгийн тайлбар

байгаа билээ. Өсвөр үеээ дайн байлдаанд ашиглаад байвал бид бүхний зэлгамж халаа цаашид цэцэглэх жимсгүй болно шүү дээ. Хүүхдүүд 18 хүрч байж насанд хүрсэнд тооцогддог. Тэгэхээр биднийг булаш биш харин эх дэлхийн төлөө амьдрахад тусланаа.  
(Алга ташиж байна.)

### ТА БАГШ БАЙСАН БОЛ ДЭВШҮҮЛСЭН САНААНУУДАА АМЬДРАЛД ТУСГАХАД НЬ СУРАГЧДАД ХЭРХЭН ТУСЛАХ БАЙСАН БЭ?

Багш: Та нар үнэхээр сайн байна. Үзсэн кино, дүрс бичлэг та нарт сайнаар нөлөөлсөнд би их баяртай байна. Гэмт хэргийн бүлэглэлүүд дотор одоо ч гэсэн хүүхдүүд байгаа, бид өнөөдөр сурсан зүйлсээ амьдарч буй нийгэмдээ хэрэгжүүлэх хэрэгтэй гэж бодож байна. Гэмт хэргийн бүлэглэлийг хэдийгээр дайнтай адилтгаж болохгүй ч гэсэн тэр аяараа буруу зүйл гэдгийг хэлмээр байна. Гэтэл тэд бас хүүхдүүдийг ашигладгийг бид мэнднэ. Тэгэхээр сурсан болгоноо амьдрал, нийгэмд хэрэгжүүлгээ. Үүнд бурхан бидэнд туслах байх.. Бид хүүхдүүдийг ямар ч дайн, бослого тэмцэл, өөр бусад буруу зүйлд ашиглаж болохгүй. Өөр нэмж хэлэх хүсэлтэй хүүхэд байна уу?

Хүү: Багш аа, та нэг чухал зүйлийг орхигдуулсан юм шиг санагдаж байна. Мартин Лютер Кинг “Надад хүсэл мөрөөдөл бий” гэж хэлсэн байдаг. Хүүхдийг цэрэг болгож байгаа хүн тэдний ирээдүйг хулгайлж байна. Энэ нь тэдний хүсэл мөрөөдлийг бузарлаж байна гэсэн үг.

Багш: Тийм ээ тэдний хүсэл мөрөөдлийг бузарлана гэсэн үг.

Хүү: Бид үүнийг л хэлэлгүй орхисон байна.

Багш: Сайн байна. Чамд их баярлалаа.

### ЗАРИМ УХАГДАХУУНУУДЫГ ОЙЛГОХОД ХУВИЙН ТУРШЛАГАА АШИГЛАХ НЬ: “ТӨВИЙГ САХИХ” БА “ШУДАРГА” ЗАРЧМУУД

ЭНЭ ХИЧЭЭЛ ДЭЭР ХЭЦҮҮ УХАГДАХУУНУУДЫГ ОЙЛГУУЛАХЫН ТУЛД БАГШ СУРАГЧДЫН ХУВИЙН ТУРШЛАГЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ТАЛААР ХЭДЭН АРГЫГ АЖИГЛАХ БОЛНО.

Багш: Бүгдээрээ сайн байцгаанаа уу?

Ангийнхан: Сайн. Сайн байна уу?

Багш: Өнөө өглөө та нар сайн байцгаанаа уу?

Ангийнхан. Сайн...

Багш: Өнөөдөр бид “төвийг сахих”, “шударга” зарчим гэсэн хоёр шинэ нэр томъёог авч үзнэ. Энэ хоёрыг та нар юу гэж ойлгож байна. За “төвийг сахих”-аас эхэльье. Ялгаж ойлгоход хэцүү ч гэсэн цөмөөрөө оролдоцгоо. “Төвийг сахих” гэдгийг та нар юу гэж ойлгож байна вэ? За Мандиссаг сонсоцгоо.

Охин: Миний бодлоор “төвийг сахих” гэдэг нь хэн нэгний талд орохгүй байх, жишээ нь, хоёр найз чинь зодолдож байхад дэргэд нь байгаад тэдний өмнөөс шийдвэр гаргах ёстой боллоо гэж үзье. Энэ үед хэнийх нь ч талд оролгүйгээр, аль алийг нь ялгалгүйгээр...

Багш: Тэгэхээр хэнийх нь ч тал орохгүй байх нээ?

Охин: Тийм.

Багш: “Төвийг сахих” гэдэг нь хэн нэгний талд орохгүй гэдэгтэй холбоотой байх нь. Та нар санал нэгтэй байна уу?

## Дүрс бичлэгийн тайлбар

Багш: Та нар бүгд санал нэг байна уу? Өөрөөр бодож байгаа хүн байж магадгүй шүү дээ? “Төвийг сахих” гэдгийг та нар юу гэж ойлгож байна вэ? Аль нэг талд орохгүй байх гэдэг дээр та нар санал нэгтэй байх шиг байна. Одоо “шударга” байх гэдэг ойлголтыг авч үзье. “Төвийг сахиж” байна гэдэг нь ерөөсөө туслахгүй гэсэн үг үү?

Хөвгүүн: Үгүй.

Багш: “Төвийг сахих” гэдэг нь хулчгар байхтай адилхан уу? Чи хулчгар. Тийм болохоор хэн нэгний талд орохгүй байна. Энэ нь ямар нэгэн байдлаар хулчгар занг харуулж байна уу?

Охин: Би үүнтэй санал нийлэхгүй байна. Яагаад гэвэл эдгээр хүмүүс амьтанд биш хүмүүст тусалж байна. Хүнд тусална гэдэг нь аль нэг талд орж байгаа хэрэг отгхон ч биш.

Багш: Бие биендээ тусалж байгаа.

Охин: Хүнд тусалж байгаа үед аль талыг нь сонгож байгаа нь чухал биш боловч аль нэг талыг сонгосноор өөр хүмүүс хохирч болох учир бүгдийг нь адилхан дэмжих нь дээр гэж бодож байна.

Багш: Бүгдийг адилхан дэмжих хэрэгтэй...

Хөвгүүн: Хулчараас болж байна гэдэгтэй санал нийлэхгүй байна. Жишээлбэл, найз чинь хэн нэгэнтэй зодолдож байхад та хэнийх нь ч талд орохгүй байна гэдэг нь хулчгар байна гэсэн үг биш. Хэрвээ хулчгар байсан бол найзынхаа талд орох байсан, яагаад гэвэл дараа нь найз чинь чи яагаад намайг хамгаалаагүй юм бэ гэж уурлах болно шүү дээ...

Багш: Та нар тэгэхээр хүн болгонд туслахыг хүсч байна аа даа.

Охин: “Төвийг сахих” нь хулчгар байдалтай ямар ч холбоогүй. Өмнө хэлснээр хүмүүнлэгийн ажилтнууд бусдад, битгий тусласай гэж бодож байгаа сөрөг талуудад ч тусалдаг. Энэ нь тэднийг хулчгар биш гэдгийг харуулж байна. Учир нь хоёуланд нь тусалж байгаад буюу өөрөөр хэлбэл дайсанд нь бас тусалж байгаад, уурласан аль нэг тал тэдгээр хүмүүнлэгийн ажилтнуудыг алах магадлал бий. Тэд нар яагаад хоёуланд нь тусалж байна вэ? Ингэснээр тэд амь насаа эрсдэлд оруулж байгаа учраас хулчгар хүмүүс биш юм.

### “ТӨВИЙГ САХИХ” БОЛОН “ШУДАРГА” БАЙХТАЙ ХОЛБООТОЙ ХУВИЙН ТУРШЛАГААСАА БИЧИХИЙГ СУРАГЧДААС ХҮСЭВ.

Багш: За. Нэгэн өгүүлэл уншья. “Эгч бид хоёрт сургуульд өмсөх гутал хэрэгтэй байлаа. Бидэнд сургуулийн шинэ дүрэмт хувцсыг үзүүлэхэд надад маш их таалагдсан. Ээж маань эхлээд эгчид гутал авч өгөхөөр шийдсэн бөгөөд харин би гутал, дүрэмт хувцас хоёрын аль нэгийг сонгох хэрэгтэй болсон юм. Эгч гуталтай болж би гэдэг хүн аль ч угүй хоцров. Эхлээд би ээж эгчийн талд орж байна гэж бодсон боловч эцэстээ эгчид гутал маш их хэрэгтэй байсныг ойлгосон. Харин гутал, дүрэмт хувцасны аль аль нь надад, эгчид гутал хэрэгтэй байгаа шиг хэрэгтэй байгаагүй. Дараа нь миний хүссэн зүйлийг авч өгсөн учраас шударга, төвийг сахисан нөхцөл байдал байсан юм байна гэдгийг би мэдэрсэн юм.”

Багш: Энэ өгүүлэлд “шударга” байх чанар юун дээр ажиглагдаж байна вэ? Хэнд нь гутал онцгой хэрэгцээтэй байсан бэ? Эгч, ээж юу хийсэн бэ?

Анги: Эгчид нь түрүүлж гутал худалдаж авч өгсөн.

Багш: Эгчид нь гутал онцгой хэрэгцээтэй байсан учраас ээж нь эгчид нь гутал худалдаж авсан.

Багш: Өөр нэг өгүүлэл уншья. ”Ээж маань эгч дүү нартайгаа ам зөрөхөд манай эгч нар ихэвчлэн ээжийн талд ордог. Учир нь тэд нар ээжийг үргэлж зовоодог. Харин би хэний ч талд оролгүй урьдных шиггэ л үеэлпүүдтэйгээ тоглож наадсан хэвзэрээ байдаг байлаа. Ээжийн гэр бүлийнхэн... ” Энэ юу гээд байна аа? Би уншиж чадахгүй байна... “Ээжийн гэр бүлийнхний, эсвэл ээжийн буруу байгааг би мэдэж байсан ч аль алинтай нь адилхан ярьж харьцаг байсан. Үүнийг манай аав, эгч, дүү нар ойлгодоггүй ч, би ойлгодог. Төвийг сахиж болохоор байтал заавал яагаад хэн нэгнийх нь талд орох ёстой гэж. Манай ээж өөрийнх нь талд орсонгүй гэж ерөөсөө уурладаггүй байсан.” Энэ өгүүлэлд “шударга” байх тухай биш харин “төвийг сахих” тухай өгүүлсэн байна.

Багш: Энд ”төвийг сахих” тухай хэрхэн өгүүлэгдэж байна вэ?

## ТЭМДЭГЛЭЛ

## ТЭМДЭГЛЭЛ

## ТЭМДЭГЛЭЛ

# ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙГ СУДЛАХ НЬ



► Тайлбар толь



ICRC

# **“ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙГ СУДЛАХ НЬ” БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР**

*/Ойлголт, нэр томъёоны тайлбар толь/*

Улаанбаатар 2007

Хүмүүнлэгийн эрх зүйг судлах явцад мэргэжлийн ойлголт, үг хэллэг, нэр томъёо цөөнгүй тохиолдоно. Жишээлбэл, "Хүмүүнлэгийн үйлс" гэдэг нэр томъёо нь бидний ердийн ойлгож байгаагаас илүү нарийн, мэргэжлийн ойлголт юм. Нөгөөтэйгүүр, мэргэжлийн ойлголт бүхий доорх үг хэллэг, нэр томъёо нь бидний өдөр тутмын амьдралд өргөн утгаар хэрэглэгдэгийг уншигч авхай та юуны түрүүн сайтар ойлгож авах хэрэгтэй.

**Албадан хэрэглэх, сахиулах, хууль эрх зүйг ~ (enforcement)** – дайны гэмт хэрэгт холбогдсон этгээдийг хууль ёсны дагуу шүүх. ОУХЭЗ нь хууль зөрчигчийн иргэншил, хаана хууль зөрчсөн эсэхээс үл хамааран уг хуулийг ноцтой зөрчигчдийг илрүүлж, шийтгэхийг улс орнуудаас шаарддаг.

**Байлдаанд оролцоо оргүй болсон этгээд (hors de combat)** – олзлогдсон, шархадсан, өвчтэй, эсвэл хөлөг онгоц нь сүйрэлд өртсөний улмаас дахин байлдах боломжгүй болсон байлдагч

**Байлдагч (combatant)** - зэвсэгт мөргөлдөөнд оролцож байгаа тухайн улсын болон бусад талын зэвсэглэсэн байлдагч буюу байлдаанд шууд оролцогч

**Байлдагч бус хүн (non-combatant)** – тулалдаанд оролцоогүй буюу цаашид оролцохгүй хүмүүс

**Газрын мина (landmines)** – хүн, амьтан, эсвэл тээврийн хэрэгсэл тухайн газар ойрхон байх буюу биеэр хүрэх үед дэлбэрэх зориулалттай, улмаар хүнийг хөдөлмөрийн чадваргүй болгох, бэртээх, амь насыг нь хөнөөх, тээврийн хэрэгслийг эвдлэх чадвартай зэвсэг

**Геноцид, төрлөөр устгах (genocide)** – үндэс, угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, соёл нэгтэй бүлэг хүмүүсийг санаатайгаар болон зохион байгуулалттайгаар устгах зорилгоор үйлдсэн бусдын амь насыг бусниулах; гэмтэл учруулах; амьдрал, ахуйн нөхцлийг доройтуулах; бүлгийн дотор төрөлт зогсооход чиглэгдсэн арга хэмжээ авах; хүүхдүүдийг нэг бүлгээс нөгөөд хүчээр шилжүүлэх үйлдэл

**Гинжин нөлөө (хууль зүйн бус нэр томъёо) (chain reaction (non-legal))** – дараа дараагийнхдаа үргэлжлэн нөлөө үзүүлэх цуврал үйл явц

**Дагаж мөрдөх [сахин биелүүлэх] (compliance [adherence])** – улс орон болон байгууллага нь нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг сахин биелүүлэх үйл ажиллагаа

**Дагалдах хохирол (collateral damage)** – энгийн иргэд амь насаа алдах, бэртэх, эд зүйлсийн хохирол амсахаас хамгаалах, түүнчлэн хохирлыг аль болох багасгах урьдчилсан арга хэмжээ авсан хэдий ч үйлдсэн довтолгооноос тохиолдлоор үүссэн гарз хохирол

**Дайны гэмт хэрэг (war crime)** – ОУХЭЗ-г ноцтойгоор зөрчих хэлбэрүүд. Тухайлбал, санаатайгаар хүний амь хөнөөх, эрүүдэн шүүх ба хүний ёсноос гажууд харьцах, зориуд зовлон шаналалд учруулах, хүний эрүүл мэнд ба бие махбодийн бүрэн бүтэн байдалд ноцтойгоор аюул учруулах, энгийн иргэд рүү халдан довтлох, хүн амын бүлгүүдийг цөлөх, хууль бусаар нүүлгэн шилжүүлэх, хуулиар хориотой зэвсэг хэрэглэх ба цэрэг дайны хориотой арга (химийн, бактериологийн, галдан шатаах зэвсгүүд г.м.) хэрэглэх, нийтийн болон хувийн өмчийг тонох зэрэг багтана.

**Дилемма, ёс зүйн ~ (хууль зүйн бус нэр томъёо) (dilemma, ethical ~ (non-legal))** – аливаа эрхэм зорилгын эрмэлзэл нь өөр эрхэм зорилготой харшилдах, эсвэл хор уршигт болон эерэг үр дүнд хүргэх нөхцөл байдал

**Долгионт үр нөлөө (хууль зүйн бус нэр томъёо) (ripple effect (non-legal))** - усанд чулуу хаяхад долгионт хүрээ үүсдэг шиг дан ганц үйлдэл, үйл ажиллагаа хүрээгээ өргөтгөн тархаж, илүү өргөн үр нөлөө үзүүлэх гэсэн ухагдахуун

**Дотооддоо шилжин нүүсэн хүмүүс (internally displaced persons)** – мөрдөж мөшгүүлэхээс эмээсний улмаас, мөн байгалийн буюу байгалийн бус гамшиг, хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл болон зэвсэгт мөргөлдөөний үр дагавраас зайлсхийхийн тулд орон гэрээсээ нүүсэн боловч улс орноосоо гараагүй хүмүүс

**Дотоодын мөргөлдоон (internal conflict)** – тухайн улсын нутаг дэвсгэр дээрх засгийн газар ба үймээн дэгдээгч бүлэглэл хоорондын, эсвэл зэвсэгт бүлэглэл өөр хоорондын зэвсэгт мөргөлдөөн (“олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн”-ийг үзнэ үү)

**Дотоодын үймээн (internal disturbances)** – зэвсэгт мөргөлдөөнийг үүсгэхгүй, хүчирхийлсэн үйлдлээс үүсэлтэй дотоодын хэв журмыг зөрчсөн ноцтой үймээн самуун (тухайлбал, эрх мэдлийн сөргөлдөөн буюу намын бүлгүүдийн хоорондын тэмцэлдээн, нийтийн эмх замбараагүй байдал гэх мэт)

**Дүрвэгч (refugee)** - тухайн нийгмийн хэв журамд ноцтой саад учруулах дайн, аливаа үйл явдал болон мөрдөж мөшгүүлэхээс эмээсний улмаас өөрийн гэртээ амьдрах боломжгүй болж, эх орноосоо өөр улсад дүрвэж гарахаар оролдож буй этгээд. Зарим дүрвэгсэд очсон улсдаа тусгай статустай болох эрхтэй байдаг. Ийм статус шаардах нөхцлүүдийг 1951 оны Дүрвэгсийн Статусын тухай Конвенцид заасан байдаг.

**Женевийн Конвенц (Geneva Conventions)** – 1949 онд Женевт гарын үсэг зурж баталгаажуулсан орчин үеийн ОУХЭЗ-н суурь баримт бичиг. Гол агуулга нь:

- I. Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөн
- II. Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгсөд
- III. Цэргийн олзлогдогчид
- IV. Энгийн иргэд

**Женевийн конвенцийн нийтлэг 3 дугаар зүйл (Article 3 common to the Geneva Conventions)** – Энэ нь Женевийн 4 конвенцид адил тусгагдсан нийтлэг зүйл бөгөөд олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгдэнэ. Мөн Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүйн (ОУХЭЗ) үндсэн зарчмуудыг багтааснаараа онцлогтой тул дор бүрэн эхээр нь нийтлэв.

### 3 ДУГААР ЗҮЙЛ

*Хэлэлцэн тохиrogч эрхэм дээд талуудын аль нэгний нь нутаг дэвсгэрт үүсэх олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн үүссэн тохиолдолд, тухайн мөргөлдөөнөнд оролцогч тал бүр дараахь заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ:*

*(1) Дайтаж ажиллагаанд шууд оролцоогүй этгээд, түүний дотор байлдахаа зогсоосон болон өвчлөх, шархдах, саатуулгадах буюу аливаа бусад шалтгааны улмаас байлдаанд биеэр оролцоогүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний этгээдтэй*

арыс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гарал үүсэл, эд хөрөнгийн байдал болон бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялагварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөл байдалд хүнлэг харьцаана.

Энэ үүднээс доорхи үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хориглоно:

- (a) амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хунд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;
- (b) барьцаанд авах;
- (c) хуний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;
- (d) соёл иргэнишилт ард түмний зайлигүй гэж хүлээн зөвшөөрсөн шүүхийн бүх баталгаагаар хангаж байнгын ажиллагаатай шүүхээс урьдчилан гаргасан шийдвэрлгүйгээр ял оноох болон ял эдлүүлэх.

(2) Өвчтөн, шархтанг олж тусламж үзүүлнэ.

Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хараат бус хүмүүнлэгийн байгууллага мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд тусгай хэлэлцээрийн замаар конвенцийн бусад заалтыг бүгдийг буюу хэсэгчлэн хүчин төгөлдөр болгохыг цаашид чармайна.

Оmnөх заалтуудыг хэрэглэх нь мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хөндөхгүй.

**Зэвсэгт мөргөлдөөн (armed conflict)** – олон улсын болон дотоодын хоёр ба түүнээс дээш зохион байгуулалттай бүлгүүдийн хоорондын зэвсэгт мөргөлдөөн

**Иргэний объект (civilian object)** – цэргийн бус бүх объект

**Итгэл эвдэх (perfidy)** – итгэлийг нь хөсөрдүүлэх зорилгоор дайснаа хамгаалалтанд орох эрхтэй, эсвэл өөрөө хамгаалалтаар хангах ёстой гэсэн итгэл үнэмшил төрүүлэх

**Мартенсын Хууль (Martens Clause)** – 1899 оноос эхлэн олон тооны ОУХЭЗ-н гэрээнд багтсаар ирсэн энгийн иргэд ба байлдагчдад ерөнхий хамгаалалтыг олгодог хуулийн заалт. Дор бүрэн эхээр нь иш татав.

Олон улсын хуулийн бичмэл эрх зүйн хэм хэмжсээнд тусгагдаагүй тохиолдолд ч, энгийн иргэд ба байлдагчид нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн заншил, хүмүүнлэгийн зарчмууд болон нийтийн ухамсын ноёрхолоос үүдэлтэй олон улсын хуулийн зарчмын эрх мэдэл, хамгаалалд байх эрхтэй.

**Мөргөлдөөнд оролцогч талууд (parties to a conflict)** – засгийн газар, сөргөлдөгч хүчинүүд зэрэг тухайн засгийн газар эсвэл улсын зүгээс албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байлдаанд оролцогч талууд

**Нийгмийн дарамт (хууль зүйн бус нэр томъёо) (social pressure (non-legal))** – тухайн хувь хүний зан үйлд ямар нэгэн хэлбэрээр нийгэм, гэр бүл, найз нөхөд болон бусад хүмүүсээс үзүүлж буй нөлөө

**Олон улсын заншилийн эрх зүй (customary international law)** - үндэстэн хоорондын ерөнхий зөвшилцөл, тогтсон практикаар тодорхойлогдох бичмэл бус дүрэм журам

**Олон улсын зэвсэгт мөргөлдөөн (international armed conflict)** – хоёр буюу түүнээс дээш улс орны зэвсэгт хүчин хоорондын мөргөлдөөн. НҮБ-аас хүлээн зөвшөөрснөөр үндэстний чөлөөлөх дайн нь олон улсын зэвсэгт мөргөлдөөний ангилалд багтдаг.

**Олон Улсын Улаан Загалмай Хороо (ОУУЗХ) (International Committee of the Red Cross (ICRC))** – дайн болон дотоодын хүчирхийллийн үед хохирогчдод тусlamж үзүүлэх, тэдний амь нас, нэр хүндийг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулдаг шударга, төвийг сахисан, бие даасан хүмүүнлэгийн байгууллага. ОУУЗХ нь аливаа мөргөлдөөний үед олон улсын тусlamжийн үйл ажиллагааг удирдан зохицуулдаг. Мөн хүмүүнлэгийн эрх зүй болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүнлэгийн зарчмыг түгээн дэлгэрүүлэх, бэхжүүлэх, мөн учрах хохирлыг урьдчилан сэргийлж ажиллах зорилготой.

**Олон Улсын Хүмүүнлэгийн Эрх Зүй (ОУХЭЗ) (international humanitarian law (IHL))** – зэвсэгт мөргөлдөөнд оролцоогүй болон цаашид дайтах боломжгүй болсон хүмүүсийг хамгаалах, дайнд хэрэглэгдэх арга, хэрэгслийг хязгаарлах тухай эрх зүйн хэм хэмжээний цогц- өөрөөр хэлбэл, дайны хууль ч гэдэг.

**Олон Улсын Эрүүгийн Шүүх (ОУЭШ) (International Criminal Court (ICC))** – геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон түрэмгий үйлдэл зэрэг олон улсын хуулийг ноцтой зөрчигчдийг мөрдөн байцааж, ял ногдуулах олон улсын байнгын шүүх юм. ОУЭШ нь 1998 онд Ром хотноо хуралдсан олон улсын хурлын хэлэлцээрт 60 улс нэгдэн орсноор үүсэн байгуулагдсан.

**Онцгой нөхцөл байдал (хууль зүйн бус нэр томъёо) (emergency (non-legal))** – хүмүүнлэгийн ажлын явцад байгалийн гамшиг буюу зэвсэгт мөргөлдөөний аюулд өртөж болзошгүй энгийн иргэд, хүмүүсийн өмнө тулгарсан эн тэргүүний хэрэгцээг хангах шаардлага гардаг. Зэвсэгт мөргөлдөөн, дотоодын үймээний үед ОУУЗХ, байгалийн гамшигийн үед Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэгүүдийн Холбоо хөндлөнгөөс оролцно.

**Оттавагийн Гэрээ (Ottawa Treaty)** – албан ёсоор “Хүний эсрэг минийн хэрэглээ, хадгалалт, нөөцлөлт, үйлдвэрлэлт ба дамжуулалт, устгахыг хориглох тухай Конвенц” гэж нэрлэгддэг, хүний эсрэг мина хэрэглэх, хадгалах, нөөцлөх, үйлдвэрлэх ба дамжуулахыг хуулиар хориглох тухай заасан, 1997 онд Канадын Оттавад хийсэн гэрээ

**Өршөөл (amnesty)** – энгийн товч хэлбэл, хууль зөрчигчдөд хуульд зааснаар үзүүлэх училалт. Мэргэжлийн ойлголтоор хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ял шийтгүүлсэн этгээдийг ялаас чөлөөлөх талаар тогтоосон эрх зүйн акт

**Өршөөл үзүүлэхээс татгалзах (quarter, to refuse to grant)** – бууж өгсөн буюу өөрийгөө хамгаалах чадваргүй болсон хүмүүсийн амь насыг зөнд нь хаяхаас татгалзах гэх мэт хууль бус үйлдэл

**Пропорциональ байдал (proportionality)** – цэргийн объект руу довтолсны үр дүнгээс урьдчилан харсан цэргийн давуу тал нь энгийн иргээдийн амь нас, объектод учруулсан хохиролтой харьцуулахад хэтэрсэн байж болохгүй гэсэн зарчим

**Ноцтой зөрчил (grave breaches)** – ОУХЭЗ-н хамгийн ноцтой зөрчлүүд. Дараах үйлдлийг Женевийн Конвенцийн дагуу ноцтой зөрчил гэж үзнэ:

- ▲ Санаатайгаар хүний амь насыг хороох
- ▲ Эрүүдэн шүүх буюу биологийн туршилтыг оролцуулан хүнлэг бусаар харьцах
- ▲ Цэргийн зайлшгүй шаардлагаар хүлээн зөвшөөрөгдөөгүй байдлаар, хууль бусаар болон үндэслэлгүйгээр хүний бие махбодь, эрүүл мэндэд хүнд гэмтэл, ноцтой хохирол санаатайгаар учруулах, бэртээж гэмтээх, өмч хөрөнгийг сүйтгэх, ашиглан завших
- ▲ Дайнд олзлогдогчийг дайсагнагч хүчний эгнээнд алба хаахыг шаардах
- ▲ Гуравдугаар Конвенцид дурдсан шударга болон ердийн шүүхэд хандах дайнд олзлогдогчийн эрхийг санаатайгаар хасах
- ▲ Хууль бусаар цөлөх, нүүлгэн шилжүүлэх буюу эрх нь хамгаалагдсан этгээдийг хууль бусаар хорих, дайсагнагч хүчний эгнээнд алба хаахыг шаардах
- ▲ Эрх нь хамгаалагдсан хүмүүсийн Конвенцид заасан шударга болон ердийн шүүхэд хандах эрхийг санаатайгаар хасах
- ▲ Барьцаанд авах

Дээрх жагсаалтыг Нэмэлт 1 дүгээр Протоколоор өргөтгөж, дараах зүйлсийг нэмэн оруулжээ:

- ▲ Энгийн иргэд, хувь хүн рүү дайрах
- ▲ Энгийн иргэд, тэдний объект руу ялгаварлалгүйгээр халдах
- ▲ Аюултай зүйл агуулж буй объект руу дайрах
- ▲ Хамгаалалтгүй нэгж ба цэрэгжилтгүй бүс рүү дайрах
- ▲ Улаан Загалмай, Улаан Хавирган Сар эмблемийг зүй зохисгүйгээр ашиглах
- ▲ Цэргийн олзлогдогчийг эх орон луу нь буцаах үйл ажиллагааг удаашруулах
- ▲ Апартейд (арыс үндсээр ялгаварлан тусгаарлах) болон бусад доромжилсон үйлдэл
- ▲ Түүхийн, урлагийн болон шашны хөшөө дурсгал руу халдах

**Нууцлал (confidentiality)** – аливааг нууцлах чадвар. Нууцлал нь Олон Улсын Улаан Загалмайн Хороо (ОУУЗХ)-ны ажлын арга зүйн стандарт юм. Энэ нь эрх мэдэл бүхий байгууллагуудтай үр дүнтэй тохиролцсоноор хохирогчдод хүрэх боломж олгох болон тэднийг хамгаалахад үйлчилнэ. ОУУЗХ нь хувь хүний нууцыг илчлэхгүй байх үнэмлэхүй эрхтэй хэмээн жишиг эрх зүйд заасан байдаг. Тиймээс ОУУЗХ-ны ажилтан хэрэв Хорооноос тусгай эрх мэдэл олгоогүй л бол үйл ажиллагааны хүрээнд ямар нэгэн асуудлаар аль нэгэн шүүхийн өмнө мэдүүлэг өгөх ёсгүй. (хуучин Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх, Симичийн хэрэг, 1999 оны 7 дугаар сарын 27)

**Нэгдэж орох (олон улсын гэрээнд) (accession)** – тухайн улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох үйл явц

**Нэмэлт протоколууд (additional protocols)** – олон улсын хууль ба гэрээний бүрэлдэхүүн хэсэг. Тухайлбал, 1949 оны Женевийн эх конвенц нь 1977 оны хоёр нэмэлт протоколоос бүрддэг.

**Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн (non-international armed conflict)** – тухайн улсын нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа ердийн зэвсэгт хүчин ба тодорхой зэвсэгт бүлэглэл хоорондын, эсвэл өөр хоорондоо дайтаж буй зэвсэгт бүлэглэлүүдийн хоорондын мөргөлдөөн; дотоодын мөргөлдөөн буюу иргэний дайн ч гэж нэрлэдэг.

**Руандагийн Олон Улсын Эрүүгийн Шүүх (РОУЭШ) (International Criminal Tribunal for Rwanda (ICTR))** – 1994 оны 1 дүгээр сарын 1-нээс 1994 оны 12 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд Руанда улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн болон тус улсын иргэд хөрш орнуудын нутаг дэвсгэрт үйлдсэн дайны гэмт хэрэг, геноцид ба хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хариуцлагатай этгээдүүдийг яллах зорилгоор НҮБ-аас 1995 онд байгуулсан шүүх

**Саатуулагдсан этгээд (detainee)** – зэвсэгт мөргөлдөөний үеэр яллагдсан болон широнд хоригдсон энгийн иргэн

**Соёрхон батлах (ratification)** – тухайн засгийн газар, байгууллага улс хоорондын гэрээ ба олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсноо гарын үсэг зурсны дараа албан ёсоор тунхаглах үйл явц

**Төвийг сахих (төвч) үзэл (neutrality)** – зөрчилдөгч талуудын аль нэгнийх нь талд орохгүй байх

**Үл ялгаварлан хийгдэх довтлогоо (indiscriminate attacks)** – цэргийн объект, энгийн иргэд буюу тэдний объект руу дайрах зэргээр объект ялгахгүйгээр хийгдэх довтлогоо

**Үл ялгаварлах зэвсэг (indiscriminate weapon)** - энгийн иргэд болон тэдний объект, мөн түүнчлэн байлдагчид болон цэргийн объектийг ялгахгүйгээр устгадаг, цэргийн ажиллагаа дууссан хэдий ч үргэлжлүүлэн хүний амь нас бусниулдаг зэвсэг

**Үндэстний чөлөөлөх дайн (war of national liberation)** – ард иргэдийн колоничлол, гадаадын түрэмгийлэн эзлэлт ба арьс өнгөөр ялгаварлах дэглэмийн эсрэг зэвсэгт тэмцэл. ОУХЭЗ-н дагуу үндэстний чөлөөлөх дайн нь (НҮБ-аар хүлээн зөвшөөрөгдсөн) олон улсын зэвсэгт мөргөлдөөн юм.

**“Үндэстэн угсаатны цэвэрлэгээ” (“ethnic cleansing”)** – аль нэгэн үндэстэн угсаатныг өөр үндэстэн угсаатны эрх мэдэл, бодьгал онцлогийг таниулахын тулд хүч хэрэглэн нүүлгэн шилжүүлэх буюу үндсээр нь устгах

**Үр дагавар (consequence)** – үйл хөдлөл буюу зан үйлээс үүдэлтэй нөхцөл байдал.

**Хагас цэрэгжсэн (paramilitary)** – зэвсэгт хүчин, цагдаагийн албан ёсны харьялалтай биш боловч цэргийн үйл ажиллагаанд албан ёсны буюу албан бус засгийн газрын дэмжлэгтэйгээр оролцдог цэргийн нэгж

**Хохирогчид (victims)** – зэвсэгт мөргөлдөөний улмаас зовлон шаналал амсч буй хүмүүс

**Хөндлөнгөөс ажиглагч (bystander)** - тухайн үйл явдалд оролцоогүй боловч бусдын амь нас, нэр хүндэд аюул учирсан үед байлцсан этгээд. Хөндлөнгөөс ажиглагч нь тухайн үйл явдалд шууд буюу шууд бусаар оролцох эсэхээ өөрөө шийдвэрлэнэ.

**Хууль, төрөлжсөн ~ (code)** – төрөлжүүлэн нэгтгэсэн хууль, бичмэл болон бичмэл бус хэлбэртэй байж болно.

**Хуучин Югославын Олон Улсын Эрүүгийн Шүүх (ЮОУЭШ) (International Criminal Tribunal for the former Yugoslavia (ICTY))** – 1991 оноос хойш хуучин Югослав улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн дайны гэмт хэрэг, геноцид ба хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хариуцлагатай этгээдүүдийг яллах зорилгоор НҮБ-аас 1993 онд байгуулсан шүүх

**Хүмүүнлэгийн үйлс (хууль зүйн бус нэр томъёо) (humanitarian act (non-legal))** – ихэвчлэн ердийн нөхцөлд хамгаалагдаад байдаггүй хувь хүний амь нас, нэр хүндийг хамгаалахаар хийгдэж буй эрсдэл, гарз хохирол дагалдах магадлал ихтэй үйлдэл

**Хүний нэр хүнд (хууль зүйн бус нэр томъёо) (human dignity (non-legal))** – аливаа хүний хэн гэдгээс нь, мөн түүнчлэн үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, нийгмийн анги бүлэг, улс төрийн үзэл бодол болон хувийн онцлог шинж чанар зэргээс үл хамаарсан хувь хүний үнэ цэнэ ба нэр төр

**Хүний эрхийн хууль (human rights law)** – хүний нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн, ялангуяа дур зоргоороо авирласан төрийн эсрэг зэрэг аль ч үед хэрэглэгдэх эрх зүйн хэм хэмжээний цогц

**Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг (crimes against humanity)** – алан хядлага, боолчлол, цөллөг, шоронд хорих болон эрүү шүүлт тулгах зэргээр гэм буруугүй иргэд, хүн амын эсрэг зохион байгуулалттайгаар үйлдсэн гэмт хэрэг. Энэхүү гэмт хэргийг Нюрнбергийн шүүхийн дүрэм, Югославын (хуучнаар) Олон Улсын Эрүүгийн Шүүхийн статут, Руандагийн Олон Улсын Эрүүгийн Шүүх болон Олон Улсын Эрүүгийн Шүүхээс хоорондоо бага зэрэг ялгагдахаар тодорхойлдог.

**Хүүхэд (child)** – Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн тухай 1989 оны конвенцид тодорхойлсноор хүүхэд гэдэг нь “насыг нь тухайн улсын хуулинд түүнээс доош гэж заагаагүй бол арван найман нас хүрээгүй хүн”

**Хүчин төгөлдөр болох (entry into force)** – гэрээ хэлэлцээр нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр болж эхлэх үе

**Хэлэлцэн Тохирогч Эрхэм Дээд Тал, Дээд Түвшинд Гэрээ Байгуулагч (High Contracting Party)** - Конвенцийг соёрхон баталсан улс орон

**Хэрэгцээгүй зовлон, шаналал (unnecessary suffering)** – цэргийн зорилгод хүрэхэд шаардлагагүй сэтгэлийн болон биеийн зовлон, шаналал (өөрөөр хэлбэл, түүнээс илүү зовлонгоос сэргийлэхийн тулд хэрэгцээгүй зовлон). Хэрэгцээгүй зовлон шаналлын талаар нарийн тодорхойлолт байхгүй боловч, үүнтэй хамтатган хэтрүүлсэн гэмтлийг ОУХЭЗ нь хуулиас гадуур гэж үздэг.

#### **Хэсэгчлэн хүчингүй болгох (derogate)**

**Цэргийн объект (military objectives)** – байгаа байдал, байршил, зориулалт, хэрэглээгээрээ цэргийн үйл ажиллагаанд үр ашигтай хувь нэмэр оруулах төдийгүй устгагдсанаар эсрэг талд цэргийн тодорхой давуу тал бий болгох объект

**Цэргийн олзлогдол, хоригдол (prisoner of war)** – олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед олзлогдсон байлдагч. Зөвхөн тодорхой болзол хангасан байлдагчид, ихэвчлэн зэвсэгт хүчний гишүүд үүнд хамаарна.

**Цэргийн зайлшгүй шаардлага, хэрэгцээ (military necessity)** – дайны үед хүн хүчний, материаллаг ба санхүүгийн хамгийн бага хохиролтойгоор дайснаа аль болох түргэн хугацаанд бүрэн эрхшээлдээ оруулах нь дайны зорилго бөгөөд энэхүү зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай дайтагч талуудын хүчний хэрэглээ нь зөвтгөж болохуйц хэм хэмжээнд байх гэсэн ойлголт

**Шилжин нүүсэн этгээд (displaced person)** [дотооддоо шилжин нүүсэн хүмүүс гэдгийг үзнэ үү]

**Шударга байдал (хууль зүйн бус нэр томъёо) (impartiality (non-legal))** – үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, нийгмийн анги болон улс төрийн үзэл бодлыг нь үл харгалzan зөвхөн тусламж шаардлагатай байгаа хэрэгцээнд нь үндэслэн хүмүүст үйлчилгээ үзүүлэх, тэдний тухай шийдвэр гаргах

**Энгийн иргэн (civilian)** – зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй этгээд

**Энгийн иргэн ба байлдагчийн ялгаа (distinction between civilians and combatants)** – Байлдаанд оролцогч болон оролцоогүй этгээдийг хооронд нь ялгаж үзэх нь ОУХЭЗ-н үндсэн зарчим бөгөөд

Женевийн Конвенцийн нэмэлт 1 дүгээр протоколд дурдсанаар:

*Дайтагч талууд нь энгийн иргэд ба байлдагчид, иргэний обьект ба цэргийн обьектийг ямагт ялгаж салган, өөрсдийн үйл ажиллагаагаа зөвхөн цэргийн обьектийн эсрэг явуулах ёстой.*

**Эих тайвны эсрэг гэмт хэрэг (crimes against peace)** – олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ зөрчин түрэмгий дайныг өдөөх, санаачлах, төлөвлөн эхлүүлэх зэрэг гэм буруутай үйлдэл /Нюрнбергийн шүүхийн дүрэмд ийнхүү тодорхойлсон байдаг./

**Эрх чөлөө нь (онцгой дэглэмээр) хязгаарлагдсан этгээд (internee)** – зэвсэгт мөргөлдөөний үед хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн хэмээн яллагдаагүй боловч аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээний улмаас хоригдсон энгийн иргэн ба байлдагч

**Эрэн сурвалжлах (хууль зүйн бус нэр томъёо) (tracing (non-legal))** – зэвсэгт мөргөлдөөний үеэр гэр бүл болон цэргийн анги нэгтгэлээсээ салж алга болсон (“үйл ажиллагааны явцад ор сураггүй алга болох”) хүнийг эрж хайх, тодруулах үйл явц